



I. Хувь нийлүүлсэн нийгэмлэг
/HNN/



Монгол-Оросын хувь нийлүүлсэн нийгэмлэг “Улаанбаатар төмөр зам”

Түүхэн замнал

Бүгд Найрамдах Монгол Ард Улс ба Зөвлөлтийн Засагт Нийгэм Журамт Бүгд Найрамдах Холбоот Улсын хоорондох найрамдлын харилцааг бэхжүүлэн эдийн засгийн харилцааг цаашид хөгжүүлэх зорилгоор хоёр улсын Засгийн газар хоорондын Хэлэлцээрээр Монгол Улсын нутаг дэвсгэр дээр төмөр замыг тавьж, ашиглахаар 1949 оны 6 дугаар сард Зөвлөлт-Монголын хувь нийлүүлсэн “Улаанбаатар төмөр зам” нийгэмлэгийг байгуулсан. Нийгэмлэгийн 50 хувийг Монгол Улсын Засгийн газар, 50 хувийг ОХУ-ын Засгийн газар эзэмшиж байна.

Үйл ажиллагааны чиглэл

- Ачаа, зорчигч тээвэрлэлт;
- Төмөр замын хөдлөх бүрэлдэхүүний угсралт, засвар, үйлчилгээ;
- Төмөр замын суурь бүтцийн барилга угсралт, засвар, арчилгаа;
- Төмөр зам, хиймэл төхөөрөмж, барилга байгууламжийн иж бүрэн зураг төслийн боловсруулалт;
- Бусад (барилга угсралтын бүтээц хийцийн үйлдвэрлэл, машин, механизм, тоног төхөөрөмж сэлбэгийн үйлдвэрлэл, тээвэр зууч, уулын үйлдвэрлэл, ашиглалт, онцгой байдал, сургуулийн өмнөх боловсрол, дээд боловсрол олгох, эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх)

Компанийн удирдлага

“УБТЗ” ХНН-ийн хувь нийлүүлэгч:

Монгол Улсын Зам, тээврийн хөгжлийн сайд
ОХУ-ын “РЖД” НХНН-ийн ерөнхийлөгч

“УБТЗ” ХНН-ийн Ерөнхий хороо:

Дарга: С.А. Павлов

Орлогч дарга: Ж.Бат-Эрдэнэ

Гишүүд: Б.Артур, Н.Буяндэлгэр, В.А. Токарев, А.М.

Чабунин

Нарийн бичгийн дарга: Ж.Батболд

“УБТЗ” ХНН-ийн гүйцэтгэх удирдлага:

“УБТЗ” ХНН-ийн дарга: Д.Жигжиднямаа

“УБТЗ” ХНН-ийн нэгдүгээр орлогч дарга: И.В. Милостных

Эрхэм зорилго


Дэвшилтэт технологи бүхий хөдлөх бүрэлдэхүүн, суурь бүтэц дээр тулгуурласан тээвэр-логистикийн чанартай, найдвартай, өргөн үр ашигтай, тогтвортой сүлжээг бий болгох, шуурхай үйлчилгээг хэрэглэгчдэд хүргэх

Товч танилцуулга

Улаанбаатар төмөр зам нь 16 мянга орчим ажиллагсадтай, Монгол Улсын үйлдвэрлэлийн дэд бүтцийн амин чухал бүрэлдэхүүн хэсэг юм. Монгол орны газарзүйн онцлогоос шалтгаалан далайд гарцгүй боловч өргөн уудам нутагтай, үйлдвэрлэл нь түүхий эд боловсруулалтад чиглэсэн бүтэцтэй зэргээс хамааран Улаанбаатар төмөр зам нь улсын эдийн засагт голлох үүргийг гүйцэтгэдэг. “УБТЗ” ХНН нь үйл ажиллагааны хувьд тэгш эрхийн үндсэн дээр зохицуулагддаг Монгол-Оросын хамтарсан цорын ганц байгууллага юм.

Сүүлийн 4 жилийн эдийн засгийн үзүүлэлт

Үзүүлэлт	2017	2018	2019	2020
Нийт орлого /сая.төг/	690,307.6	809,459.2	931,622.2	1,161,156.5
Нийт зардал /сая.төг/	684,216.5	805,865.9	925,936.1	1,149,906
Цэвэр ашиг /сая.төг/	6,091.1	3,593.2	5,686.1	11,250.7
Авлага /сая.төг/	15,576.7	13,511.8	11,984.2	63,606.1
Өглөг /сая.төг/	261,511.2	331,616.6	472,697.6	521,940.3
Ажиллагсдын тоо	15,139	15,458	15,923	15,859



Компанийн хөрөнгө

Монгол Улс, ОХУ-ын эзэмшлийн хувь: 50/50 хувь

Дүрмийн сан: 339.5 тэрбум төгрөг

Нийт хувьцаа: 200 ширхэг

Хувьцааны нэрлэсэн үнэ: 1.7 тэрбум төгрөг

Хэрэгжиж буй төсөл, хөтөлбөр

- “УБТЗ” ХНН-ийн 2030 он хүртэлх техникийн шинэчлэлийн хөтөлбөрийн нэгдүгээр үе шат болох “УБТЗ” ХНН-ийн төв коридорын суурь бүтцийн хэсгийг хөгжүүлэх нэн тэргүүнд хэрэгжүүлэх арга хэмжээнүүд” төсөл;
- “УБТЗ” ХНН-ийн гол замын тээх чадварыг нэмэгдүүлэх зорилго бүхий “Галт тэрэгний хөдөлгөөнийг зааглан зохицуулах системийг нэвтрүүлэх” төсөл;
- Нефть боловсруулах үйлдвэрээс Сайншанд өртөө хүртэлх 27 км суурь бүтцийн барилга угсралтын ажил;
- Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын дээд бүтцийн барилга угсралт;
- Ажиллагсдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх хөтөлбөрүүд: орон сууцжуулах хөтөлбөр, цэцэрлэгүүд ашиглалтад оруулах.

Тулгамдаж буй асуудал

- Төмөр замын суурь бүтцийн объектууд болон хөдлөх бүрэлдэхүүний парк өндөр насжилт (элэгдэл)-тэй учир галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй байдлыг ханган ажиллахад өндөр эрсдэлтэй болсон;
- Хэт бага үнэлгээтэй тогтоогдсон тээвэрлэлтийн тариф (дотоодын харилцааны нүүрс тээвэрлэлт, зорчигч тээвэрлэлт гэх мэт)-аас үүссэн алдагдлын хэмжээ жил ирэх тусам нэмэгдэж байна;
- МОНП-1, МОНП-2 зээлтэй холбоотой асуудлыг төр засгийн түвшинд шийдвэрлэх.



II. Төрийн өмчийн оролцоотой компани /Partially state-owned companies/

“МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО” ХК

Түүхэн замнал

Тус компани нь 1921 онд “Шуудан бичиг, цахилгаан мэдээний хороо” нэртэй байгуулагдаж байсан түүхтэй. 1995 онд МУЗГ-ын Өмч хувьчлалын комиссын 28 тоот тогтоол, Дэд бүтцийн Хөгжлийн сайдын 208 тоот тушаалаар хувьцаат компани болон зохион байгуулагдсан.

Үйл ажиллагааны чиглэл

- Монгол улсын нийт нутаг дэвсгэрт цахилгаан холбоо, улс хоорондын яриа, интернэт, кабелийн телевиз, мэдээллийн лавлах үйлчилгээг хэрэглэгчдэд хүргэж ажилладаг.

Компанийн удирдлага

- Төлөөлөн удирдах зөвлөл
 Дарга: Т.Лхагвасүрэн
 Гишүүд: Г.Эрдэнэбулган,
 Ж.Цогтбаяр,
 Ч.Цэвэгдорж,
 Ц.Шинэхүү,
 М.Лхагважав,
 Ц.Норовжамц,
 Ж.Тамир,
 Ю.Бат-Эрдэнэ
 Нарийн бичиг: Х.Цэцэгмаа
- Гүйцэтгэх захирал: Б.Чинбат

Хэрэглэгчийн тоо

Суурин утас

58,901

Улс хоорондын яриа 001, Easy карт, MIP 70

Интернэт

18,836

x-DSL GPON, VPN, Data Center

Кабель ТВ

15,455

Тоон КаТВ, Агаарын ОСДУ

Эрхэм зорилго


Харилцаа бүрийг холбоно.

Товч танилцуулга

2018 оны 4 дүгээр сарын 19 ний өдрөөс МЦХ ХК-ийн БНСУ-ын эзэмшлийн хувьцааг Монгол Улсын Засгийн Газар худалдан авснаар МЦХ ХК-ийн хувьцааны 94.7 хувийг Монгол Улсын Засгийн Газар эзэмшиж байна. Монголын цахилгаан холбоо ХК нь одоогоор Улаанбаатар хот түүний алслагдсан 2 дүүрэг, 21 аймаг, 280 гаруй сум сууринд үйлчилгээгээ хүргэн ажиллаж байгаа бөгөөд нийт 800 гаруй ажилтан, албан хаагчидтай.

Сүүлийн 4 жилийн эдийн засгийн үзүүлэлт

Үзүүлэлт	2017	2018	2019	2020
Нийт орлого /сая.төг/	21,866.3	21,193.8	19,673.7	19,246.8
Нийт зардал /сая.төг/	21,860.6	20,778.2	19,541.0	19,203.4
Цэвэр ашиг /сая.төг/	6.1	316.0	62.0	43.4
Авлага /сая.төг/	4,987.6	3,374.9	2,166.4	2,437.8
Өглөг /сая.төг/	6,789.4	2,839.3	7,485.5	7,241.1
Ажиллагсдын тоо	768	771	770	771



Компанийн хөрөнгө

Төрийн эзэмшлийн хувь: 94.7%-ТӨБЗГ
 Эзэмшигчийн өмч: 34,598,110.9 мян.төг
 Нийт хувьцаа: 25,870,276 ширхэг

Хэрэгжиж буй төсөл, хөтөлбөр

- АНДЦХБ-тай хамтран хэрэгжүүлж байгаа “Шинэ технологийн шилэн кабелийн туршилтын төсөл”-ийн үргэлжлэл
- E-mongolia үйлчилгээний төрийн оператор компани болох
- Интернэт, GPON, шилэн кабель зэрэг үндсэн сүлжээг өргөтгөх, OTT систем, тоон телевизийн өргөтгөл
- Програм хангамжийн хөгжүүлэлт /Web selfcare, Цахим салбар апп, ERP, Banking gateway/

Түүхэн замнал

- 1921 ОН: МУ-ын шуудан бичиг, Цахилгаан мэдээний ерөнхий хороо байгуулагдав.
- 1935 ОН: Нийслэлийн Төв Холбооны Газрын төв Шуудан Тасаг
- 1990 ОН: 1966-1990 оны хооронд Төв шуудан
- 1990 ОН: 1990.07.01-ээс Шуудан холбооны газар нэртэйгээр ажиллаж байна.
- 1994 ОН: Монгол Шуудан ТӨУҮГ-г байгуулан Дэд Бүтцийн Хөгжлийн Яамны харьяанд бие даалган ажиллуулав
- 2002 ОН: Монгол шуудан ХХК болон өөрчлөн зохион байгууллагдав
- 2009 ОН: Монгол Шуудан ТӨХК болон өөрчлөгдөн зохион байгуулагдав
- 2016 ОН: Монгол Шуудан ХК болгон өөрчлөн зохион байгуулагдан ажиллаж байна.

Компанийн удирдлага

ТУЗ-дарга: Д. Нарангэрэл /Дарга/
 Гишүүд: Д. Дондогмаа /Гишүүн/
 Э. Бат-Идэр /Гишүүн/
 О.Одбаяр /Гишүүн/
 Г. Тэлмэн /Гишүүн/
 В. Ганзориг /Гишүүн/
 Б. Ганбаатар /Гишүүн/
 Д.Балдорж /Гишүүн/
 Д. Дэлгэрмаа /Гишүүн/
 ТУЗ-ийн нарийн бичиг: Д. Цэцгээ
 Гүйцэтгэх захирал: Б. Анхбаатар

АЛСЫН ХАРАА

Өдөр бүр уулзах үндэсний шилдэг компани

Товч танилцуулга

“Монгол шуудан” ХК нь 2016 онд Монголын Хөрөнгийн Биржээр дамжуулан компанийн нийт хувьцааны 34%-ийг олон нийтэд хувьчилснаар нээлттэй компани болсон. Одоогоор Улаанбаатар хот түүний алслагдсан 2 дүүрэг, 21 аймаг, 330 гаруй сум, сууринд шуудангийн үйлчилгээгээ хүргэн ажиллаж байгаа бөгөөд нийт 980 гаруй ажилтан, албан хаагчидтай.

Сүүлийн 4 жилийн эдийн засгийн үзүүлэлт

№	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	2017 он	2018 он	2019 он	2020 он
1	Нийт орлого	Сая.төг	13,671.3	15,474.0	16,735.8	18,231.9
2	Нийт зардал	Сая.төг	12,319.7	13,731.5	15,506.6	17,602.0
3	ТТӨ ашиг	Сая.төг	1,351.6	1,742.4	1,229.2	629.9
4	ОТ-ын зардал	Сая.төг	127.4	182.2	122.9	72.0
5	Цэвэр ашиг	Сая.төг	1,224.2	1,560.3	1,106.3	557.9
6	Нийт ажиллагсад	Хүн	865	917	940	987
7	Цалингийн сан	Сая.төг	5,884.8	6,845.3	7,544.2	8,325.5
8	Нийт авлага	Сая.төг	3,533.5	6,168.1	4,847.4	2,589.8
9	Нийт өр төлбөр	Сая.төг	19,435.2	11,498.4	10,166.9	13,389.8
10	Нийт хөрөнгө оруулалт	Сая.төг	1,136.3	1,811.5	1,522.8	6,505.8
11	Ногдол ашиг	Сая.төг	367.2	468.1	331.9	167.3
12	Элэгдлийн зардал	Сая.төг	768.6	864.3	942.1	1,028.5

Компанийн хөрөнгө

Төрийн эзэмшлийн хувь: 66%
 Нийт хувьцаа: 99,586,363.ширхэг
 Нэгж хувьцааны үнэ: 1,330 төгрөг
 Зах зээлийн үнэлгээ: 132,449,862,790 төгрөг

Хэрэгжиж буй төсөл, хөтөлбөр

- Улс хоорондын мөнгөн гуйвуулгын үйлчилгээ үзүүлэх
- E-Mongolia системээр дамжуулах төрийн үйлчилгээг иргэдэд хүргэх төсөл
- Улаанбаатар хот болон аймгийн төвүүдэд логистик үйлчилгээний дэд бүтцийг байгуулах өргөжүүлэх төсөл

Тулгамдаж буй асуудал

1. Улаанбаатар хотод Логистик үйлчилгээний төв байгуулахад шаардлагатай газар байхгүй

Түүхэн замнал

“Эрдэнэс-Тавантолгой” ХК нь УИХ-ын 2010 оны 39-р тогтоол, ЗГ-ийн 2010 оны 272-р тогтоолын дагуу 2010 оны 12 дугаар сарын 23-ны өдөр байгуулагдсан.

Үйл ажиллагааны чиглэл

- Стратегийн ач холбогдол бүхий Тавантолгойн нүүрсний ордыг хуулийн дагуу эдийн засгийн эргэлтэд оруулах, ордод ашиглалтын үйл ажиллагаа явуулах, дэд бүтцийн төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх үндсэн чиглэлээр ажиллаж байна.

Компанийн удирдлага

- Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга:
Б.Бат-Эрдэнэ /ШӨХТГ/
- Гишүүд Г.Нандинжаргал /УУХҮЯ/
С.Наранцогт /СЯ/
Ц.Баяр-Эрдэнэ /ТӨБЗГ/
Т.Гантулга /МХЕГ/
Ц.Эрдэнэбаяр /АМГТГ/
Б.Ганхуяг /ЭТТ/
Ү.Амарбат /Хараат бус гишүүн/
П.Өлзийнаран /Хараат бус гишүүн/
Х.Болор-эрдэнэ /Хараат бус гишүүн/
Д.Батхшиг /Хараат бус гишүүн/
Д.Отгонтуяа /ТУЗ-ийн нарийн бичиг/
- Гүйцэтгэх захирал: Б.Ганхуяг
- Ерөнхий нягтлан бодогч: Д.Алтанцэцэг

Эрхэм зорилго

Бид сайн чанарын нүүрсний “ETT 1, 2, 3, 4” брэнд код бүхий бүтээгдэхүүн бий болгож, аюулгүй, тогтвортой, хариуцлагатай уул уурхай, аж үйлдвэрийн цогцолбор үйлдвэрлэлийг хөгжүүлэн, улс орон болон бүс нутгийн эдийн засгийн өсөлтөд бодит хувь нэмрээ оруулан, хувьцаа эзэмшигч Монгол Улсын төр, иргэн бүрт ашиг хүртээнэ.

Товч танилцуулга

“Эрдэнэс-Тавантолгой” ХК нь Монгол Улсын стратегийн ач холбогдол бүхий Тавантолгойн өндөр чанартай нүүрсний ордын ашиглалтын тусгай зөвшөөрлийн эзэмшигч төрийн өмчийн оролцоотой компани юм.

Компанийн хөрөнгө

Төрийн эзэмшлийн хувь: 81.5%
Эзэмшигчийн өмч: 13,030 тэрбум төг
Нийт хувьцаа: 12 тэрбум ширхэг
Хувьцааны нэрлэсэн үнэ: 933 төгрөг

Эдийн засгийн үзүүлэлт

Үзүүлэлт	2017	2018	2019	2020
Татвар, хураамж /тэрбум.төг/	235	479	736	459
Нийт орлого /тэрбум.төг/	1,194	2,041	2,710	1,576
Нийт зардал /тэрбум.төг/	733	1,233	1,308	1,331
Цэвэр ашиг /тэрбум.төг/	461	807	1,032	149
Авлага /тэрбум.төг/	35	50	249	34
Өглөг /тэрбум.төг/	189	168	356	2,040
Ажиллагсдын тоо	642	772	802	936

Хэрэгжиж буй төсөл, хөтөлбөр

- ❖ Компанийн урт хугацааны хөгжлийн стратеги, бодлогын хүрээнд Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн 238.5 км төмөр замын бүтээн байгуулалтад 308.9 тэрбум төгрөгийн санхүүжилт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн 414.6 км төмөр замын бүтээн байгуулалтад 357 тэрбум төгрөгийн санхүүжилт, нийгмийн хариуцлагын хүрээнд Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах зорилгоор “Тавантолгой түлш” ХХК-ийн сайжруулсан шахмал түлшний Зүүн болон Баруун бүсийн хоёр үйлдвэрийн төсөлд 208.4 тэрбум төгрөгийн санхүүжилтийг тус тус олгоод байна.

Тулгамдаж буй асуудал

1. Тавантолгойн ордод түшиглэн аж үйлдвэрийн цогцолбор байгуулахад 3.7 тэрбум ам.долларын санхүүжилт шаардлагатай. Цогцолборт нойтон болон хуурай аргаар нүүрс баяжуулах үйлдвэрүүд, коксын үйлдвэр, хими технологийн үйлдвэр, авто зам, төмөр зам, ачилтын нэгдсэн төв, суурьшлын бүтэц, 100 мянган хүнтэй хот барих ажлууд багтана.



III. Төрийн өмчит хувьцаат компани /State-owned company/



“ДУЛААНЫ ХОЁРДУГААР ЦАХИЛГААН СТАНЦ” ТӨХК

Үйл ажиллагааны чиглэл

Дулаан болон цахилгааны эрчим хүчний үйлдвэрлэл

Хэрэгжиж буй төсөл, хөтөлбөр

- ❖ ДЦС-2 –ыг 300 МВт-аар шинэчлэх ТЭЗҮ –ийг Эрчим хүчний яамны шинжлэх ухаан, технологийн зөвлөлийн 2019 оны 2-р сарын өдрийн хуралдаанаар дэмжиж баталсан.
- ❖ Эрчим хүчний сайдын өгсөн чиглэлийн дагуу “ДЦС-2” ТӨХК-ийг түшиглэн эрчим хүчний нэгдсэн системийн оргил ачааллын горим ажиллагааг тохируулах үүрэгтэй 2x50 МВт-ын хийн генератор бүхий эх үүсвэрийг байгуулах ТЭЗҮ-ийг Эрчим хүчний яамны шинжлэх ухаан, технологийн зөвлөлийн 2020 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн хуралдаанаар дэмжиж баталсан.

Цаашид дээрх хоёр ТЭЗҮ-ийг хэрэгжүүлэх, хөрөнгө оруулалтын асуудлыг шийдвэрлэхээр ажиллаж байна.

Компанийн удирдлага

- Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Р.Батрагчаа- ЭХЯ-ны газрын дарга
Гишүүд:
- 2.Н.Бэх-Очир -ЭХЯам
- 3.Б.Ариунбулган -ЭХЯ-ны мэргэжилтэн
- 4.Д.Төртүлгэ - ЭХЯ-ны мэргэжилтэн
- 5. Ц.Баяр-Эрдэнэ -ТӨБЗГ-ын хэлтсийн дарга
- 6. Т.Лхагвасүрэн-ТӨБЗГ-ын мэргэжилтэн
- Хараат бус гишүүд**
- 7.С.Батмөнх /Хараат бус гишүүн/
- 8.Ц.Норовжамц /Хараат бус гишүүн/
- 9.П.Цэрэннадмид /Хараат бус гишүүн/
- Гүйцэтгэх захирал: С.Бямбаахүү
- Тэргүүн дэд захирал бөгөөд ерөнхий инженер: Б.Мягмаржав
- Санхүү бүртгэл, эдийн засгийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч: С.Хангал-Эрдэнэ

Эрхэм зорилго

Найдвартай эрчим хүч, Шинэ технологи, Өөдрөг амьдрал

Түүхэн замнал, товч танилцуулга

ДЦС-2 нь 1961 онд БНХАУ, БНМАУ-ын засгийн газар хоорондын гэрээгээр анх 12 МВт-ын хүчин чадалтай байгуулагдаж 1969 онд 12 МВт-аар өргөтгөсөн. Монгол Улсын засгийн газрын 2001 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн 164 дүгээр тогтоолоор бие даасан ТӨХК болж өөрчлөгдөн зохион байгуулагдсан. 2012-2014 онд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 35 т/ц бүтээмжтэй шинэ зуух, турбин №2-ыг 6 МВт-ын хүчин чадал бүхий N6-3.43 маркийн турбинээр шинэчилж суурилуулах ажил хийгдсэн. Өнөөдөр 24 МВт-ын суурилагдсан хүчин чадалтай ажиллаж байна.

Компанийн хөрөнгө

Төрийн эзэмшлийн хувь: 100
Эзэмшигчийн өмч: 11,797,535.5 мян.төг
Нийт хувьцаа: 11,797,535 ширхэг
Хувьцааны нэрлэсэн үнэ: 100 төгрөг


Сүүлийн 4 жилийн эдийн засгийн үзүүлэлт

Үзүүлэлт	2017	2018	2019	2020
ЦЭХ үйлдвэрлэл /сая кВт.ц/	151.2	161.4	158.9	155.2
Түгээсэн ЦЭХ /сая кВт.ц/	130.7	140.1	138.9	136.2
Түгээсэн дулаан /мян.Гкал/	195.6	201.1	232.5	234.2
Нийт орлого /сая.төг/	21,127.6	22,542.7	24,859.9	24,445.1
Нийт зардал /сая.төг/	21,035.5	22,768.6	24,555.3	25,358.9
Цэвэр ашиг /сая.төг/	92.1	-225.9	304.6	-916.5
Авлага /сая.төг/	325.9	1,164.3	1,810.8	2,190.1
Өглөг /сая.төг/	749.4	1,804.7	1,997.6	1,976.3
Ажиллагсдын тоо	297	306	303	304

Тулгамдаж буй асуудал

1. Станцаас хэрэглэгчдийг баруун чиглэлд уураар хангах зориулалттай уурын хэрэглэгчийн шугам нь хувийн компанийн мэдэлд байдаг. Энэхүү шугамын ашиглалтын хугацаа дууссан, алдагдал ихтэй. Цаашид хэрэглэгчийн уурын шугамыг шинэ трассаар байгуулах;
2. Станцын турбингенератор №1 болон №3 ашиглалтын хугацаа бүрэн дуусаж байгаа тул эдгээр турбины ротор, туслах эд ангиудыг шинэчлэх зэрэг асуудал тулгамдаж байна.

Цэвэр ашиг /сая.төг/





“ДУЛААНЫ ГУРАВДУГААР ЦАХИЛГААН СТАНЦ” ТӨХК

Түүхэн замнал

1966 оны 12-р сарын 3-нд станцын анхны суурь тавьсан. Улмаар 1968 оны 12-р сарын 10-нд анхны зуух ашиглалтанд орж нийслэл хотын үйлдвэр, албан байгууллага, ард иргэдэд **дулааны эрчим хүч**, 1974 оны 12 дугаар сарын 1-ний өдөр анхны турбиныг ашиглалтанд оруулснаар **цахилгаан эрчим хүч** түгээж эхэлсэн.

Үйл ажиллагааны чиглэл

- Цахилгаан, дулааны эрчим хүчний үйлдвэрлэх, борлуулах.

Компанийн удирдлага

➤ **ТУЗ-дарга: Ж.Батсуурь**

Гишүүд:

- П.Энхцэлмэг- ЭХЯ-ны ахлах мэргэжилтэн
- Б.Нармандах-ЭХЯ-ны мэргэжилтэн
- Л.Мөнхцог- ЭХЯ-ны ахлах мэргэжилтэн
- Ц.Шинэхүү-ТӨБЗГ-ын мэргэжилтэн
- Л.Сэлэнгэ- ТӨБЗГ-ын ахлах мэргэжилтэн

Хараат бус гишүүд:

- Ж.Ханд-Иш /Хараат бус гишүүн/
- С.Солонго /Хараат бус гишүүн/
- Д.Цэрэндолгор /Хараат бус гишүүн/

Гүйцэтгэх захирал: **Ч.Чинбат**

Тэргүүн дэд захирал, ерөнхий инженер: **П.Болдбаатар**

Санхүү эрхэлсэн дэд захирал: **Т.Энхтөр**

Аж ахуй дэд захирал: **Д.Баянжаргал**

Эрхэм зорилго

Эх орноо хөгжилд хөтлөх эрчим хүчнийг бүтээнэ.

Товч танилцуулга


Тус станц өндөр ба дунд даралтын гэсэн 2 хэсгээс бүрддэг бөгөөд дунд даралтын станц 48 меговатт, Өндөр даралтын станц 150 меговатт нийт 198 МВт цахилгаан эрчим хүч үйлдвэрлэх суурилагдсан хүчин чадалтай. Бүтэц зохион байгуулалтын хувьд 3 алба, 7 хэлтэс, 4 хэсэг, 2 лаборатори, 10 цехээс бүрдсэн нийт 996 ажиллагсадтайгаар цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэх, борлуулах үйл ажиллагаа явуулж байна.

Компанийн хөрөнгө

Төрийн эзэмшлийн хувь: 100
Эзэмшигчийн өмч: 221 630 490.4 мян.төг
Нийт хувьцаа: 993 627 829 ширхэг
Хувьцааны нэрлэсэн үнэ: 100 төгрөг

Сүүлийн 4 жилийн эдийн засгийн үзүүлэлт

Үзүүлэлт	2017	2018	2019	2020
Боловсруулсан ЦЭХ (сая.кВтц)	1,077.7	1,085.0	1,054.3	1,050.1
ДХЦЭХ (%)	16.3	16.5	16.4	16.8
ЦЭХ-ний түгээлт (сая.кВтц)	901.9	905.5	881.0	872.9
ДЭХ-ний түгээлт (мян.Гкал)	2,163.0	2,192.7	2,214.2	2,369.3
Нийт орлого /сая.төг/	112,222.5	114,115.1	116,902.4	122,738.5
Нийт зардал /сая.төг/	110,102.8	115,154.0	119,587.4	124,807.9
Цэвэр ашиг /сая.төг/	449.5	- 1,081.5	- 2,773.0	-2,107.6
Авлага /сая.төг/	3,277.7	8,373.1	8,562.5	9,713.8
Өглөг /сая.төг/	30,119.2	32,168.9	34,060.3	30,494.2
Ажиллагсдын тоо	996.0	993.0	996.0	995



■ Нийт орлого /тэрбум төг/
■ Цэвэр ашиг, алдагдал /тэрбум.төг/

■ Нийт зардал /тэрбум төг/

Хэрэгжиж буй төсөл, хөтөлбөр

- “ДЦС-3” ТӨХК-ийн өндөр даралтын хэсгийн суурилагдсан хүчин чадлыг 75 МВт-аар нэмэгдүүлэх.
- Дулааны III цахилгаан станцын суурилагдсан хүчин чадлыг 250 МВт-аар нэмэгдүүлэх зэрэг төслүүдийг хэрэгжүүлэхээр төлөвлөн судалгаа тооцоог хийж, Монгол Улсын Засгийн газрын тогтоол гарч хэрэгжих шатандаа явж байна.

Тулгамдаж буй асуудал

- Станцын үндсэн тоноглолууд 44-52 жил ажиллаж, насжилт дууссан. Цаашид зайлшгүй шинэчлэх шаардлагатай байгаа.
- Хөрөнгө мөнгөний дутагдлаас шалтгаалан ИЗ, ТЗБАХ, ХО-ын ажлууд хугацаандаа хийгдэхгүй хойшлогдох, барилга байгууламж, тоног төхөөрөмжийн насжилт өндөр, техник технологийн шинэчлэл хийгдэхгүй удааширсан.
- ДҮТ-өөс авлага төлөгдөхгүй хойшлогдох, авлага барагдаагүйгээс шалтгаалж богино хугацаат өр төлбөрийн хэмжээ өсөж байна.
- Үйлдвэрлэлийн нэгжийн өөрийн өртөг өндөртэй дулааны эрчим хүчийг өртгөөс доогуур үнээр борлуулж, ДЭХ-ээс жил бүр алдагдалтай ажилладаг.



“ДУЛААНЫ ҮҮ ЦАХИЛГААН СТАНЦ” ТӨХК

Түүхэн замнал

“ДЦС-4” ТӨХК-ийн суурийг 1979 онд тавьж 1983 онд эхний агрегат 80 МВт, 1984 онд 2 агрегат бүхий 180 МВт, 1985 онд 3 агрегат бүхий 280 МВт, 1986 онд 4 агрегат бүхий 380 МВт, 1990 онд 5 агрегат бүхий 460 МВт, 1991 онд 6 агрегат бүхий 540 МВт-ын суурилагдсан хүчин чадалтай болсон бөгөөд өөрийн инженерүүдийн санаачлагаар хүчин чадлыг 2007, 2009 онд тус бүр 20 МВт-аар нэмэгдүүлсэн ба 2015 онд Монгол Улсын Засгийн газрын дэмжлэгтэйгээр 120 МВт-ын хүчин чадал бүхий шинэ Турбоагрегат №7-ыг суурилуулсан. 2019 онд Турбоагрегат №1 ба Турбоагрегат №4-ийг шинэчилснээр суурилагдсан хүчин чадал цахилгаанд 43 МВт, дулаанд 47 Гкал/цагаар нэмэгдсэн. Нийт 743 МВт цахилгаан эрчим хүчний, 1416 Гкал дулааны эрчим хүчний суурилагдсан хүчин чадалтай болсон.

Үйл ажиллагааны чиглэл

- Цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэл, түгээлт

Компанийн удирдлага

- ТУЗ-дарга: Х.Бекболат (ЭХЯ-ны ДАЭУ-ын газрын дарга)
- Гишүүд
 Ё.Энхтуяа – ЭХЯ-ны шинжээч
 Д.Болд - ЗГХЭГ-ын референт
 У.Нямгэрэл - ЭХЯ-ны мэргэжилтэн
 Л.Сэлэнгэ –ТӨБЗГ
 Д.Эрэвгийлхам - ТӨБЗГ
- Хараат бус гишүүд:
 Д.Содномдорж /Хараат бус гишүүн/
 Ч.Дашпунцаг /Хараат бус гишүүн/
 Г.Атармаа /Хараат бус гишүүн/
- Гүйцэтгэх захирал: Ү.Төмөрхуяг
 Ерөнхий инженер: Б.Ганхуяг
 Ерөнхий нягтлан бодогч: Д.Төмөртоого

Эрхэм зорилго

Эх орны хөгжлийн баталгаа, Эрчим хүчний хүчирхэг тулгуур нь байна.

Товч танилцуулга

2001 оны 8 дугаар сараас Компанийн тухай хуулиар Төрийн өмчит хувьцаат компани болж үйл ажиллагаагаа явуулж байна. Тус компанийн эзэмшилд захиргааны, ахуй үйлчилгээний, лабораторийн, үйлдвэрлэлийн, засварын зэрэг 66.7 га талбай бүхий 74 барилга байгууламж багтдаг бөгөөд нийт 1487 ажиллагсадтай ба үүний 304 нь инженер техникийн ажилтан юм. 2019 оны байдлаар үйлдвэрлэл технологийн 6, механик боловсруулалтын 1 цех, 6 алба, 4 хэлтэс, төсөл хэрэгжүүлэх хэсэг, авто аж ахуй, эрчим зоог цайны газар, эмнэлэг гэсэн бүтэцтэйгээр үйл ажиллагаагаа явуулж, нэгдсэн системийн цахилгаан эрчим хүчний хэрэглээний 58.3 хувийг, Улаанбаатар хотын дулааны эрчим хүчний хэрэглээний 55.6 хувийг дангаараа үйлдвэрлэн хэрэглэгчдийн хэрэгцээ, тав тухтай байдлыг ханган ажиллаж байна.

Компанийн хөрөнгө

Төрийн эзэмшлийн хувь: 100
 Эзэмшигчийн өмч: 107,919,748.9 мян.төг
 Нийт хувьцаа: 1,079,197,489 ширхэг
 Хувьцааны нэрлэсэн үнэ: 100 төгрөг

Сүүлийн 4 жилийн эдийн засгийн үзүүлэлт


Үзүүлэлт	Хэм. нэгж	2017	2018	2019	2020
Боловсруулсан ЦЭХ	мян. кВтц	3,805.9	3,788.9	3,972.7	3,627.7
Дотоод хэрэгцээний ЦЭХ	хувь	12.3	12.4	12.1	11.9
	мян. кВтц	467.2	469.2	480.1	478.9
Эрчим хүч түгээлт: ЦЭХ	мян. кВтц	3,338.6	3,319.7	3,492.5	3,627.7
	мян. Гкал	3,508.5	3,716.6	3,915.7	4,110.3
Нийт орлого	сая төг.	243,196.9	253,993.5	279,911.5	295,923.3
Нийт зардал	сая төг.	240,334.9	254,048.4	275,582.7	330,203.9
Цэвэр ашиг	сая төг.	1,345.7	-1,583.4	880.1	-35,487.8
Нийт авлага	сая төг.	7,119.4	12,138.0	18,624.5	17,858.8
Өглөг	сая төг.	29,727.9	36,317.3	51,934.6	590,395.5
Нийт ажиллагсдын тоо	тоо	1,486	1,496	1,487	1489

Хэрэгжиж буй төсөл, хөтөлбөр

- Турбоагрегат №1-4-ийн шинэчлэлийн төсөл хэрэгжиж байна. 2019 онд Турбоагрегат №1 ба №4-ийг шинэчилснээр суурилагдсан хүчин чадлыг 43 МВт-аар нэмэгдүүлсэн. ОХУ-ын УТЗ ХК төслийн гүйцэтгэгчээр ажиллаж байгаа бөгөөд. 2020 онд Турбоагрегат №2 ба №3-ыг шинэчлэх ажил үргэлжилж байна.

Тулгамдаж буй асуудал

- Насжилт ихтэй үндсэн тоноглолын өндөр даралтын шугам хоолой болон ерөнхий уурын шугам хоолойнуудыг шинэчлэн станцын найдвартай ажиллагааг дээшлүүлж байна.
- Зуухны шаталтаас ялгарсан үнсийг барилгын материалын үйлдвэрлэлд өргөнөөр ашиглах замаар үнсэн сангийн ашиглалтын хугацааг уртасгах шаардлага тулгарч байна.
- Нэг худалдан авагч буюу ДҮТ-с авах авлага өсж байгаа нь санхүүгийн хүндрэлд орох эрсдлийг үүсгэж байна.
- Компанийн хашааны гадна байрлах инженерийн шугам сүлжээ, барилга байгууламжийн хамгаалалтын зурваст газрыг чөлөөлөх асуудал тулгамдаж байна.





“ДАРХАНЫ ДУЛААНЫ ЦАХИЛГААН СТАНЦ” ТӨХК

Түүхэн замнал

- ✓ 1961-03-31: ДЦС-ыг барих шийдвэрт гарын үсэг зурав.
- ✓ 1963-11-04: ДЦС-ын суурийг тавих ёслол болсон.
- ✓ 1965-10-02: Цахилгаан эрчим хүч түгээж эхлэв.
- ✓ 2001.07.09-ний өдрөөс “ДДЦС” ТӨХК болон зохион байгуулагдав.

Үйл ажиллагааны чиглэл

- Цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэх

Компанийн удирдлага

- **Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга:**
 1. Б.Отгонцэцэг- ЭХЯ-ны хэлтсийн дарга
- **Гишүүд:**
 2. Г.Мөнхтөр-ЭХЯ-ны мэргэжилтэн
 3. Б.Давааням-ЭХЯам
 4. Б.Ариундэлгэр - ЭХЯ-ны ахлах мэргэжилтэн
 5. Б.Баттөмөр- ЭХЯ-ны мэргэжилтэн
 6. Д.Одмаа –ТӨБЗГ-ын мэргэжилтэн
- **Хараат бус гишүүд:**
 7. Д.Өлзийтогтох /Хараат бус гишүүн/
 8. Г.Төрбат-/Хараат бус гишүүн/
 9. Ж.Баттулга-/Хараат бус гишүүн/
- Гүйцэтгэх захирал: М.Жаргалсайхан
- Дэд захирал бөгөөд Ерөнхий инженер: Б.Хаш-Эрдэнэ
- Санхүү бүртгэлийн хэлтсийн дарга бөгөөд Ерөнхий нягтлан бодогч: Ц.Ууганбаяр

Эрхэм зорилго

Хэрэглэгчээ дээдэлсэн найдвартай үйлдвэрлэгч компани байна.

Товч танилцуулга

“ДДЦС” ТӨХК нь 9 зуух, 4 турбогенератортой. Суурилагдсан хүчин чадал 48 МВт/цаг. Дархан, Сэлэнгийг цахилгаан эрчим хүчээр, Дархан хотыг дулааны эрчим хүчээр хангадаг бөгөөд жилдээ 302,8 сая кВт/цаг цахилгаан эрчим хүч, 1196 мянган Гкал дулааны эрчим хүч боловсруулах чадалтай.

Компанийн хөрөнгө

Төрийн эзэмшлийн хувь: 100
Эзэмшигчийн өмч: 100,889,686.90 мян.төг
Нийт хувьцаа: 327,047,680 ширхэг
Хувьцааны нэрлэсэн үнэ: 100 төгрөг

Сүүлийн 4 жилийн эдийн засгийн үзүүлэлт


Үзүүлэлт	2017	2018	2019	2020
Бүтээгдэхүүн үйлдвэрлэл ЦЭХ /мян.кВтц/	274,633.9	265,635.1	310,267.7	346,848.1
Дотоод хэрэгцээний ЦЭХ /мян.кВтц/	47,643.1	46,738.4	50,835.3	54,454.9
Түгээсэн ЦЭХ /мян.мВтц/	226,985.7	218,896.7	259,432.4	292,393.1
Бүтээгдэхүүн үйлдвэрлэл ДЭХ /мян.Гкал/	512,055.0	534,877.2	556,944.4	582,661.1
Дотоод хэрэгцээний ДЭХ /мян.Гкал/	12,199.4	15,079.2	19,071.4	21,453.1
Түгээсэн дулаан /мян.Гкал/	499,855.0	519,798.0	537,873.0	561,208.0
Нийт орлого /сая.төг/	40,955.2	42,426.6	48,437.8	55,563.6
Нийт зардал /сая.төг/	43,386.6	44,252.4	48,397.1	67,174.7
Цэвэр ашиг /сая.төг/	(2,431.4)	(1,825.8)	40.2	-11,611.1
Авлага /сая.төг/	2,042.2	2,340.6	4,113.6	4,444.8
Өглөг /сая.төг/	53,112.4	73,859.6	84,254.1	95,752.4
Ажиллагсдын тоо	467	476	480	485

Хэрэгжиж буй төсөл, хөтөлбөр

- ❖ ХБНГУ-ын KFW банкны хөнгөлөлттэй зээлийн хүрээнд “ДДЦС”-д 35МВт-ын шинэ турбин суурилуулах төсөл хэрэгжиж дууссан.

Тулгамдаж буй асуудал

1. Үнсэн сан шинэчлэх.
2. НОВ-ын газар доорх шугамыг шинэчлэх.





“ЭРДЭНЭТИЙН ДУЛААНЫ ЦАХИЛГААН СТАНЦ” ТӨХК

Түүхэн замнал

ЗХУ, БНМАУ-ын Засгийн газар хоорондын 1981-1985 онд хамтран ажиллах хэлэлцээрийн дагуу Эрдэнэт хотын цахилгаан дулааны ачааллыг хангах зорилгоор тус станцыг барьж байгуулахаар болсон бөгөөд станцын зураг төслийг ЗХУ-ын ВНИПИЭНЕРГОПРОМ институтын Киевийн салбарт хийсэн юм. Станцыг барьж байгуулах ажлыг 1984-1990 онд ЗХУ-ын “Загранэнергострой” байгууллагын харьяа “Монгол-энергострой” трестийн “Эрдэнэтэнергострой” барилга угсралтын удирдах газар хийж гүйцэтгэсэн. Станцын ашиглалтын өмнөх захиргаа 1984 онд, үндсэн захиргаа 1986 онд байгуулагдсан. Станцын эхний ээлж 1987 оноос ашиглалтанд орж цахилгаан, дулаан үйлдвэрлэж эхэлсэн ба 1990 онд бүрэн дуусч улсын комисс “Онц” дүнтэй хүлээн авсан юм.

Үйл ажиллагааны чиглэл

- Цахилгаан, дулаан түгээх, цахилгаан дулаанаар зохицуулалттай хангах тусгай зөвшөөрлийн хүрээнд цахилгаан, дулааны эрчим хүчээр найдвартай хангах.

Компанийн удирдлага

- Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга
Б.Ерэн-Өлзий /ЭХЯ/

Гишүүд: Г.Хүслэн-ЭХЯ-ны мэргэжилтэн
Б.Энхтуул-ЭХЯ-ны мэргэжилтэн
Б.Баясгаланбаатар- ЭХЯ-ны мэргэжилтэн
Ж.Гэрэл –ЭХЯ-ны мэргэжилтэн
Ч.Батчимэг-ТӨБЗГ-ын мэргэжилтэн

Хараат бус гишүүд:

7.С.Цэнд-Аюуш-/Хараат бус гишүүн/
8.О.Ганчимэг-/Хараат бус гишүүн/
9.С.Цогтоо-/Хараат бус гишүүн/

- Гүйцэтгэх захирал: Л.Эрхбаатар
- Үйлдвэрлэл эрхэлсэн тэргүүн дэд захирал бөгөөд Ерөнхий инженер Б.Сурмаахорол
- Санхүү, эдийн засаг эрхэлсэн дэд захирал С.Үнэнхүү
- Санхүү эдийн засгийн хэлтсийн дарга Ч.Орхон

Эрхэм зорилго

Таны гэрэл, дулаантай, ая тухтай амьдрах нөхцлийг бид хангана.


Товч танилцуулга

Монгол Улсын Засгийн газрын 2001 оны 07 сарын 09-ний өдрийн 164 тоот тогтоолоор тус станцыг “Эрдэнэтийн ДЦС” нэртэйгээр төрийн өмчит хувьцаат компани болгон зохион байгуулсан. Монгол Улсын эрчим хүчний зохицуулах газрын зохицуулагчдын зөвлөлийн 2001 оны 10 сарын 15-ны өдрийн 15-р тогтоолоор тус станцад цахилгаан, дулаан үйлдвэрлэх, дулаан түгээх, дулаанаар зохицуулалттай хангах тусгай зөвшөөрлүүдийг эзэмших эрх авсан. Эдгээр тусгай зөвшөөрлүүдээс гадна өнөөдөр тус станц нь зуух, даралтат сав, шугам хоолойг угсрах, засварлах тусгай зөвшөөрлийг эзэмшиж байна.

Станцын эхний ээлж 1987 оноос ашиглалтанд орж цахилгаан, дулаан үйлдвэрлэж эхэлсэнээс хойш 30 дахь жилдээ Эрдэнэт хотын ард иргэдийг дулаан, цахилгааны эрчим хүчээр тасралтгүй, найдвартай ханган ажиллаж байна. Эрдэнэтийн Дулааны Цахилгаан Станц нь 7 зуух, 3 турбинтэй, цагт 302.5 Гкал/цаг дулаан, 28,8 МВт.цаг цахилгаан эрчим хүч үйлдвэрлэх хүчин чадалтайгаар үйл ажиллагаагаа явуулж байна.

Сүүлийн 4 жилийн эдийн засгийн үзүүлэлт

Үзүүлэлт	2017	2018	2019	2020
Бүтээгдэхүүн үйлдвэрлэл ЦЭХ /мян.Гкал/	162.3	163.9	163.4	158.8
Бүтээгдэхүүн үйлдвэрлэл ДЭХ /сая.кВт/	571.187	592.399	604.443	620.329
Дотоод хэрэгцээний ЦЭХ	31.6	31.0	29.7	29.2
Түгээсэн ЦЭХ /сая.кВт/	130.7	132.8	133.7	128.9
Түгээсэн ДЭХ /мян.Гкал/	543.347	567.210	580.833	589.609
Нийт орлого /сая.төг/	34,757.6	35,870.1	40,723.0	42,737.5
Нийт зардал /сая.төг/	34,708.1	35,526.2	39,777.2	42,144.1
Цэвэр ашиг /сая.төг/	49.5	343.9	841.6	543.4
Авлага /сая.төг/	1,411.8	2,426.7	3,323.9	3,584.3
Өглөг /сая.төг/	1,740.9	1,753.8	7,203.2	6,493.7
Ажиллагсдын тоо	437	437	454	450



Компанийн хөрөнгө

Төрийн эзэмшлийн хувь: 100
Эзэмшигчийн өмч: 93,766,156.20 мян.төг
Нийт хувьцаа: 388.949.134 ширхэг
Хувьцааны нэрлэсэн үнэ: 50 төгрөг

Хэрэгжиж буй төсөл, хөтөлбөр

- “ЭДЦС” ТӨХК-ийг 35 мВт-ын турбогенератороор өргөтгөх төслийг хэрэгжүүлэхээр 2017 оны 01 дүгээр сарын 17-нд ЭХЯ Hunan Industrial Equipment Installation компанитай ЭХА-001/2017 дугаартай гэрээнд гарын үсэг зурж баталгаажин ажил эхэлсэн. Өргөтгөлийн нийт барилга байгууламжийн ажил 90%, тоног төхөөрөмж нийлүүлэлт 70%, тоног төхөөрөмжийн угсралт 35%-ийн гүйцэтгэлтэй байна. Төслийн ажил 2019 оны 8-р сарын 16 эхлэн /1 жилийн хугацаанд /2020 оны 08-р сарын 15-нд дуусган хүлээлгэн өгөхөөр төлөвлөгөөтэй ажиллаж байгаа боловч covid-19 коронавирус гарсантай холбогдон угсралтын ажил графикаас хоцорч байна.

Тулгамдаж буй асуудал

- Одоо ашиглагдаж байгаа “Үнсэн сан №2” 2023 онд үнсээр дүүрч ашиглалтаас гарах тул энэ хугацаанд “Үнсэн сан №1”-г ажилд бэлдэх.
- Станцаас 1-р цэг хүртэл 3,5 км урттай Ду 700 мм –ийн шугам шинээр барих.
- Зуух №1-7-ийн үнс, шлак хуурайгаар зайлуулах технологид шилжүүлэх.



“УЛААНБААТАР ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ” ТӨХК

Түүхэн замнал

1932 оны хоёрдугаар сарын 27-ны өдөр “Дундголын чийдэнгийн хороо” гэсэн нэртэйгээр 40 км урт цахилгаан дамжуулах агаарын шугамаар “Улаанбаатарын цахилгаан шугам сүлжээ”-ний эхлэл тавигдсан гэж үздэг.

Үйл ажиллагааны чиглэл

- Цахилгаан эрчим хүч түгээх, ЦЭХ-ээр хангах, Цахилгаан дамжуулах шугам, дэд станцын угсралт, засвар, туршилт тохируулгын ажил үйлчилгээ эрхлэх /0.4 – 35 кВ/

Компанийн удирдлага

- Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга
Б.Ерэн-Өлзий ЭХЯ-ны газрын дарга

Гишүүд: Б.Алтантунгалаг-ЭХЯ-ны мэргэжилтэн

Б.Номин- ЭХЯ

Б.Пунцагбалжир-ЭХЯ-ны мэргэжилтэн

Д.Дэмбэрэл-ТӨБЗГ

Д.Одмаа-ТӨБЗГ-ын мэргэжилтэн

Хараат бус гишүүд:

Н.Намхай-/Хараат бус гишүүн/

Д.Балбар -/Хараат бус гишүүн/

- Гүйцэтгэх захирал: Д.Баярсайхан

- Тэргүүн дэд захирал: Р.Дагдан

- Нийтлэг үйл ажиллагаа эрхэлсэн дэд захирал: О.Отгонбаяр

- Хангах үйл ажиллагаа эрхэлсэн дэд захирал:

Б.Бат-Эрдэнэ

- Хяналт, хөдөлмөрийн аюулгүй байдал хариуцсан дэд захирал:

Н.Даваажаргал

- Санхүү бүртгэлийн хэлтсийн дарга бөгөөд Ерөнхий нягтлан бодогч: О.Ариунболд

Эрхэм зорилго

Чадварлаг ажилтнуудаар чанартай үйлчилгээг хэрэглэгчдэдээ хүргэж, цахилгаан эрчим хүчийг найдвартай түгээгч, аюулгүй ажиллагааг хангасан салбартаа тэргүүлэгч компани болно.

Товч танилцуулга

Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ хувьцаат компани нь төвийн бүсийн цахилгаан сүлжээний нийт түгээлтийн 50 шахам хувийг цахилгаан эрчим хүчээр ханган ажилладаг. Цахилгаан эрчим хүчийг найдвартай түгээн борлуулах эрхэм үйлсэд компанийн төвийн бодлого хэрэгжүүлэх хэлтэс, албадаас гадна Баянгол, Сонгинохайрхан, Хан-Уул, Сүхбаатар, Чингэлтэй, Баянзүрх, Зуслан, Зуунмод, Налайх “Хэрэглэгчдэд үйлчлэх төв”-үүд болон Зуунмод, Налайх, Өндөр хүчдэл, Баруун, Зүүн түгээх төвийн нийт 1920 гаруй инженер, техникийн ажилтан, албан хаагч оюун ухаан, хүч хөдөлмөрөө нэгтгэн ажиллаж байна.


УБЦТС ТӨХК хөрөнгө

Төрийн эзэмшлийн хувь: 100
Нийт хөрөнгийн дүн 286,655.2 сая төгрөг
Эргэлтийн хөрөнгө 58,589.3 сая төгрөг
Үндсэн хөрөнгө 219,394.0 сая.төг
Эзэмшигчийн өмч: 194,932.0 сая.төг

Сүүлийн 4 жилийн эдийн засгийн үзүүлэлт

Үзүүлэлт	2017	2018	2019	2020
Нийт орлого /сая.төг/	362,975.7	421,191.4	478,583.2	502,953.1
Нийт зардал /сая.төг/	358,832.6	420,672.3	478,561.4	513,765.9
Цэвэр ашиг /сая.төг/	3,438.6	156.2	(619.3)	-11,341.7
Авлага /сая.төг/	24,617.4	30,222.2	35,904.4	59,190.1
Өглөг /сая.төг/	64,928.2	94,926.8	87,461.6	118,144.8
Ажиллагсдын тоо	1,918	1,919	1,920	1,920

ГЭРЭЭТ ХЭРЭГЛЭГЧ



Хэрэгжиж буй төсөл, хөтөлбөр

- Хяналт, удирдлагын **СКАДА** систем
- Түгээлтийн автоматжуулсан **DAS** систем
- Өгөгдлийн менежментийн **ТИТЭМ** буюу **ARCGIS** систем
- Arctgis-ийн мэдээллийн бааз дээр суурилсан **UT** систем-**UTILITY NETWORK**
- Техникийн нөхцөл олголтын цахим **NEW.TOG.MN** систем
- Гадуур ажиллах хүзчний менежментийн **ГЯЛС** систем
- Компанийн хэмжээнд **ЦАХИМ** хурлын систем

Тулгамдаж буй асуудал

- Тулаасгүй (monopole) тулгуурыг түгээх сүлжээнд шинээр нэвтрүүлэх.
- Хотын төвийн цахилгаан хангамжийн түгээх сүлжээг шинэчлэх, 6 кВ-оос 10 кВ хүчдэлийн түвшинд шилжүүлэх
- Улаанбаатар хотын өсөн нэмэгдэж буй хэрэглээг хангах эх үүсвэр дэд станц шинээр барих
- XXXMC-3 системийг нэвтрүүлэх
- ERP систем нэвтрүүлэх



“УЛААНБААТАР ДУЛААНЫ СҮЛЖЭЭ” ТӨХК

Түүхэн замнал

1959 оны 09-р сарын 09-ний өдөр УБ хотын дулаацуулах байгууламжийн ашиглалт, засварыг хариуцах үүрэгтэй ДШС-ийн ашиглалтын газрыг Төв цахилгаан комбинатын харьяанд байгуулагдсан.

Үйл ажиллагааны чиглэл

- Дулаанаар зохицуулалттай хангах, Дулаан түгээх, Шугам хоолой, ДДТ-ийн засвар угсралт, туршилт, тохируулга, дагдах ажил үйлчилгээ Дулааны тоолуур хэмжих хэрэгслийг суурилуулах засварлах

Компанийн удирдлага

Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга:
А.Энхбат - ЭХЯ-ны газрын дарга

Гишүүд:

Н.Бэх-Очир- ЭХЯ

Б.Энхтөр- ЭХЯ

Ж.Жанарбаатар – ЭХЯ-ны шинжээч

Д.Болортуяа- ТӨБЗГ-ын мэргэжилтэн

Э.Дуламсүрэн-ТӨБЗГ-ын мэргэжилтэн

Хараат бус гишүүд:

Б.Намхайням-/Хараат бус гишүүн/

Г.Бэхбат-/Хараат бус гишүүн/

Б.Аюуш-/Хараат бус гишүүн/

➤ Гүйцэтгэх захирал: Г.Баярсайхан

• Тэргүүн дэд захирал бөгөөд Ерөнхий инженер Б.Батбаяр

• Эдийн засгийн асуудал хариуцсан дэд захирал

Ж.Ганболд

• Түгээх үйлчилгээ хариуцсан дэд захирал Б.Бямбасайхан

• Санхүү бүртгэлийн хэлтсийн дарга бөгөөд Ерөнхий нягтлан бодогч И.Шүрэнцэцэг

Эрхэм зорилго

Улаанбаатар хотын төвлөрсөн дулаан хангамжид холбогдсон иргэд, аж ахуйн нэгж, байгууллагыг дулааны эрчим хүчээр тасралтгүй найдвартай хангах.

Товч танилцуулга



Магистраль шугам: 14
Шугамын диаметр: 150-1200 мм
Шугамын урт: 380 км
Даралт өргөх станц: 10
Хэрэглэгчдийн тоо: 2,697 аж ахуйн нэгж, ОСНААУГ-ын 16 ХҮТ, 67 ХОСК
Холбогдсон барилгын тоо: 11,200 орчим

Компанийн хөрөнгө

Төрийн эзэмшлийн хувь: 100
Эзэмшигчийн өмч: 174,531,041.5 мян.төг
Нийт хувьцаа: 1.745.310.414 ширхэг
Хувьцааны нэрлэсэн үнэ: 100 төг

Сүүлийн 4 жилийн эдийн засгийн үзүүлэлт

Үзүүлэлт	2017	2018	2019	2020
Түгээсэн дулаан /мян.Гкал/	5,806.10	6,075.80	6,370.10	6,701.4
Нийт орлого /сая.төг/	92,866.10	96,256.00	102,628.10	110,730.9
Нийт зардал /сая.төг/	91,686.40	100,575.50	102,377.70	112,875.5
Цэвэр ашиг /сая.төг/	1,013.20	-4,352.20	137.6	-2,144.5
Авлага /сая.төг/	3,796.50	6,529.30	5,539.80	4,905.7
Өглөг /сая.төг/	21,983.90	28,299.70	24,564.90	23,335.7
Ажиллагсдын тоо	365	360	384	390



Хэрэгжиж буй төсөл, хөтөлбөр

- ❖ Дэлхийн банкны 41.0 сая долларын санхүүжилтээр хийгдэх Улаанбаатар хотын төвлөрсөн дулаан хангамжийн төсөл (2020-2025 оны хооронд хэрэгжинэ)
- ❖ ЕСБХБ-ны 15 сая долларын хөрөнгө оруулалтаар хэрэгжих Улаанбаатар хотын дулаан хангамжийг сайжруулах төсөл (2020-2023 оны хооронд хэрэгжинэ)

Тулгамдаж буй асуудал

1. Хүлээгдэж буй техникийн нөхцөлтэй хэрэглэгч сүлжээнд холбогдсоноор эх үүсвэрийн суурилагдсан хүчин чадлаас 1,227.6 Гкал/ц-аар хэтэрсэн үзүүлэлттэй байна. Цаашид зайлшгүй эх үүсвэр, дамжуулах сүлжээний шугам тоноглол, насос станцын өргөтгөл, шинэчлэлтийн ажлыг хийх шаардлага тулгарч байна.



“ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ ҮНДЭСНИЙ СҮЛЖЭЭ” ТӨХК

Түүхэн замнал

1967-1968 он: УБ хотын 3-р цахилгаан станцын 110 кВ-ын ИХБ-ийг Дархан хотын ДЦС-тай 110 кВ-ын шугамаар холбож, Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээний үндэс суурь тавигдсан.

1968-1976 он: 110 кВ-ын Зүүнхараа, Баруунхараа, Борнуур, Баянчандмань дэд станцууд ашиглалтад орсноор Төвийн эрчим хүчний систем бий болсон.

1976-1979 он: ОХУ-ын Галуут нуурын дэд станцтай 220 кВ-ын ЦДАШ-аар холбогдон Дархан 220/110/35 кВ, Эрдэнэт 220/110/35/6 кВ-ын дэд станцууд ашиглалтад орж, 220 кВ-ын 257, 258-р ЦДАШ-аар Дархан хот, 201, 202-р ЦДАШ-аар Эрдэнэт хот, 110 кВ-ын 117-р ЦДАШ-аар ОХУ-ын Сибирийн эрчим хүчний системтэй Монгол улсын эрчим хүчний систем холбогдсон.

1979-1990 он: УБ хотод 110/35/10 кВ-ын Туул, 110/10/6 кВ-ын Өмнөд дэд станцууд, 110 кВ-ын 105, 106-р ЦДАШ барьж, Тойруу 110 кВ-ын шугамын эхлэлийг тавьсан. Чойрт 220 кВ-ын дэд станцыг барьж, Багануураас 207-р шугамаар холбож, Зүүн-Өмнөд бүсийн хэрэглэгчид Төвийн бүсийн эрчим хүчний системтэй холбогдсон.

1991-2000 он: Төвийн эрчим хүчний системийн нийлбэр хүчин чадал 774 МВт-д хүрч, Цахилгаан дамжуулах сүлжээ нь Дархан, Эрдэнэт, Чойр, Архангай, Өвөрхангай, Булган, Сэлэнгэ, Төв, Дорноговь, Дундговь, Хэтий аймгуудын нутаг дэвсгэрийг хамарсан.

2001-2010 он: ЗГ-ын 2001 оны 164-р тогтоолоор бүтцийн өөрчлөлт хийгдэж, Төвийн бүсийн цахилгаан дамжуулах сүлжээ ТӨХК байгуулагдсан. Швед Монголын ЗГ хооронд “Цахилгаан дамжуулах сүлжээг шинэчлэн засварлах төсөл”-ийг амжилттай хэрэгжүүлж, 15 дэд станцын тоноглолыг шинэчлэв. ХБНГУ-ын ЗГ хоорондын хамтын ажиллагааны хүрээнд хэрэгжүүлсэн “Эрчим хүчний хөтөлбөр-1” төслөөр хяналт, мэдээллийн СКАДА системийг нэвтрүүлсэн. УБ хотын 110 кВ-ын 107,108,109,110-р ЦДАШ-ын үндсэн хамгаалалтын сигналыг кабелиар дамжуулж, тойрог схемээр ажиллаж эхэлсэн.

2011-2018 он: ЗГ-ын 2012 оны 108-р тогтоолоор “Төвийн бүсийн цахилгаан дамжуулах сүлжээ” ТӨХК нэрийг “Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК гэж өөрчлөв. УБ хотод Улаанбаатар салбарыг, Өмнөговь аймгийн Цогтцэций суманд Говийн бүсийн салбарыг шинээр байгуулав. Өмнөговь аймгийн Ханбогд, Баян-Овоо сумдын хэрэглэгчдийг Төвийн эрчим хүчний системээс ЦЭХ-ээр хангах эхэлсэн. УБ хотод Их тойрог 220/110 кВ-ын шугам, дэд станцын эхний ээлжийн 3 дэд станцыг ашиглалтад хүлээн авсан.

Үйл ажиллагааны чиглэл

- Цахилгаан эрчим хүч дамжуулах
- 0,4-220 кВ болон түүнээс дээш цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцын угсралт, засвар,
- туршилт тохируулгын ажил гүйцэтгэх
- 0,4-110 кВ болон түүнээс дээш цахилгаан дамжуулах шугам, дэд станцын ТЗЭУ, зураг төсөл боловсруулах
- ЦЭХ-ний импорт (БНХАУ-аас)
- Мэргэжлийн сургалт явуулах
- Химийн хорт болон аюултай бодисыг экспортлох, импортлох, хил дамжуулан тээвэрлэх, үйлдвэрлэх, ашиглах, худалдах аж ахуйн үйл ажиллагаа

Компанийн удирдлага

Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга: А.Энхбат -ЭХЯ-ны газрын дарга

Гишүүд: Д.Энхүүш- ЭХЯ

Б.Нямбаяр-ЭХЯ-ны ахлах мэргэжилтэн

П.Жаргалсайхан- ЭХЯ-ны шинжээч

Э.Ганчимэг-ТӨБЗГ-ын ахлах мэргэжилтэн

Г.Дэлгэрмаа -ТӨБЗГ-ын мэргэжилтэн

Хараат бус гишүүд:

Ч.Жамбалсүрэн-/Хараат бус гишүүн/

Л.Дарамбазар-/Хараат бус гишүүн/

Б.Үүрийнцолмон-/Хараат бус гишүүн/

Гүйцэтгэх захирал: Б.Нямсамбуу

• Тэргүүн дэд захирал бөгөөд ерөнхий инженер Б.Дашдаваа

• Санхүү, эдийн засгийн асуудал хариуцсан дэд захирал Д.Балдорж

Аюулгүй ажиллагааг эрхэмлэж, байгаль орчинд ээлтэй, дэвшилтэт технологи ашиглан цахилгаан эрчим хүчийг найдвартай, үр ашигтай дамжуулах нь бидний эрхэм зорилго мөн.

Товч танилцуулга

Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК нь бүтэц зохион байгуулалтын хувьд 11 хэлтэс, 5 салбар, 1 төсөл хэрэгжүүлэх нэгжтэйгээр, 18 аймгийн 272 сумын 562,0 мянган хэрэглэгчийг 220 кВ-ын 9, 110 кВ-ын 67, 35 кВ-ын 1, нийт 77 дэд станц, 4843,082 км цахилгаан дамжуулах агаарын шугамаар дамжуулан цахилгаан эрчим хүчээр хангаж, мөн дээрх шугам, дэд станцуудын ашиглалт, засвар үйлчилгээг хоногийн 24 цагийн туршид хариуцан цахилгаан эрчим хүчний тасралтгүй, найдвартай ажиллагааг хангах үндсэн үүрэгтэй, 100 хувь төрийн өмчтэй компани юм.

Компанийн хөрөнгө

Төрийн эзэмшлийн хувь: 100

Эзэмшигчийн өмч: 238 073 068.3 мян.төг

Нийт хувьцаа: 2 380 730 683 ширхэг

Хувьцааны нэрлэсэн үнэ: 100 төгрөг

Хэрэгжиж буй төсөл, хөтөлбөр


- ❖ ХБНГУ-ын KfW банкны хөнгөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжиж буй “Төвийн бүсийн цахилгаан дамжуулах, түгээх сүлжээний үр ашгийг дээшлүүлэх” төсөл;
- ❖ Азийн хөгжлийн банкны хөнгөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжиж буй “Эрчим хүчний сүлжээнд ашиглах том хэмжээний хуримтлуур”-ын төсөл;
- ❖ Европын сэргээн босголт хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжиж буй “Чойр-Сайншандын чиглэлийн 220 кВ-ын 2 хэлхээт цахилгаан дамжуулах агаарын шугам, Сайншанд хотод 220 кВ-ын дэд станц барих” төсөл
- ❖ Дэлхийн банкны хөнгөлттэй зээлээр хэрэгжиж буй “Эрчим хүч-2” төсөл;
- ❖ Улаанбаатар хотын “Их тойрог” төслийн хүрээнд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй “Их тойрог 110, 220 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц” төсөл;

Тулгамдаж буй асуудал

1. 220 кВ-ын Мандал-Арвайхээр ЦДАШ, дэд станцыг барьж, Хангайн бүсийн 5 аймаг, АУЭХС-н өсөн нэмэгдэж буй ЦЭХ-ний хэрэглээний найдвартай ажиллагааг хангах, 2 талын тэжээлтэй болгож схемийг найдваржуулах, эрчим хүчний чанарыг сайжруулах
2. Төвийн эрчим хүчний системийн найдвартай ажиллагаа, өсөн нэмэгдэж буй хэрэглээг хангахын тулд 220 кВ-ын 207, 208-р транзит ЦДАШ-ыг 2 хэлхээт болгож өөрчлөх
3. 220 кВ-ын Сайншанд-Цагаансуварга 2 хэлхээт шугам, дэд станц барих
4. 220 кВ-ын Оюут дэд станцыг Эрдэнэт хотод барьж, ашиглалтад оруулах
5. 220 кВ-ын Багануур-Өндөрхаан-Чойбалсан ЦДАШ, дэд станцыг шинээр барих

Сүүлийн 4 жилийн эдийн засгийн үзүүлэлт

Үзүүлэлт	2017	2018	2019	2020
Дамжуулах ЦЭХ /сая кВт.цаг/	5,171.3	5,652.3	5,951.1	6,027.9
Дамжуулсан ЦЭХ /сая кВт.цаг/	4,997.9	5,474.2	5,762.6	5,820.1
Дамжуулалтын алдагдал /сая кВт.цаг/	173,4	178.1	188.5	207.8
Нийт орлого /сая.төг/	159,505.6	348,560.1	379,153.7	411,818.7
Нийт зардал /сая.төг/	159,433.0	348,513.1	373,710.7	411,790.7
Цэвэр ашиг /сая.төг/	33.1	0.1	4,411.7	-179.1
Авллага /сая.төг/	5,497.1	21,835.9	4,411.7	3,090.2
Өглөг /сая.төг/	22,320.6	32,315.5	113,284.6	194,242.4
Ажилтны тоо	1,142	1,154	1,223	1,257





“ДАРХАНЫ ДУЛААНЫ СҮЛЖЭЭ” ТӨХК

Түүхэн замнал

1965 онд ашиглалтад орсон Дарханы Дулааны цахилгаан станцын харьяанд **Дулааны шугам сүлжээний цех** байгуулагдаж байгаад БНМАУ-ын Хүнд Үйлдвэрийн Яамны сайдын 1990 оны 6-р сарын 4-ний өдрийн 20-р тушаалаар Дархан хотын дулааны шугам сүлжээ, тухайн үеийн Жимс Ногооны САА-н дулааны станц, Шарын голын Шаазгайтын зуух, Тосгоны халаалтын зуухыг харъяалсан “**Дархан хотын Дулааны станц шугам сүлжээний газар**” нэртэй дулааны сүлжээний бие даасан байгууллага бий болж, 1990 оны 07-р сарын 01-нээс үйл ажиллагаагаа эхэлжээ.

Үйл ажиллагааны чиглэл

- Дулаан түгээх
- Дулаанаар зохицуулалттай хангах

Компанийн удирдлага

➤ Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга: Ё.Энхтуяа-ЭХЯ-ны шинжээч

Гишүүд:

Б.Энхтуул ЭХЯ-ны мэргэжилтэн
 Б.Намжилжав-ЭХЯ-ны мэргэжилтэн
 Д.Ариунзул- ЭХЯ-ны мэргэжилтэн
 П.Даваадорж- ЭХЯ-ны шинжээч
 А.Алтаншагай -ТӨБЗГ-ын мэргэжилтэн

Хараат бус гишүүд:

Р.Дорж -/Хараат бус гишүүн/
 П.Эрдэнэбаяр-/Хараат бус гишүүн/
 Б.Ариунболд-/Хараат бус гишүүн/

➤ Гүйцэтгэх захирал: Д.Гантуул

- Ерөнхий инженер: Б.Хүрэлтогоо
- Ерөнхий нягтлан бодогч: С.Лхагважаргал

Эрхэм зорилго

Дэлхийн хөгжилтэй хөл нийлүүлэн урагшилж, дулааны эрчим хүчийг хамгийн бага алдагдалтайгаар түгээж, хэрэглэгчээ дээдэлсэн чанартай үйлчилгээ үзүүлнэ

Товч танилцуулга

“Дарханы Дулааны Сүлжээ” ТӨХК нь **Дулаан түгээх, дулаанаар зохицуулалттай хангах** тусгай зөвшөөрлийн хүрээнд дулаан дамжуулах сүлжээний 23,2 хос км, дулаан түгээх сүлжээний 91,4 хос км шугам хоолой, насосны 3 дэд станц, дулаан хуваарилах 8 төвөөр дамжуулан Дархан хотын 13791 айл өрх, 1646 ААН, байгууллагуудад дулаан түгээх, борлуулах үйл ажиллагаа эрхэлдэг. Жилд дунджаар 538 мянган Гкал дулаан түгээж, 10,5 тэрбум төгрөгийн борлуулалт хийсэн байна.

Сүүлийн 4 жилийн эдийн засгийн үзүүлэлт


Үзүүлэлт	2017	2018	2019	2020
Худалдаж авсан ДЭХүч /мян.Гкал/	499.9	519.8	537.9	561.2
ДЭХ-ний алдагдал /мян.Гкал	73	68.2	69.8	86.7
Түгээсэн дулаан /мян.Гкал/	426.9	451.6	468.1	474.5
Нийт орлого /сая.төг/	8,196.2	9,050.5	10,289.2	11,055.2
Нийт зардал /сая.төг/	8,087.5	9,171.6	9,991.2	11,053.4
Цэвэр ашиг /сая.төг/	97.9	(125.4)	249	-16.7
Авлага /сая.төг/	1,049.9	815.5	1480.9	2,487.4
Өглөг /сая.төг/	1,728.2	1,223.0	1,893.2	2,482.6
Ажиллагсдын тоо	185	186	189	187

Компанийн хөрөнгө

Төрийн эзэмшлийн хувь: 100
 Эзэмшигчийн өмч: 26.416.202.759,88 мян.төг
 Нийт хувьцаа: 179,207,223 ширхэг
 Хувьцааны нэрлэсэн үнэ: 100 төгрөг

Тулгамдаж буй асуудал

1. Дамжуулах сүлжээний К80-К94 худгийн хоорондох Ф250-300мм-ийн голчтой шугам 1970 онд ашиглалтанд орсон ба тухайн хэсгийн ханын зузааны хэмжилтийг хийхэд 0.63-5.1 мм байсан ба нимгэрэлт зөвшөөрөгдөх хэмжээнээс 28.75-72.13%-аар илүү гарч аваарийн горимд ажиллаж байгааг илтгэж байна.
2. “ДДС” ТӨХК нь 2,5 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 1473 хос метр шугамыг 2012 оноос хойш шинэчлэн солиулах талаар зураг төсвийг гаргуулан экспертизээр батлуулж улсын төсвийн хөрөнгөд тусгуулахаар хөөцөлдөж байгаа хэдий ч өнөөг хүртэл шийдвэрлэгдээгүй байна.





“ЭРДЭНЭТ БУЛГАНЫ ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ” ТӨХК

Түүхэн замнал

- 1973 оны 5 сард Эрдэнэт-Дарханы 220кв-ын шугамын тулгуур анх боссоноор гараагаа эхэлсэн.
- 1980 оны 12-р сард Сайд нарын зөвлөлийн 377 тоот тогтоолоор төвийн бүсийн баруун, баруун хойд чиглэлийн цахилгаан дамжуулах шугамын ашиглалт засварыг хариуцаж, Эрдэнэт Булганы цахилгаан шугам сүлжээний газар нэртэйгээр байгуулагдсан.
- Монгол улсын Засгийн Газрын 2001 оны 7 сарын 164 тоот тогтоолын дагуу 2001 оны 8 сарын 1-нд “ЭБЦТС” ТӨХК нэртэй өөрчлөн байгуулав.

Эрхэм зорилго

Бид найдвартай, чанартай цахилгаан эрчим хүчийг түгээхдээ хэрэглэгчээ хүндэлж нийгмийн хариуцлагыг эрхэмлэн, аюулгүй ажиллагааг ханган ажиллана.

Товч танилцуулга

Монгол улсын нутаг дэвсгэрийн 25,7% буюу 385,000 км2 газар нутаг, 11 аймаг, 124 сум, суурин газар, нийт 81,120 хэрэглэгчдэд дунджаар 1,100 сая квт цахилгаан эрчим хүч түгээж, 220 тэрбум төгрөгийн борлуулалтын орлого олж, улсын төсөвт 5 тэрбум төгрөгийн татвар төвлөрүүлдэг. Булган, Архангай, Хархорин, Өвөрхангай аймагт салбартай, нийт 658 ажилтантай.

Компанийн хөрөнгө

Төрийн эзэмшлийн хувь: 100
Эзэмшигчийн өмч: 41,896,959.3 мян.төг
Нийт хувьцаа: 418,969,593 ширхэг
Хувьцааны нэрлэсэн үнэ: 100 төгрөг

Үйл ажиллагааны чиглэл

- Цахилгаан эрчим хүч түгээх, борлуулах, ЦЭХ-аар зохицуулалттай ба зохицуулалтгүй хангах
- Цахилгаан эрчим хүчний шугамын болон тоног төхөөрөмжийн угсралт, засвар

Компанийн удирдлага

Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга: Ш.Ганзориг- ЭХЯ-ны ахлах шинжээч

Гишүүд:

М.Гансүх-ЭХЯ-ны шинжээч
 З.П.Жаргалсайхан –ЭХЯ-ны шинжээч
 Л.Нямдорж - ЭХЯ-ны хэлтсийн дарга
 5.О.Бүжин- ЭХЯ-ны мэргэжилтэн
 Т.Хулан-ТӨБЗГ-ын мэргэжилтэн

Хараат бус гишүүд:

Б.Сэмжидмаа-/Хараат бус гишүүн/
 Б.Ванчинсүрэн-/Хараат бус гишүүн/
 Д.Тэгшдэлгэр-/Хараат бус гишүүн/

Гүйцэтгэх захирал: Г.Баярцогт

- Санхүү, хангах үйл ажиллагаа хариуцсан дэд захирал Д.Мөнхбат
- Түгээх үйл ажиллагаа хариуцсан дэд захирал, Ерөнхий инженер Д.Мөнх-Эрдэнэ
- Нийтлэг үйлчилгээ, нийгмийн асуудал хариуцсан дэд захирал Ч.Сайнбат

Сүүлийн 4 жилийн эдийн засгийн үзүүлэлт


Үзүүлэлт	2017	2018	2019	2020
Худалдаж авсан цахилгаан /мян.кВт.ц/	1,127,352.3	1,185,358.1	1,176,098.9	1,181,900.0
Цахилгаан түгээлтийн алдагдал /хувь/	3.2%	2.9%	3.3%	3.5%
Борлуулсан цахилгаан /мян.кВт.ц/	1,091,672.4	1,150,685.9	1,136,707.5	1,139,800.0
Нийт орлого /сая.төг/	202,746.0	220,509.5	248,740.4	255,834.8
Нийт зардал /сая.төг/	202,584.4	220,241.5	248,573.3	256,947.3
Цэвэр ашиг /сая.төг/	117.6	208.3	98.4	-1,118.6
Авлага /сая.төг/	12,850.6	12,350.0	11,681.6	15,565.2
Өглөг /сая.төг/	15,037.1	12,860.4	11,150.1	36,320.2
Ажиллагсдын тоо	643	653	656	658

Хэрэгжиж буй төсөл, хөтөлбөр

- ❖ 2018 оны 5 сард Дэлхийн банкны олон улсын хөгжлийн агентлагийн хөнгөлөлттэй зээлээр Сангийн Яам, Эрчим Хүчний Яам ба “ЭБЦСТ” ТӨХК-ийн хооронд байгуулсан дамжуулан зээлдүүлэх гэрээгээр 16,2 сая ам долларын санхүүжилт хийгдэж, “Эрчим хүчний төсөл -2” хэрэгжин Компанийн 4 салбарын төвд төсөл хэрэгжихээр байна. Одоогийн байдлаар барилга угсралтын ажил болон нийлүүлэх, зөвлөх үйлчилгээний тендерийн 11 гэрээ хийгдэн ажлын гүйцэтгэл амжилттай явагдаж байна.

Тулгамдаж буй асуудал

1. ЦДАШ хуучралт их, байх ёстой хэмжээнээс урт ашиглалтын зардал их, орон нутгийн өмчийн дэд станцуудад шугамын ашиглалтын зардал их төсөв бага, хүчдэлийн хэлбэлзэл их
2. Ажиллагсдын дундаж цалин Эрчим хүчний салбарын дундаж цалингаас бага.
3. Хөдөө орон нутагт ажиллах мэргэжлийн боловсон хүчин дутмаг, орон тоо бага





“ ДОРНОД БҮСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ” ТӨХК

Түүхэн замнал

Монгол улсын засгийн газар Зүүн бус нутгийн эрчимтэй хөгжлийг хангах, Чойбалсан хотыг аж үйлдвэржүүлэн хөгжүүлэх зорилгоор 1967 оны 06 дугаар сарын 17 ны өдөр тус цахилгаан станцын суурийг тавьж, 1967-1970 онд ЗСБНХУ-ын (хуучин нэрээр) техник эдийн засгийн тусламжаар 12МВт-ын суурилагдсан хүчин чадалтай Дулааны цахилгаан станц баригдан ашиглалтанд орж, 1979-1982 онд Дулааны цахилгаан станцыг БКЗ-75-39/ФБ маркийн 3 зуух, ПТ12-35/10М маркийн 2 турбогенератораар өргөтгөж станцын хүчин чадал 36МВт болж нэмэгдсэн. Засгийн газрын 2001 оны 07 дугаар сарын 09 ны өдрийн 164 дүгээр тогтоолоор “Дорнод бүсийн эрчим хүчний систем” төрийн өмчит хувьцаат компани болон үйл ажиллагаа нь өргөжин тэлж, эрчим хүчний хангамжийн үйлчлэх хүрээ Монгол улсын Зүүн бүс нутгийг хамрах болсон.

Үйл ажиллагааны чиглэл

- Цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэх, түгээх, зохицуулалттай хангах

Компанийн удирдлага

- Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга:
Д.Батзориг - ЭХЯ-ны газрын дарга

Гишүүд:

- Н.Амартөвшин - ЭХЯ-ны мэргэжилтэн
- Б.Баясгаланбаатар -ЭХЯ-ны мэргэжилтэн
- С.Ариунболд -ЭХЯ-ны мэргэжилтэн
- Б.Шүр-Эрдэнэ -ЭХЯ-ны зохион байгуулагч
- В.Дарханбаатар –ТӨБЗГ-ын ахлах мэргэжилтэн

Хараат бус гишүүд:

- Г.Пүрэвдорж -/Хараат бус гишүүн/
- Ш.Дуламсүрэн -/Хараат бус гишүүн/
- Д.Ган-Очир -/Хараат бус гишүүн/

- Гүйцэтгэх захирал: Г.Отгонбаатар
- Ерөнхий инженер Ө.Жаргалсайхан
- Санхүү бүртгэлийн хэлтсийн дарга бөгөөд Ерөнхий нягтлан бодогч Д.Гэрэлчулуун

Эрхэм зорилго

Хэрэглэгчийн хэрэгцээт цахилгаан, дулааны эрчим хүчийг үйлдвэрлэн хэвийн найдвартай хангах.

Товч танилцуулга

“Дорнод бүсийн эрчим хүчний систем” Төрийн Өмчит Хувьцаат Компани нь Цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэх, түгээх, зохицуулалттай хангах 9 тусгай зөвшөөрлийн хүрээнд Дорнод, Сүхбаатар аймгийн 36 сум, багийн 27679 айл өрх, 2373 аж ахуйн нэгж, албан байгууллага, уул уурхайн 17 ордын баяжуулах, олборлох үйлдвэрийг 0.4, 10, 15, 35, 110 кВ-ын 3375.83 км агаарын ба кабель шугам, 468 ком дэд станцыг ашиглан цахилгаан эрчим хүчээр, Чойбалсан хотын 742 аж ахуйн нэгж, 94 төсвийн байгууллага, 6481 орон сууцны хэрэглэгчдийг 17.6 хос/км шугамаар дамжуулан дулааны эрчим хүчээр хангаж байна. Өнөөдөр үйлдвэрлэлийн суурилагдсан хүчин чадлын 70%-ийг цахилгаан эрчим хүчний хэрэглээ, 30%-ийг дулааны эрчим хүчний хэрэглээ эзэлж байна. Тус компани Захиргаа удирдлагын, санхүү бүртгэлийн, хангамж үйлчилгээний 3 хэлтэс, төсөл хэрэгжүүлэх нэгж, төлөвлөлтийн 1 хэсэг, дотоод хяналтын, техник хяналтын, инженерийн, хамгаалалтын гэсэн 4 алба, Дорнод болон Сүхбаатарын 2 салбар, Түлш дамжуулах, Зуух, Турбин-Хими, Цахилгаан, Компьютер Дулааны хэмжүүр автоматик, Механик засвар, Цахилгаан шугам сүлжээ, Дулааны шугам сүлжээний 8 цехийн бүтэц зохион байгуулалтаар ажиллаж байна.

Сүүлийн 4 жилийн эдийн засгийн үзүүлэлт

Үзүүлэлт	2017	2018	2019	2020
Бүтээгдэхүүн үйлдвэрлэл /сая.кВтц/	230.3	230.5	237.9	234.0
Дотоод хэрэгцээний ЦЭХ /сая.кВтц/	13.6	13.5	13.6	13.9
Түгээсэн дулаан /мян.Гкал/	269.2	273.4	297.3	312.1
Нийт орлого /сая.төг/	42,479.9	45,367.47	49,708.2	47,266.1
Нийт зардал /сая.төг/	38,016.0	44,279.48	50,095.6	46,943.6
Цэвэр ашиг /сая.төг/	3,926.5	895.1	-422.3	302.4
Авлага /сая.төг/	48.9	1,056.5	518.1	1,113.1
Өглөг /сая.төг/	11,419.9	12,937.5	16,919.8	16,402.1
Ажиллагсдын тоо	615	615	615	620


Компанийн хөрөнгө

Төрийн эзэмшлийн хувь: 100
Эзэмшигчийн өмч: 79,449,907.76 мян.төг
Нийт хувьцаа: 480,105,357 ширхэг
Хувьцааны нэрлэсэн үнэ: 100 төгрөг


Хэрэгжиж буй төсөл, хөтөлбөр

- ❖ Чойбалсангийн ДЦС-ийг 50 МВт-аар өргөтгөх төсөл

Бүтээгдэхүүн үйлдвэрлэл /сая.кВтц/



Нийт орлого /сая.төг/



Тулгамдаж буй асуудал

- Дорнодын ДЦС нэгдсэн системээс тусдаа бие дааж ажилладаг учир өндөр ачаалалтай шугамаудад гэмтэл гарч тасрах үед системийн тогтвортой ажиллагаа алдагдаж аваарын байдал үүсч болзошгүй тул цаашдаа Багануур-Өндөрхаан-Чойбалсан чиглэлийн 220 кВ ЦДАШ -ыг барьж, ДЦС-ыг нэгдсэн системтэй холбох зайлшгүй шаардлагатай байна



“ДАЛАНЗАДГАДЫН ДУЛААНЫ ЦАХИЛГААН СТАНЦ” ТӨХК

Түүхэн замнал

Өмнөговь аймгийн цахилгаан эрчим хүчний нийт хэрэглээ 2001 онд дундажаар 2.5 МВт, дулааны эрчим хүчний дундаж хэрэглээ 3.8 Гкал/ц байснаа 2013 онд 5.2 МВт, дулааны эрчим хүчний дундаж хэрэглээ 7.4 Гкал/ц болж өссөнөөр үндсэн тоноглол болох зуух турбины ажиллах хугацаа нэмэгдэж 2008 оноос эхлэн өвлийн ачааллын үед бэлтгэл тоноглолгүйгээр үйл ажиллагаа явуулж ирсэн нь найдварт ажиллагааны үед хүндрэл учирч эхэлсэн. 2010 онд өсөн нэмэгдэж байгаа эрчим хүчийг хангахын тулд орон нутгийн хөрөнгө оруулалтаар 3 МВт ын, 25 тн/ц ын нам температурын буцлах давхаргад түлш шатаах технологитой SHX-25-2.25-400 А15 маягийн зуух бүхий цахилгаан станцаар өргөтгөл хийсэн.

Үйл ажиллагааны чиглэл

- Цахилгаан үйлдвэрлэх, түгээх хангах
- Эрчим хүчний барилга, байгууламж барих, тоног төхөөрөмж суурилуулах
- Гадаад худалдаа
- Дулааны эрчим хүч үйлдэрлэх түгээх хангах

Компанийн удирдлага

- Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга: Т.Батдондог- ЭХЯ-ны хэлтсийн дарга

Гишүүд:

- 2.Ж.Гэрэл- ЭХЯ-ны ахлах мэргэжилтэн
- 3.П.Энхцэлмэг-ЭХЯ-ны ерөнхий нябо буюу ахлах мэргэжилтэн
- 4.П.Даваадорж-ЭХЯ шинжээч
- 5.Б.Алтантунгалаг-ЭХЯ-ны мэргэжилтэн
- 6.Э.Ганчимэг- ТӨБЗГ-ын ахлах мэргэжилтэн

Хараат бус гишүүд:

- 7.С.Буюанхишиг-/Хараат бус гишүүн/
- 8.Б.Өрнөхбаяр-/Хараат бус гишүүн/
- 9.Ч.Мангалжалав-/Хараат бус гишүүн/

- Гүйцэтгэх захирал: Л.Банзрагч

- Ерөнхий инженер: О.Отгонсүх
- Төлөвлөлт санхүүгийн хэлтсийн дарга: С.Гэрэлт-Од

Эрхэм зорилго

Хэмнэлтийг эрхэмлэн, инноваци шингэсэн “ЭРЧИМ ХҮЧ” -ээр хэрэглэгчдийг найдвартай хангана.

Товч танилцуулга


Станцад одоогийн байдлаар БНХАУ-д үйлдвэрлэсэн ул ширэмтэй “UG-27-3.63M” маягийн 2 зуух, нам температурын буцлах давхаргад түлш шатаах технологитой №3 SHX-25-2.25-400 А15 маягийн 1 зуух, тус бүр нь 3 МВт цахилгаан эрчим хүч үйлдвэрлэх хүчин чадал бүхий N3-2.35-1 маягийн 3 турбогенератор, нийт 38.2 Гкал/ц чадалтай 3 иж бүрдэл уур-усны хурдны бойлер, анх суурилагдсан 3M-12-2 -2 ø насос, 2014 онд ОХУ-д үйлдвэрлэгдсэн СЭ-500 маягийн 2 иж бүрдэл сүлжээний усны эргэлтийн насос суурилуулан ашиглаж байна. Суурилагдсан хүчин чадал ашиглалт цахилгаанд 63,6% дулаанд 62,8%.

Компанийн хөрөнгө

Төрийн эзэмшлийн хувь: 100
Эзэмшигчийн өмч: 8,337,595.02 м.төг
Нийт хувьцаа: 83,375.9502 ширхэг
Хувьцааны нэрлэсэн үнэ: 100 төгрөг

Сүүлийн 4 жилийн эдийн засгийн үзүүлэлт

Үзүүлэлт	2017	2018	2019	2020
Бүтээгдэхүүн үйлдвэрлэл /мян.Гкал/	29.6	38.8	50.9	
Дотоод хэрэгцээний ДЭХ /мян.Гкал/	1.0	1.0	1.0	
Түгээсэн дулаан /мян.Гкал/	28.6	37.8	49.9	67.2
Нийт орлого /сая.төг/	3,938.6	4,740.7	5,400.3	8,592.3
Нийт зардал /сая.төг/	4,876.5	5,555.1	6,522.3	9,800.9
Цэвэр ашиг /сая.төг/	-938.3	-814.4	-1,122.1	-1,208.6
Авлага /сая.төг/	188.2	289.0	218.1	492.6
Өглөг /сая.төг/	3,776.6	9,584.5	10,784.1	11,951.6
Ажиллагсдын тоо	130	131	144	175



Тулгамдаж буй асуудал

1. Бүтээгдэхүүний өөрийн өртөг, тарифийн өртгийн зөрүүг нөхөх зориулалттай санхүүжилт 2014 оноос хойш тогтмол байсан. Энэ хугацаанд валютын ханшны өөрчлөлт 36% орчим өссөн, материал хангамжийн үнэ мөн өссөн. Харин тарифийн үнэ, санхүүжилт, эдийн засгийн энэ өөрчлөлтөнд тогтмол байснаар үүрэг гүйцэтгэж чадахгүйг компанийг мөнгөний хомсдолд гүн оруулж өр зээлийг нэмэгдүүлэх хүчин зүйлс болсон. Иймд бүтээгдэхүүний тарифийн үнэ, санхүүжилтийн тооцоог эдийн засгийн өөрчлөлт бүрд хийж тухайн компанийн санхүү эдийн засгийг эрүүл байлгах нөхцөлийг бүрдүүлж өгөх шаардлагатай байна.
2. Манай компани ДЭХ үйлдвэрлэж уг бүтээгдэхүүнийхээ 33%-г бөөний үнээр ОНӨКомпанид худалдаж байгаа нь санхүү эдийн засгийн нөөцийг буруу ашиглах шийдвэр болж байна. Энэ нөөцийг зөв ашиглах гарц нь манай станцтай адил үйлчилгээг орон нутгийн цөөхөн хэрэглэгч дээр хийх нь уг 2 компанийг эдийн засгийн хувьд сул дорой байх үндсэн нөхцөлийн нэг болж байна.
3. 2020 оны 6 сараас санхүүжилтийн дүнг 18%-р бууруулсан нь эдийн засгийг улам сульдуулж 1 тэрбум гаруй төгрөгийн мөнгөний хомсдолд орох нөхцөл эхэлсэн.

Дээрх 3 асуудал нэн түрүүнд тулгамдаж байна. Асуудалыг шийдвэрлэж өгнө үү.



“БАГАНУУР ЗҮҮН ӨМНӨД БҮСИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ” ТӨХК

Түүхэн замнал

Тус компани нь БНМАУ-ын Сайд нарын зөвлөлийн 1984 оны 11-р сарын 16-ны өдрийн 328 тоот тогтоолоор “БАГАНУУР ЗҮҮН ӨМНӨД РАЙОНЫ ЦАХИЛГААН ШУГАМ СҮЛЖЭЭНИЙ ГАЗАР” нэртэйгээр байгуулагдаж, 2001 онд Засгийн газрын 164 дүгээр тогтоолын дагуу “Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК болсон.

Үйл ажиллагааны чиглэл

- Цахилгаанаар зохицуулалттай хангах, түгээх
- 0.4-110 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцын засвар угсралт, тохируулга, дагалдах ажил үйлчилгээ.
- Цахилгаан соронзон хэмжлийн хэмжих хэрэгслийг суурилуулах, засварлах, худалдах.

Компанийн удирдлага

- Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга:
И.Лувсанцэрэн – Эрчим хүчний яамны Сэргээгдэх эрчим хүчний хэлтсийн дарга

Гишүүд:

- 2.М.Гансүх-ЭХЯ-ны шинжээч
- 3.Б.Отгонцэцэг-ЭХЯ-ны мэргэжилтэн
- 4.Н.Амартөвшин-ЭХЯ-ны мэргэжилтэн
- 5.Д.Чимидлхам-ЭХЯ-ны ахлах шинжээч
- 6.Ц.Түвшинзаяа-ТӨБЗГ-ын хэлтсийн дарга

Хараат бус гишүүд:

- 7.Д.Пүрэвдаш-/Хараат бус гишүүн/
- 8.М.Ганбаатар-/Хараат бус гишүүн/
- 9.Ж.Уранчимэг-/Хараат бус гишүүн/

- Гүйцэтгэх захирал: Н.Тавинбэх

- Түгээх үйл ажиллагаа хариуцсан тэргүүн дэд захирал, ерөнхий инженер: Г.Шүрэнчулуун
- Санхүү, хангах үйл ажиллагаа хариуцсан дэд захирал Ж.Ганбаатар
- Нийтлэг үйл ажиллагаа хариуцсан дэд захирал Н.Даваа
- Хүний хөгжил, төсөл хариуцсан дэд захирал Д.Мөнхжаргал
- Санхүү, эдийн засгийн хэлтсийн дарга А.Энхбат

Эрхэм зорилго

Монгол орны зүүн өмнөд бүсийн хөгжлийн хөтөч нь байж хэрэглэгч, хамт олноо дээдэлсэн тэргүүлэгч компани байх болно.

Товч танилцуулга


Бүтэц зохион байгуулалтын хувьд өөрчлөгдөн, эзэмшил үйлчилгээний заагаар хойд тал нь Хэнтий аймгийн Дадал сумаас, урд тал нь Дорноговь аймгийн Замын-Үүд сум хүртэл, зүүн тал нь Сүхбаатар аймгийн Түмэнцогт сумаас, баруун тал нь Дундговь аймгийн Дэлгэрхангай сум хүртэл нийт 272.2 мянган хавтгай дөрвөлжин км газар нутагт орших, Улаанбаатар хотын Багануур дүүрэг, Хэнтий, Говьсүмбэр, Дорноговь, Дундговь аймгуудын төвүүдийг цахилгаан эрчим хүчээр ханган ажилладаг.

Компанийн хөрөнгө

Төрийн эзэмшлийн хувь: 100
Эзэмшигчийн өмч: 120,410,403.9 мян.төг
Нийт хувьцаа: 337,660,090 ширхэг
Хувьцааны нэрлэсэн үнэ: 100 төгрөг

Сүүлийн 4 жилийн эдийн засгийн үзүүлэлт

Үзүүлэлт	2017	2018	2019	2020
Худалдан авсан цахилгаан /сая.кВт*цаг/	348.0	410.5	457.4	440.0
Түгээлтийн алдагдал /сая.кВт*цаг/	28.4	28.1	35.7	22.4
Борлуулсан цахилгаан /сая.кВт*цаг/	319.6	382.4	421.8	417.5
Нийт орлого /сая.төг/	63,147.6	65,721.5	97,128.2	97,693.5
Нийт зардал /сая.төг/	62,380.3	65,487.4	95,524.0	96,787.3
Цэвэр ашиг /сая.төг/	609.7	4.7	657.9	459.1
Авлага /сая.төг/	1,006.8	721.1	448.7	2,628.5
Өглөг /сая.төг/	1,596.6	2,461.6	6,434.3	11,346.9
Ажиллагсдын тоо	520	527	533	547



Хэрэгжиж буй төсөл, хөтөлбөр

- ❖ Дэлхийн банкны хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр “Эрчим хүчний төсөл-2”-ын хүрээнд цахилгаан түгээх сүлжээг шинэчлэх, сайжруулах ажил Улаанбаатар хотын Багануур дүүрэг, Говьсүмбэр аймгийн Сүмбэр сум, Дорноговь аймгийн Сайншанд сум, замын-Үүд сум, Хэнтий аймгийн Хэрлэн сум, Бор-Өндөр сум, Дундговь аймгийн Сайнцагаан сум буюу 1 дүүрэг 4 аймгийн төв, 2 суманд нийт 12580 мян.долларын хөрөнгөөр хэрэгжүүлж байна. Төслийг 2022 онд багтаан бүрэн хэрэгжүүлж дуусгахаар ажиллаж байна.

Тулгамдаж буй асуудал

1. 35/10 кВ Баяжаргалан дэд станц, 35/10 кВ Хулд дэд станц, 35/15 кВ Баян-Адарга дэд станцаас цахилгаан эрчим хүчээр хангагддаг Дадал, Норовлин, Биндэр, Батширээт сумдын 15 кВ-ын ЦДАШ, 35/6 кВ Зүлэгтэй дэд станц, 35/10 кВ Даланжаргалан дэд станцуудын хүчин чадлыг нэмэгдүүлэх, техник технологийн шинэчлэл хийх шаардлагатай байна.



“БАРУУН БҮСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ” ТӨХК

Түүхэн замнал

“ББЭХС” ТӨХК нь анх ЭХГУУЯ-ны сайдын шийдвэрээр 1995 оны 05-р сарын 01-нд “ББЭХС” нэртэйгээр байгуулагдсан. МУ-ын Засгийн газрын 2001 оны 164 тоот тогтоолоор “ББЭХС”-ийг Увс, Ховд, Баян-Өлгий аймгууд дахь цахилгаан дамжуулах өндөр хүчдэлийн шугам, дэд станцуудыг түшиглэн, импортын ЦЭХ-ийг хэрэглэгчдэд дамжуулан борлуулах үйл ажиллагааг эрхлэх “Баруун бүсийн цахилгаан дамжуулах сүлжээ” ТӨХК болгосноор зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжүүлэх эхлэл тавигдсан. Хувьцаат компанийн үйл ажиллагааг өөрчлөн сайжруулах, гадаад төлбөр тооцоогоо өөрөө бүрэн хариуцан гүйцэтгэж хэрэглэгчдийг ЦЭХ-ний тасалдлаас бүрэн ангижруулах зорилгоор Монгол улсын Засгийн газрын 2006 оны 01 сарын 01-нээс “ББЭХС” ТӨХК болгон нэрийг нь дахин өөрчилж өргөтгөн харьяалалд нь “Ховд ЦТС”, “Увс ЦТС” ХХК-уудыг охин компани байдлаар ажиллуулж эхэлсэн. Компанийн нийт хувьцаа 100 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 552 010 727 ширхэг хувьцаатай. Удирдах дээр байгууллага нь хувь нийлүүлэгчдийн хурлаас томилсон Төлөөлөн Удирдах Зөвлөл нь компанийн үйл ажиллагаанд тасралтгүй байнга хяналт тавьж ажилладаг.

Үйл ажиллагааны чиглэл

- Цахилгаан эрчим хүч үйлдвэрлэх
- Цахилгаан эрчим хүч импортлох
- Цахилгаан эрчим хүч дамжуулах
- Цахилгаан эрчим хүч түгээх
- 0.4-110 кВ хүртэлх цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцын засвар үйлчилгээ, туршилт тохируулга бусад дагалдах үйлчилгээ

Компанийн удирдлага

➤ **Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга:** Д.Батзориг - ЭХЯ-ны газрын дарга

Гишүүд:

- 2.Б.Санчирдорж - ЭХЯ-ны ахлах шинжээч
- 3.Б.Мөнхчулуун - ЭХЯ-ны мэргэжилтэн
- 4.У.Нямгэрэл - ЭХЯ-ны мэргэжилтэн
- 5.Г.Хүслэн - ЭХЯ-ны мэргэжилтэн
- 6.Г.Нямдаваа-ТӨБЗГ-ын мэргэжилтэн

Хараат бус гишүүд:

- 7.Д.Гягар-/Хараат бус гишүүн/
 - 8.Б.Туяа-/Хараат бус гишүүн/
 - 9.Г.Оюунтөгөлдөр-/Хараат бус гишүүн/
- Гүйцэтгэх захирал: Р.Нямтуул
 ➤ Тэргүүн дэд захирал бөгөөд Ерөнхий инженер Д.Ганхүлэг
 • Санхүүгийн албаны дарга Н.Отгонтунгалаг

Эрхэм зорилго

Баруун бүс нутгийн импортын болон дотоодын эх үүсвэрийг чанартай эрчим хүчээр найдвартай хангаж, хэрэглэгчдийг дээдэлсэн соёлтой үйлчилгээг үзүүлнэ

Товч танилцуулга

“ББЭХС” ТӨХК нь Ховд, Баян-Өлгий аймгуудад 2 салбар, ДУЦС ХХК, Увс ЦТС ХХК, Ховд ЦТС ХХК гэсэн 3 охин компанийн нийт 400 гаруй ИТА-тайгаар үйл ажиллагаагаа явуулж байна. ББЭХС-ийн 110 кВ-ын 913.7 км, 35 кВ-ын 980.8 км, 110 кВ-ын 9, 35 кВ-ын 20 дэд станцуудаар ЦЭХ-ийг дамжуулан баруун бүс нутгийн 3 аймгийн төв, 5 аймгийн 52 сум, 40 гаруй багийн төв суурин газрыг ЦЭХ-ээр хангаж байна.

Компанийн хөрөнгө

Төрийн эзэмшлийн хувь: 100
Эзэмшигчийн өмч: 55 201 072 730.45 төгрөг
Нийт хувьцаа: 552 010 727 ширхэг
Хувьцааны нэрлэсэн үнэ: 100 төгрөг

Сүүлийн 4 жилийн эдийн засгийн үзүүлэлт

Үзүүлэлт	2017	2018	2019	2020
Дамжуулсан ЦЭХ /сая кВт.ц/	150.5	159.4	176.4	166.6
Дамжуулалт, түгээлтийн алдагдал / % /	20.5	19.3	18.7	18.2
Борлуулсан ЦЭХ /сая кВт.ц/	119.6	128.7	140.1	149.7
Нийт орлого /сая төг/	14,613.1	16,287.8	26,507.1	22,821.7
Нийт зардал /сая төг/	26,864.8	29,203	31,173.5	40,746.7
Цэвэр ашиг /сая төг/	-12,251.7	-12,915.2	-4,667.6	-1,225.1
Авлага /сая төг/	1,779.2	1,611.3	783.7	3,434.6
Өглөг /сая төг/	38,519.3	44,071.2	49,222.3	48,349.7
Ажиллагсдын тоо	140	142	145	413



Хэрэгжиж буй төсөл, хөтөлбөр

- ❖ Дэлхийн банкны санхүүжилттэй “ЭРЧИМ ХҮЧНИЙ ТӨСӨЛ II”-ын хүрээнд 110/35/6 кВ-ын Мянгад дэд станцын шинэчлэлийн ажил
- ❖ Дэлхийн банкны санхүүжилттэй “ЭРЧИМ ХҮЧНИЙ ТӨСӨЛ II”-ын хүрээнд Ховд аймгийн Мянгад сумын нутагт 10 МВт-ын чадалтай Нарны цахилгаан станц барих ажил
- ❖ АХБ-ны хөнгөлөлттэй зээлээр Увс аймгийн Өмнөговь суманд 10 МВт-ын чадалтай Салхин цахилгаан станц барих төсөл

Тулгамдаж буй асуудал

- 2020 онд шаардлагатай татаасын хэмжээг 2019 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн 01/732 тоот албан бичгээр 18.3 тэрбум төгрөгөөр хүргүүлсэн боловч 13.5 төгрөгөөр батлагдсан бөгөөд энэхүү татаасаас 2019 оны төлбөр 4.9 тэрбум төгрөгийг төвийн бүсийн нэгдсэн сүлжээнд, 4.0 тэрбум төгрөгийг ОХУ-аас худалдаж авсан цахилгааны 2019 хуримтлагдсан өр төлбөрт 3.2 тэрбум төгрөгийг 2020 оны 05 дугаар сар хүртэл хугацаанд худалдаж авсан импортын цахилгааны төлбөрт төлж барагдуулсан. Өөрөөр хэлбэл 2020 онд батлагдсан татаасыг ОХУ-аас худалдаж авсан импортын цахилгааны төлбөрт төлж барагдуулаад байна.
- ОХУ-аас худалдан авч байгаа цахилгааны үнэ энэ оны 01 дүгээр сарын 01-нээс 0.10 рубль/кВт.ц-аар 07 дугаар сарын 01-нээс 0.07 рубль/кВт.ц-аар тус тус нэмэгдэж санхүү, эдийн засгийн хүндрэлтэй нөхцөл байдалд үйл ажиллагаа явуулж байна.
- компанийн сүүлийн хагас жилд шаардлагатай **7.0** тэрбум төгрөгийн татаасыг 2020 оны улсын төсвийн тодотголд тусгах шаардлагатай байна.



“БАГАНУУРЫН ДУЛААНЫ СТАНЦ” ТӨХК

Түүхэн замнал

“Багануурын Дулааны станц” ТӨХК нь анх 1980 оны 12-р сарын 12-ны өдөр Багануурын уурхайг дулааны эрчим хүчээр хангах зорилгоор “Төвийн уурын зуух” нэртэйгээр Багануурын нүүрсний уурхайн харьяанд байгуулагдаж цагт 25 тн ханасан уур үйлдвэрлэх хүчин чадалтай KE-25-140 маркийн 3 зуухтайгаар үйл ажиллагаагаа эхэлсэн ба 1983 он гэхэд усан халаалтын KBTC-20-150/70 маркийн 6 зуухнуудыг туслах төхөөрөмжийн хамт ашиглалтад оруулсан.

1989 онд өргөтгөл хийгдэж усан халаалтын 2 зуух, уур үйлдвэрлэх 1 зуухыг ашиглалтад оруулснаар жилд 300 мянган Гкал дулаан үйлдвэрлэх хүчин чадалтай болон өргөжсөн.

Төрийн өмчийн хорооны 2008 оны 02-р сарын 28-ны өдрийн 88-р тогтоолоор бие даасан хуулийн этгээд Төрийн өмчит хувьцаат компани болсон.

Үйл ажиллагааны чиглэл

- Дулаан үйлдвэрлэх,
- Дулаан түгээх,
- Дулаанаар зохицуулалттай хангах

Компанийн удирдлага

- Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга: Н.Мөнхбат- ЭХЯ

Гишүүд:

- 2.Т.Болортуяа- ЭХЯ зохион байгуулагч
- 3.Ж.Саруул- ЭХЯ-ны мэргэжилтэн
- 4.Ж.Жанарбаатар-ЭХЯ-ны шинжээч
- 5.М.Алтаншагай -ШЕЗ-ийн референт
- 6.Ж.Мөнхтүвшин -ТӨБЗГ-ын мэргэжилтэн

Хараат бус гишүүд:

- 7.Д.Нанжаа /Хараат бус гишүүн/
- 8.Ж.Шагдарсүрэн /Хараат бус гишүүн/
- 9.Х.Цогтбаатар /Хараат бус гишүүн/

- Гүйцэтгэх захирал: Н.Ганбаатар

- Дэд захирал /Ерөнхий инженер/ А.Лхамсүрэн
- Санхүү, борлуулалт, эдийн засгийн хэлтсийн дарга Ц.Энхцэцэг

Эрхэм зорилго

Хэрэглэгчээ дээдэлж, хүний хөгжлийн дэвшилтэт технологид түшиглэн үр ашигтай үйлдвэрлэл явуулж, стандартын шаардлага хангасан ДЭХ-ээр тасралтгүй найдвартай хангах

Товч танилцуулга

Манай байгууллага нь дулааны эрчим хүчний мэдлэг туршлага хуримтлуулсан чадварлаг ИТА, ажиллагсадтай ба нийт 141 ажилтантай. Үүнээс 101 эрэгтэй 40 эмэгтэй, МУ-ын зөвлөх инженер 3, Мэргэшсэн инженер 2, мэргэшсэн нягтлан бодогч 1 байна. Нийт ажиллагсдын 50-аас дээш хувь нь 16-с дээш жил ажилласан. Алтангадас одонт 5, Хөдөлмөрийн хүндэт медальт 8, эрчим хүчний тэргүүний ажилтан 54 байна.


Компанийн хөрөнгө

Төрийн эзэмшлийн хувь: 100
Эзэмшигчийн өмч: 10,191,717.5 мян.төг
Нийт хувьцаа: 62,915,178.41 ширхэг
Хувьцааны нэрлэсэн үнэ: 100 төгрөг

Сүүлийн 4 жилийн эдийн засгийн үзүүлэлт

Үзүүлэлт	2017	2018	2019	2020
Бүтээгдэхүүн үйлдвэрлэл /мян.Гкал/	168.1	164	154.8	164.4
Дотоод хэрэгцээний ДЭХ /мян.Гкал/	6.1	5.7	4.6	4.7
Түгээсэн дулаан /мян.Гкал/	162	158.3	150.2	159.6
Нийт орлого /сая.төг/	6,175.2	6,230.1	6,280.8	6,621.2
Нийт зардал /сая.төг/	6,183.4	6,402.1	6,976.6	7,317.4
Цэвэр ашиг /сая.төг/	- 22.8	- 172.4	- 676.78	-677.3
Авлага /сая.төг/	327.5	220	181.4	789.5
Өглөг /сая.төг/	2,893.6	2,400.5	1,889.7	2,271.5
Ажиллагсдын тоо	141	141	141	141

Өглөг /сая.төг/



Хэрэгжиж буй төсөл, хөтөлбөр

- ❖ Үйлдвэрлэл, техник технологид барих “ТЕХНИКИЙН ҮНДСЭН БОДЛОГО /2018-2023 он/” хөтөлбөр.
- ❖ “БНДС” ТӨХК-ийн Үндсэн болон туслах тоног төхөөрөмж, тусгай зөвшөөрлийн үйл ажиллагааны “ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ, ЭРЭМБЭЛЭЛТ”-ийн дагуу гүйцэтгэх техникийн арга хэмжээний хөтөлбөр.
- ❖ Дүүргийн, 2030 он хүртлэх хот төлөвлөлттэй уяалдан, одоогийн хотын төвийн хойд бүсээр шинээр байгуулах төвлөрсөн дулаан хангамжийн ерөнхий магистралын **Ф370x8мм-ийн, хос, 3600м урт шугам сүлжээний** төсөл.

Тулгамдаж буй асуудал

1. Үйлдвэрлэлийн үндсэн ША(шуурхай ажиллагаа)-нд ашиглах 2-оос доошгүй автомашины асуудал шийдэх.
2. Нийлүүлэгчээс татан авч буй нүүрсийг хэмжих иж бүрэн пүүний систем, нүүрсний хос тоолуур суурилуулах.
3. Нүүрс түрэх бульдозер-1, нүүрс тээвэрлэх (>40тн) автомашин-1 зэргийн асуудал шийдэх.
4. 2020-2021 оны өвөлжилтийн бэлтгэл хангахад төлөвлөгөөнд тусгагдаагүй, аваарийн нөөцөд тооцогдох, нийт 96,8 сая төгрөгийн 9 нэр төрлийн багц бэлдэц, сэлбэг материал, тоног төхөөрөмжийн асуудлыг бүрэн хэмжээнд шийдвэрлэх.



“НАЛАЙХЫН ДУЛААНЫ СТАНЦ” ТӨХК

Түүхэн замнал

БНМАУ-ын Сайд нарын зөвлөлийн 1976 оны 9-р сарын 24-ний өдрийн 317 тоот тогтоолоор “Налайх тосгоны Дулааны станц” нэртэйгээр анх үүсэн байгуулагдаж, Монгол Улсын Засгийн газрын 2001 оны 7-р сарын 9-ний өдрийн 164 тоот тогтоолоор “Налайхын Дулааны станц” ХК болсон.

Үйл ажиллагааны чиглэл

- Дулаан үйлдвэрлэх,
- Дулаан түгээх,
- Дулаанаар зохицуулалттай хангах.

Компанийн удирдлага

➤ ТУЗ-дарга:
С.АРИУНБОЛД /ЭХЯ, ахлах мэргэжилтэн/

Гишүүд:

- 2.Г.Энхтүвшин-ЭХЯ-ны ахлах мэргэжилтэн
- 3.Б.Ариундэлгэр-ЭХЯ-ны шинжээч
- 4.Б.Дэлгэрэл-ЭХЯ-ны мэргэжилтэн
- 5.Г.Бадамцэцэг-ЭХЯ-ны мэргэжилтэн
- 6.С.Сүнжидмаа-ТӨБЗГ-ын мэргэжилтэн

Хараат бус гишүүд:

- 7.Ж.Цэен-Ойдов /Хараат бус гишүүн/
- 8.С.Бямбадалай /Хараат бус гишүүн/
- 9.Б.Баяржаргал /Хараат бус гишүүн/

➤ Гүйцэтгэх захирал:

Ц. ЭНХТҮВШИН

Эрхэм зорилго

Хэрэглэгчээ дээдлэн, дэвшилтэд технологид түшиглэсэн дулааны эрчим хүчний үр ашигтай үйлдвэрлэл явуулах

Товч танилцуулга


“Налайхын дулааны станц” төрийн өмчит хувьцаат компани нь төлөвлөлт санхүү бүртгэлийн хэлтэс, ашиглалт, авто хангамж, дулааны шугам сүлжээ, ДХХА цахилгаан, засвар, захиргаа аж ахуйн гэсэн 1 хэлтэс, 6 хэсгийн нийт 122 ажиллагсадтайгаар хэрэглэгчдэд дулааны эрчим хүч үйлдвэрлэх, түгээх, дулааны эрчим хүчээр зохицуулалттай хангах үндсэн үйл ажиллагаанаас гадна бусад тусгай зөвшөөрлийн хүрээнд ажил үйлчилгээг амжилттай явуулж байна.

Компанийн хөрөнгө

Төрийн эзэмшлийн хувь: 100
Эзэмшигчийн өмч: 6,373,866.4 мян.төг
Нийт хувьцаа: 63,738,665 ширхэг
Хувьцааны нэрлэсэн үнэ: 100 төгрөг

Сүүлийн 4 жилийн эдийн засгийн үзүүлэлт

Үзүүлэлт	2017	2018	2019	2020
Дулаан үйлдвэрлэл /мян.Гкал/	123.1	108.1	96.3	94.9
Дотоод хэрэгцээнд /мян.Гкал/	2.2	2.4	2.5	2.5
Түгээсэн дулаан /мян.Гкал/	120.9	105.7	93.8	92.4
Нийт орлого /сая.төг/	2,971.5	3,769.2	3,827.7	4,057.6
Нийт зардал /сая.төг/	4,254.3	4,532.7	3,937.4	5,687.1
Цэвэр ашиг /сая.төг/	-10.1	448.2	-114.3	-504.1
Авллага /сая.төг/	406.6	377.9	442.1	693.9
Өглөг /сая.төг/	1,917.2	1,229.2	1,140.9	1,410.2
Ажиллагсдын тоо	114	114	122	122



Хэрэгжиж буй төсөл, хөтөлбөр

❖ Тус станцын суурилагдсан хүчин чадлыг 120 МВт-аар өргөтгөл хийх зураг, төсвийг “ББСМО” ХХК гүйцэтгэж байгаа бөгөөд Эрчим хүчний хөгжлийн төв, Барилгын хөгжлийн төвүүдэд магадлал хийгдэж байна.

Тулгамдаж буй асуудал

1. Станцын өргөтгөлийн асуудалтай уялдан дулааны түгээх шугам сүлжээнүүдэд өргөтгөл шинэчлэл хийх зураг төсөв хийлгэх
2. Налайхын нүүрсний уурхайнууд ажиллахаа больсон учир стандартын шаардлага хангахуйц нүүрсний олдоц муудсан, Багануурын уурхайгаас нүүрсийг автомашинаар тээвэрлэлт хийж байгаа нь зардал өсөх шалтгаан болж байна.



“ӨМНӨД БҮСИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ” ТӨХК

Түүхэн замнал

Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 1 дүгээр сарын 5-ны өдрийн 3 дугаар тогтоолоор “Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” төрийн өмчит хувьцаат компани шинээр үүсгэн байгуулагдсан. Тухайн үеийн Төрийн өмчийн хорооны 2013 оны 4 дүгээр сарын 18-ны өдрийн 185 дугаар тогтоолоор компанийн дүрмийг баталж, “Даланзадгадын ДЦС” ТӨХК-иас балансаас балансад 1,2 тэрбум төгрөг, бусад сумдын 6,0 тэрбум төгрөг нийт 7,2 тэрбум төгрөгийн хөрөнгө хүлээн авч үйл ажиллагаагаа эхэлсэн.

Үйл ажиллагааны чиглэл

- Цахилгаанаар зохицуулалттай хангах
- Цахилгаан түгээх
- 0,4-35 кВ-ын ЦДШ, дэд станцын засвар, угсралт, түүний туршилт тохируулга, дагалдах үйлчилгээ эрхлэх
- Тоолуур хэмжих хэрэгслийг засварлах, суурилуулах
- Цахилгаан импортлох
- Эрчим хүчний барилга байгууламж барих

Компанийн удирдлага

- Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга:
Б.Нямбаяр- ЭХЯ-ны ахлах мэргэжилтэн

Гишүүд:

- 2.Г.Мөнхтөр- ЭХЯ-ны мэргэжилтэн
- 3.Ж.Мөнхбилэг-ЭХЯ
- 4.С.Ариунбулган- ЭХЯ-ны мэргэжилтэн
- 5.Б.Өнөрмаа-ТӨБЗГ-ын мэргэжилтэн
- 6.Г.Бадамцэцэг-ЭХЯ-ны мэргэжилтэн

Хараат бус гишүүд:

- 7.Д.Жанчив-/Хараат бус гишүүн/
- 8.Л.Долгорсүрэн-/Хараат бус гишүүн/
- 9.Ц.Санчин-/Хараат бус гишүүн/

- Гүйцэтгэх захирал: Т.Жаргалсайхан
- Дэд захирал бөгөөд Ерөнхий инженер Т.Гантөмөр
- Санхүү бүртгэлийн хэлтсийн дарга бөгөөд Ерөнхий нягтлан бодогч М.Өлзийнэмэх

Эрхэм зорилго

Дэвшилтэт технологийг нэвтрүүлэн хэрэглэгчдийг цахилгаан эрчим хүчээр тасралтгүй найдвартай хангаж, түгээсэн эрчим хүчийг борлуулж хэрэглэгчдээ дээдлэн ажиллах.

Товч танилцуулга


2013 онд үүсгэн байгуулагдсан. 2019 оны жилийн эцсийн байдлаар 19,2 тэрбум төгрөгийн хөрөнгөтэй, 6 тусгай зөвшөөрлийн хүрээнд Өмнөговь аймгийн 14 сумдын нутаг дэвсгэрийг хамран нийт 294 ширхэг хуваарилах байгууламж, дэд станцын цахилгаан тоног төхөөрөмж ашиглан үйл ажиллагаагаа явуулж байна. Нийт батлагдсан орон тоо 108, 2019 оны жилийн эцсээр 90.6 сая.кВт.ц цахилгаан эрчим хүчийг 14,516.2 сая төгрөгөөр худалдан авч, 81,8 сая.кВт.ц цахилгаан эрчим хүчийг 15,003.8 сая төгрөгөөр борлуулж, нийт 18,732.9 сая төгрөгийн орлоготой 18,744.4 сая төгрөгийн зардалтай, 19.6 сая төгрөгийн алдагдалтай ажилласан.

Компанийн хөрөнгө

Төрийн эзэмшлийн хувь: 100
Эзэмшигчийн өмч: 18,611,459.0 мян.төг
Нийт хувьцаа: 156,023,071 ширхэг
Хувьцааны нэрлэсэн үнэ: 100 төгрөг

Сүүлийн 4 жилийн эдийн засгийн үзүүлэлт

№	Үндсэн үзүүлэлт	Хэмжих нэгж	2017 он	2018 он	2019 он	2020 он
1	Худалдан авсан	сая.квт.ц	43.3	62.7	90.6	110.2
2	Түгээлтийн алдагдал	сая.квт.ц	5.5	7.5	8.8	7.7
		хувиар	12.8	11.9	9.7	7.0
3	Борлуулсан ЦЭХ	сая.квт.ц	37.8	55.2	81.8	102.5
4	Нийт орлого	сая.төг	8,501.1	11,957.2	18,732.9	23,911.1
	Нийт зардал	сая.төг	7,776.4	11,863.5	18,744.4	23,903.8
5	Цэвэр ашиг/ алдагдал	сая.төг	652.2	83.3	(19.5)	-39.1
6	Авллага	сая.төг	50.4	212.0	288.4	743.1
7	Өглөг	сая.төг	767.9	623.9	550.1	559.5
8	Ажилчдын тоо	хүн	87	90	97	96



Хэрэгжиж буй төсөл, хөтөлбөр

- ❖ 35/15 кВ-ын Ноён, Номгон, 35/10 кВ-ын Далан, Манлай, Ханбогд, Баян-Овоо, Хүрмэн, Жуулчин, Гурвантэс дэд станцууд, 10 кВ-ын Эрчим, РП-1, РП-2 ХХБ -ын оруулга, гаргалгаа, дотоод хэрэгцээ, 35/0.4 кВ, 15/0.4 кВ, 10/0.4 кВ-ын бүх дэд станцуудын толгой тоолууруудыг ухаалаг тоолуураар шинэчлэн түгээлтийн алдагдалыг бууруулах

Тулгамдаж буй асуудал

1. Өмнөговь аймаг нь сүүлийн жилүүдэд уул уурхай түшиглэн хурдацтай хөгжиж байна. Үүнийг дагаад нарийн мэргэжлийн ажилчид цалин өндөр хангамж сайтай уул уурхайд ихээр ажилд орж байна. Манай компани өнөөдрийн байдлаар мэргэжлийн чадварлаг боловсон хүчний дутагдалтай 10 орон тоо дутуу ажиллаж байна.



“АЛТАЙ-УЛИАСТАЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ” ТӨХК

Түүхэн замнал

Монгол Улсын Засгийн Газрын 2008 оны 233 дугаар тогтоолоор “Алтай-Улиастайн ЭХС” ТӨХК болж улмаар 2009 оны 04 дүгээр сараас үйл ажиллагаа явуулж эхэлсэн.

Үйл ажиллагааны чиглэл

- Цахилгаан эрчим хүч дамжуулах, түгээх, үйлдвэрлэх, цахилгаанаар зохицуулалтаар хангах, тоолуур худалдах, засварлах, суурилуулах, тохируулах, эрчим хүчний барилга шугам сүлжээ барих, засварлах

Компанийн удирдлага

- Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга:
И.Лувсанцэрэн- ЭХЯ-ны ахлах мэргэжилтэн

Гишүүд:

- Д.Дулмаа-ЭХЯ
- Э.Мөнхтөр-ЭХЯ-ны мэргэжилтэн
- Ш.Ганзориг-ЭХЯ-ны ахлах шинжээч
- Д.Оюунчимэг- ЭХЯ-ны шинжээч
- Д.Тунгалагтуул-ТӨБЗГ-ын мэргэжилтэн

Хараат бус гишүүд:

- Ж.Амарсайхан-/Хараат бус гишүүн/
- Ч.Улам-Оргил-/Хараат бус гишүүн/
- Б.Бат-Эрдэнэ-/Хараат бус гишүүн/

- Гүйцэтгэх захирал: А.Пүрэвсүрэн

- Үйлдвэрлэл эрхэлсэн тэргүүн дэд захирал бөгөөд Ерөнхий инженер: Б.Бээжин
- Үйл ажиллагаа эрхэлсэн дэд захирал: Б.Наваан-Юндэн
- Санхүү төлөвлөлтийн хэлтсийн дарга бөгөөд Ерөнхий нягтлан бодогч: С.Ганзориг

Эрхэм зорилго

Манай системийн үндсэн зорилго нь хоёр аймгийн нийт хэрэглэгчдийг цахилгаан эрчим хүчээр тасралтгүй найдвартай хангах, эрчим хүчний хэмнэлтийн бодлогыг хэрэгжүүлэх, цахилгаан эрчим хүчний алдагдлыг бууруулах, компанийн үр ашгийг дээшлүүлэх явдал юм.

Товч танилцуулга


“Алтай-Улиастайн эрчим хүчний систем” ТӨХК нь Завхан аймаг дахь салбар, “Тайшир-Гуулин УЦС” ХХК, “Тосонцэнгэл УЦС” ХХК, “Богдын голын УЦС” ХХК зэрэг салбар, охин компаниуд болон 5 хэлтэс, 1 албаны бүтэцтэй 338 орон тоотой үйл ажиллагаагаа явуулж байна.

Компанийн хөрөнгө

Төрийн эзэмшлийн хувь: 100
Эзэмшигчийн өмч: 60 388 037.2 мян.төг
Нийт хувьцаа: 603 880 372 ширхэг
Хувьцааны нэрлэсэн үнэ: 100 төгрөг

Сүүлийн 4 жилийн эдийн засгийн үзүүлэлт

Үзүүлэлт	2017	2018	2019	2020
Бүтээгдэхүүн үйлдвэрлэл /мян.Гкал/	70,100.0	75,673.71	81,012.24	83,963.65
Дотоод хэрэгцээний ДЭХ /мян.Гкал/	561.93	621.29	591.25	504.56
Түгээсэн дулаан /мян.Гкал/	69,575.23	75,052.42	80,420.99	83,459.09
Нийт орлого /сая.төг/	10,358.59	1,1791.3	13,077.2	13,463.1
Нийт зардал /сая.төг/	12,599.14	14,085.3	16,547.9	17,482.4
Цэвэр ашиг /сая.төг/	-2,240.6	-2,294.0	-3,471.7	-4,019.5
Авлага /сая.төг/	106.85	461.2	1,167.6	1,256.9
Өглөг /сая.төг/	43,754.8	44,859.9	44,893.6	45,171.7
Ажиллагсдын тоо	330	338	338	338



Хэрэгжиж буй төсөл, хөтөлбөр

- “Азийн хөгжлийн банк”-ны санхүүжилтээр Говь-Алтай аймгийн Есөнбулаг сум 10 МВт хүчин чадалтай нарны цахилгаан станц барих төслийн нэгж байгуулагдан ТЭЗҮ болон бусад холбогдох тооцоо судалгаа хийгдэн, тендер шалгаруулалтын шатандаа явагдаж байна. Мөн Алтай сум 0,5МВт нарны цахилгаан станцын хүчин чадлыг нэмэгдүүлэх,
- Азийн хөгжлийн банк”-ны санхүүжилтээр Завхан аймгийн Алдархаан сумд 5 МВт-ын хүчин чадалтай нарны цахилгаан станц барих төслийн нэгж байгуулагдан ТЭЗҮ болон бусад холбогдох тооцоо судалгаа хийгдэн, тендер шалгаруулалтын шатандаа явагдаж байна.

Тулгамдаж буй асуудал

- 1.АУЭХС-ийг 110 кВ-ын хүчдэлийн түвшинд бүрэн шилжүүлэн чадлын дамжуулах чадварыг нэмэгдүүлэх, жилээс жилд өсөн нэмэгдэж байгаа хэрэглээг хангахын тулд шинэ эх үүсгүүрийн асуудлыг шийдвэрлэх
- 2.“Тайширын усан цахилгаан станц төсөл”-ийн урт хугацаат зээлийн 42.8 тэрбум төгрөгийг чөлөөлж, улсын төсвийн хөрөнгө оруулалт хэлбэрээр шийдвэрлүүлэх
3. Монгол Улсын дээд шүүхийн хяналтын шатны захиргааны хэргийн шүүхийн шийдвэрээр үүссэн үл хөдлөх хөрөнгийн нөхөн татварын 437.0 сая төгрөгийн өр төлбөрийн асуудлыг шийдвэрлэх.



“ДУЛААН ШАРЫН ГОЛ” ТӨХК

Түүхэн замнал

“Дулаан Шарын гол” ТӨХК нь Шарын гол сумын хэрэглэгчдийг цэвэр ус, дулаанаар хангаж, бохир усыг татан зайлуулах үүрэгтэйгээр Шарын голын уурхайн уурын зуухны цех хэлбэрээр анхны суурь тавигдсан түүхтэй. 2003 оныг хүртэл “Шарын гол” ХК-ийн харъяа Дулаан үйлдвэрлэл шугам сүлжээний газар нэртэйгээр аж ахуйн тооцоотой ажиллаж байсан. Монгол улсын засгийн газрын 2003 оны 180-р тогтоолоор орон нутгийн өмчит улсын үйлдвэрийн газар, 2005 оны Дархан Уул аймгийн ИТХ-н 57-р тогтоолоор Орон нутгийн өмчит хувьцаат компани болгон өөрчлөн зохион байгуулсан. 2009 оны Засгийн газрын шийдвэрээр Төрийн өмчийн хорооны 2010 оны 03 сарын 25-ны өдрийн 121 тоот тогтоолоор Төрийн өмчит хувьцаат Компаний хэлбэрээр зохион байгуулагдан 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 65,3 сая төгрөгийн хувьцаатай төрийн өмчит хувьцаат компанийн хэлбэрээр ажиллаж байна.

Эрхэм зорилго

Чанартай бүтээгдэхүүн, Найдвартай жигд ажиллагаа үр ашиг

Товч танилцуулга

Шарын гол сумын 1134 айл өрх, 128 аж ахуй нэгж, 14 төсвийн байгууллагыг дулааны эрчим хүч, хэрэгцээний халуун, хүйтэн усаар хангах тэдгээрийн бохир усыг татан зайлуулахаар 7,5 км хос дулааны шугам, 17 км цэвэр усны шугам, 12 км бохир усны шугам, 19,6 мВт дулааны эрчим хүч үйлдвэрлэх хүчин чадалтай DZL маркийн 4 зуухтай, гэр хорооллын айл өрхүүдэд зөөврийн усаар хангах 4 ус түгээх байр, 24 цагийн ажиллагаатай 2 ухаалаг ус түгээх байртай, 2019 оны 01-р сарын тогтоолоор батлагдсан 1 алба, 3 хэлтэс, 2 хэсэг нэгжтэй нийт 115 ажилтны орон тоотойгоор Дулааны станц, дулааны сүлжээ, ус суваг, орон сууц нийтийн аж ахуйн байгууллагуудын үзүүлдэг үйлчилгээг цогцоор нь Дулааны станцын хэсэг, Ус дулаан ариутгах татуургын хэсэг, Санхүү борлуулалтын хэлтэс, Техникийн хэлтэс, Захиргаа удирдлагын хэлтэс, Хяналтын алба гэсэн үндсэн нэгжтэйгээр явуулж байна.

Компанийн хөрөнгө

Төрийн эзэмшлийн хувь: 100
Эзэмшигчийн өмч: 6 525 994 100 мян.төг
Нийт хувьцаа: 65 259 940 ширхэг
Хувьцааны нэрлэсэн үнэ: 100 төгрөг

Хэрэгжиж буй төсөл, хөтөлбөр

- ❖ 2017 - 2020 онд " *Инновацийг нэвтрүүлж, чанартай бүтээгдэхүүнээр хэрэглэгчдийг найдвартай ханган, өртөг зардлыг бууруулах* " зорилго дэвшүүлэн :
- ❖ дулаан дамжуулах 2,2 км төв шугамын шинэчлэлийн ажил,
- ❖ орон сууцны байруудыг зуны улиралд хэрэгцээний халуун усаар хангах,
- ❖ насосны станцуудыг хувьсах горимд шилжүүлсэн,
- ❖ гэр хорооллын ус түгээх худгуудын 24 цагийн ажиллагаатай ухаалаг системтэй ус түгээх байр болгосон
- ❖ Ус хийгүүжүүлэх төхөөрөмж / төмрийн үртсэн деаэратор/-ийг шинээр суурилуулан ашиглалтанд оруулсан.
- ❖ Сүлжээний усны насосны хүчин чадлыг нэмэгдүүлэн насосанд давтамж хувиргуур шинээр суурилуулсан.
- ❖ Эрчим хүчний аудитын зөвлөмжийн дагуу 1 трансформаторын хүчин чадлыг бууруулж, эрчим хүчний хэмнэлттэй трансформатораар шинэчилсэн.
- ❖ Компанийн төв байрыг өргөтгөн “Хэрэглэгчдэд үйлчлэх төв”-ийг шинээр байгуулсан
- ❖ Бохир усны насос станцыг бүрэн автоматжуулж, алсын удирдлагад шилжүүлсэн зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэд байна.

Үйл ажиллагааны чиглэл

- Дулааны эрчим хүч үйлдвэрлэх
- Дулааны эрчим хүч түгээх
- Дулааны эрчим хүчээр зохицуулалттай хангах
- Цэвэр ус олборлох, түгээх
- Бохир ус татан зайлуулах
- Усны тоолуур суурилуулах, засварлах
- 0,7-16,0 кг/см даралттай зуухны усралт, засвар түүний туршилт тохируулга, дагалдах ажил үйлчилгээ хийх

Компанийн удирдлага

➢ Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга: Д.Мөнхжаргал /ЭХЯ/

Гишүүд:



- 2.Б.Батдэлгэр-ЭХЯ-ны мэргэжилтэн
- 3.Б.Дэлгэрэл - ЭХЯ-ны мэргэжилтэн
- 4.Д.Оюунчимэг-ЭХЯ-ны шинжээч
- 5.Э.Мөнхтөр - ЭХЯ-ны мэргэжилтэн
- 6.Н.Ган-Эрдэнэ-ТӨБЗГ-ын мэргэжилтэн

Хараат бус гишүүд:

- 7.Н.Оюунбилэг-/Хараат бус гишүүн/
 - 8.Ш.Жавзансүрэн -/Хараат бус гишүүн/
 - 9.Ч.Алтантуяа-/Хараат бус гишүүн/
- Гүйцэтгэх захирал: Б.Энхцэцэг
- Ерөнхий инженер: Л.Нарангэрэл
 - Ерөнхий нягтлан бодогч: Ж.Даш

Сүүлийн 4 жилийн эдийн засгийн үзүүлэлт

Үзүүлэлт	2017	2018	2019	2020
Бүтээгдэхүүн үйлдвэрлэл /мян.Гкал/	39,8	37,6	38,2	38,8
Дотоод хэрэгцээний ДЭХ /мян.Гкал/	2,9	3,2	3,2	3,2
Түгээсэн дулаан /мян.Гкал/	36,9	34,4	35,0	35,6
Олборлосон ус /мян.м3/	448,4	422,1	383,5	320,0
Татан зайлуулсан бохир ус /мян.м3/	316,1	342,4	337,3	308,1
Нийт орлого /сая.төг/	2,517.8	3,123.9	3,093.9	3,041.6
Нийт зардал /сая.төг/	2,601.4	3,168.9	3,418.8	3,499.3
Цэвэр ашиг /сая.төг/	-83.6	-45.0	-324.9	-457.8
Авлага /сая.төг/	356.5	326.6	342.3	329.5
Өглөг /сая.төг/	1,346.7	1,462.6	1,673.2	1,812.1
Ажиллагсдын тоо	117	117	115	111



Тулгамдаж буй асуудал

1. Шарын гол сумын өсөн нэмэгдэх хэрэглээг хангах үүднээс дулааны станц, цэвэрлэх байгууламжийн өргөтгөл шинэчлэл хийх, түгээх шугам сүлжээг өргөтгөх,
2. Ашиглалтын хугацаа дууссан тоног төхөөрөмжүүдийг эрчим хүчний хэмнэлттэй, ашиглалтын зардал багатай тоног төхөөрөмжөөр үе шаттайгаар шинэчлэх
3. Нийгмийн даатгал, Татвар, Цахилгаан эрчим хүчний хуримтлагдсан өр төлбөрийн асуудал



“ХОВД ДУЛААНЫ СТАНЦ” ТӨХК

Түүхэн замнал

2014 оны 10 сарын 01-ны өдрөөс үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн. 2017 оны 05 сарын 02-ны Засгын газрын тогтоолоор Төрийн өмчит хувьцаат компани болсон.

Үйл ажиллагааны чиглэл

- Дулаан үйлдвэрлэх, түгээх, зохицуулалтай хангах

Компанийн удирдлага

- Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга:
Л.Мөнхцог-ЭХЯ-ны ахлах мэргэжилтэн

Гишүүд:

- 2.Б.Түмэнжаргал-ЭХЯ-ны шинжээч
- 3.М.Золжаргал- ЭХЯ-ны зохион байгуулагч
- 4.Ж.Саруул- ЭХЯ-ны мэргэжилтэн
- 5.Х.Бекболат-ЭХЯ-ны газрын дарга
- 6.Ө.Батбаатар-ТӨБЗГ-ын мэргэжилтэн

Хараат бус гишүүд:

- 7.Д.Нацагдорж
 - 8.Э.Ганчимэг
 - 9.Н.Оргодол
- Гүйцэтгэх захирал: Д.Энхсайхан
 - Үйлдвэрийн техникийн хэлтсийн дарга Ерөнхий инженер Т.Бямбатөмөр
 - Санхүү борлуулалтын албаны дарга, Ерөнхий нягтлан бодогч Ц.Энхмөрөн

Эрхэм зорилго

Ногоон үйлдвэрийг хөгжүүлэгч байгууллага болох,
Алсын хараа: Баруун бүсийн тэргүүлэгч байгууллага болох

Товч танилцуулга


Тус станц нь 2014 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн тоот улсын комиссын актаар ашиглалтад хүлээн авч 42 Мвт хүчин чадалтай 3 ширхэг зуухтайгаар үйл ажиллагаа явуулж эхлэсэн. **Манай компани нь** 2 хэлтэс 6 алба 107 ажилтан ажиллагсадтайгаар үйл ажиллагаа явуулж байна. 2014-2015 оны халаалтын жилд 589 айл өрх, 23 аж ахуйн нэгж, 15 төсөвт байгууллагатай хамтран ажилласан бол 2019-2020 оны халаалтын жилд хэрэглэгчдийн ачаалал 20 Гкал/цаг буюу 24 төсөвт байгууллага, 87 аж ахуйн нэгж, 1805 айл өрхийг дулааны эрчим хүчээр тасралтгүй найдвартай ханган ажиллаж байна.

Компанийн хөрөнгө

Төрийн эзэмшлийн хувь: 100
Эзэмшигчийн өмч: 11.485.711,20 мян.төг
Нийт хувьцаа: 13.285.935,0 ширхэг
Хувьцааны нэрлэсэн үнэ: 100 төгрөг

Сүүлийн 4 жилийн эдийн засгийн үзүүлэлт

Үзүүлэлт	2017	2018	2019	2020
Бүтээгдэхүүн үйлдвэрлэл /мян.Гкал/	39,104.85	43,949.77	45,118.69	50,344.9
Дотоод хэрэгцээний ДЭХ /мян.Гкал/	775.29	817.97	865.74	1,007.4
Түгээсэн дулаан /мян.Гкал/	38,329.56	4,3131.8	44,252.94	49,327.6
Нийт орлого /сая.төг/	2,056.68	2,209.92	2,395.6	2,891.9
Нийт зардал /сая.төг/	2,247.07	3,051.58	3,242.2	3,289.7
Цэвэр ашиг /сая.төг/	-190.38	-841.66	-847	-397.8
Авлага /сая.төг/	307.2	270.3	240.9	653.1
Өглөг /сая.төг/	214.99	859.2	1,159.2	1,486.6
Ажиллагсдын тоо	102	102	107	107



Хэрэгжиж буй төсөл, хөтөлбөр

- ❖ Байгаль Орчин аялал жуулчлалын яамнаас хэрэгжүүлж буй утааг бууруулах төсөл хэрэгжин турших шатандаа явж байна.

Тулгамдаж буй асуудал

1. Хэрэглэгчийн ачаалал дулааны эрчим хүч үйлдвэрлэх эх үүсвэрийн хүчин чадлаас хэтэрсэн. Эх үүсвэрийг өргөтгөж, хүчин чадлыг нэмэгдүүлэх.
2. Үйлдвэрлэсэн дулааны 62%-г 1805-н айл өрхөд өгч орлогын 14%-г бүрдүүлж байгаа нь алдагдал үүсэх шалтгаан болж санхүүгийн хувьд үйл ажиллагаа явуулахад хүндрэл учирч байгаа тул татаасын асуудлыг шийдвэрлэх.



“ХӨВСГӨЛ ДУЛААНЫ СТАНЦ” ТӨХК

Түүхэн замнал

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн 206 тоот тогтоолоор төрийн өмчит хувьцаат компани болгон зохион байгуулагдсан.

Үйл ажиллагааны чиглэл

- Дулааны эрчим хүч үйлдвэрлэх, дамжуулан түгээх, дулаанаар зохицуулалттай хангах

Компанийн удирдлага

- Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга:
Т.Батдондог-ЭХЯ-ны хэлтсийн дарга

Гишүүд:

Д.Төртулга -ЭХЯ-ны мэргэжилтэн
Б.Батдэлгэр -ЭХЯ-ны мэргэжилтэн
Д.Ариунзул - ЭХЯ-ны мэргэжилтэн
М.Оюундаваа -ЭХЯ

Г.Туул - ТӨБЗГ-ын мэргэжилтэн

Хараат бус гишүүд:

М.Дашдондог -/Хараат бус гишүүн/
Б.Пүрэвсүрэн -/Хараат бус гишүүн/
Д.Ганцэцэг -/Хараат бус гишүүн/

- Гүйцэтгэх захирал: Д.Цанлигрэнчин

- Ерөнхий инженер: Ш.Нямханд
- Ерөнхий нягтлан бодогч: В.Мөнгөнцэцэг

Эрхэм зорилго

Нийгмийн сайн сайхны төлөө ажил үйлсээ зориулж, өөрийн байгууллагын соёл, зан заншлаа эрхэмлэн хөгжлийн шинэ шатанд хүрч, иргэдэд дулааны эрчим хүчээр үйлчлэх үйлчилгээгээ хэрэглэгчийн эрэлт, хэрэгцээ, шаардлагад нийцүүлсэн үйл ажиллагаа явуулахад оршино.

Товч танилцуулга


“Хөвсгөл дулааны станц” ТӨХК нь 34МВт дулаан үйлдвэрлэх суурилагдсан хүчин чадалтай, усан халаалтын 3 ширхэг зуухтай, зуух тус бүр нь 10 Гкал/цаг дулаан үйлдвэрлэх хүчин чадалтай 115/70-ын температурын графикаар ажилладаг. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн 14 тоот тогтоолоор 155 ажилтантайгаар үйл ажиллагаа явуулахаар батлагдан ажиллаж байна

Компанийн хөрөнгө

Төрийн эзэмшлийн хувь: 100
Эзэмшигчийн өмч: 33,981,526.3 мян.төг
Нийт хувьцаа: 33,981,526.31 ширхэг
Хувьцааны нэрлэсэн үнэ: 1000 төгрөг

Сүүлийн 4 жилийн эдийн засгийн үзүүлэлт

Үзүүлэлт	2017	2018	2019	2020
Бүтээгдэхүүн үйлдвэрлэл /мян.Гкал/	64,551.2	73,425.2	74,056.81	80,701.5
Дотоод хэрэгцээний ДЭХ /мян.Гкал/	5,233.9	3,671.3	3,526.51	1,061.7
Түгээсэн дулаан /мян.Гкал/	59,317.9	69,753.9	70,530.3	79,639.8
Нийт орлого /сая.төг/	4,343.8	5,115.0	5,439.4	5,579.1
Нийт зардал /сая.төг/	4,573.7	5,327.1	6,213.8	6,481.6
Цэвэр ашиг /сая.төг/	(229.9)	(212.1)	(774.4)	(902.4)
Авлага /сая.төг/	157.3	774.4	1,478.3	1,003.5
Өглөг /сая.төг/	1,010.2	1,022.9	2,174.4	2,366.6
Ажиллагсдын тоо	133	147	154	154



Хэрэгжиж буй төсөл, хөтөлбөр

Байгаль орчин аялал жуулчлалын яамны Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооноос хэрэгжүүлж буй 4-н аймгийн Дулааны станцад утаа шүүх шүүлтүүр суурьлуулах төсөл.

Тулгамдаж буй асуудал

“Хөвсгөл Дулааны Станц” ТӨХК-д Зуух нэг бүр нь 11,63 Мвт дулаан үйлдвэрлэх хүчин чадалтай, 220тн/ц –ийн зарцуулалттай, 16 ата хүртэлх ажлын даралттай 115 С хүртэлх параметртэй дулааны эрчим хүчийг үйлдвэрлэж байна. Станцын нийт суурилагдсан хүчин чадал 34,8 мВт бөгөөд 2020 оны байдлаар давхардсан тоогоор 1920 хэрэглэгчийн дулаан тооцоот ачаалал 30 мВт хүрч нийт хүчин чадлын 88 хувиар ажиллаж байна.



“УЛААНГОМЫН ДУЛААНЫ ХОЁРДУГААР СТАНЦ” ТӨХК

Түүхэн замнал

Дулааны станц, ашиглалтын өмнөх захиргаа 2013 оны 11 сард байгуулагдан 2014 оны 09-р сарын 20-ноос ажилчдаа авч зуухны туршилт, горим тохируулагыг гүйцэтгэгчийн ажлын хэсэгтэй хамтран явуулж, 10 сард станцаа ашиглалтанд хүлээн авч үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн.

Үйл ажиллагааны чиглэл

- Дулаан үйлдвэрлэх, дамжуулах, түгээх

Компанийн удирдлага

➤ Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга:
Б.Баттөмөр /ЭХЯ/

Гишүүд:

- 2.Ч.Ганчимэг-ЭХЯ-ны зохион байгуулагч
- 3.Б.Түмэнжаргал-ЭХЯ-ны шинжээч
- 4.П.Давааням-ЭХЯ-ны мэргэжилтэн
- 5.Х.Энхчимэг-ТӨБЗГ-ын ах/мэргэжилтэн
- 6.А.Отгонбаатар-ЭХЯ

Хараат бус гишүүд:

- 7.Ч.Уранчимэг-/Хараат бус гишүүн/
- 8.Ё.Гантоого-/Хараат бус гишүүн/
- 9.Я.Содбаяр-/Хараат бус гишүүн
- Гүйцэтгэх захирал: Ю.Сайнжаргал
- Ерөнхий ижнелер: Б.Мөнгөн
- Санхүү, борлуулалтын алба Н.Сарнай

Эрхэм зорилго

Увс аймгийн нийгэм, эдийн засгийн хөгжлийн өсөлтийг хангахуйц дулааны эрчим хүчний бодлогыг хэрэгжүүлж, дулаан хангамжаар хүний эрүүл, аюулгүй, тав тухтай орчинд амьдрах болон үйлдвэрлэл, үйлчилгээний найдвартай, тогтвортой нөхцлийг хангахад оршино.

Товч танилцуулга

2018 оны 6 сарын 27-ны өдрийн 202 дугаартай Монгол Улсын засгийн газрын тогтоолоор “Улаангомьын дулааны 2-р станц” ТӨХК болсон. Үйл ажиллагаагаа явуулаад 6 жил Улаангомьын орон сууцны хэрэглэгч, төсөвт байгууллага, аж ахуйн нэгж байгууллагуудыг халаалт болон хэрэгцээний халуун усаар тасралтгүй найдвартай ханган ажиллаж байна. Одоогоор 93 хүний батлагдсан бүтэц орон тоотойгоор ажиллаж байна.

Компанийн хөрөнгө

Төрийн эзэмшлийн хувь: 100
Эзэмшигчийн өмч: 15,250,167,700 мян.төг
Нийт хувьцаа: 152,501,677 ширхэг
Хувьцааны нэрлэсэн үнэ: 100 төгрөг

Сүүлийн 4 жилийн эдийн засгийн үзүүлэлт


Үзүүлэлт	2017	2018	2019	2020
Бүтээгдэхүүн үйлдвэрлэл /мян.Гкал/	33.1	37.7	41.2	47.3
Дотоод хэрэгцээний ДЭХ /мян.Гкал/	2.5	2.5	4.1	
Түгээсэн дулаан /мян.Гкал/	30,6	35,2	37.1	44.9
Нийт орлого /сая.төг/	1,654.2	1,967.9	2,187.4	2,781.9
Нийт зардал /сая.төг/	2,828.9	2,27.5	2,926,4	3,239.9
Цэвэр ашиг /сая.төг/	-1,174.8	-659.5	-739.1	-458.1
Авлага /сая.төг/	226.5	195.3	215.8	267.8
Өглөг /сая.төг/	791.8	958.8	1,097.6	1,030.6
Ажиллагсдын тоо	82	90	92	90

Хэрэгжиж буй төсөл, хөтөлбөр

❖ Байгаль Орчны яамнаас хэрэгжүүлж буй утааг бууруулах төсөл хэрэгжин турших шатандаа явж байна

Тулгамдаж буй асуудал

1. Хэрэглэгчийн ачаалал дулааны эрчим хүч үйлдвэрлэх эх үүсвэрийн хүчин чадлаас хэтэрсэн. Хөрөнгийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх. санхүүгийн хувьд үйл ажиллагаа явуулахад хүндрэл учирч байгаа тул улсын төсвөөс татаас авах асуудлыг шийдвэрлэх шаардлагатай байна.





“АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ” ТӨХК

Түүхэн замнал

Монгол Улсын Засгийн газрын 35,55 дугаар тогтоолоор тус станцыг БНХАУ-ын Чайна машинойри инженеринг корпораци /СМЕС/ 2013.08.21-ний өдрөөс 2015.9.27-ны хооронд Хөгжлийн банкны санхүүжилтээр барьж байгуулсан. Засгийн газрын 2015 оны 371 дүгээр тогтоолоор ДЦС-4 ТӨХК-ийн охин компани хэлбэрээр, 2020 оны 71 дүгээр тогтоолоор 100% бие даасан ТӨХК болон өөрчлөн зохион байгуулагдсан.

Үйл ажиллагааны чиглэл

- Дулааны эрчим хүч үйлдвэрлэх

Компанийн удирдлага

- Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга:
Д.Даваасүрэн /ЭХЯ/

Гишүүд:

- 2.Д.Чимэдлхам-ЭХЯ-ны ахлах шинжээч
- 3.П.Давааням-ЭХЯ-ны мэргэжилтэн
- 4.Б.Нармандах-ЭХЯ-ны мэргэжилтэн
- 5.Б.Мөнхчулуун-ЭХЯ-ны мэргэжилтэн
- 6.Ч.Батчимэг-ТӨБЗГ-ын мэргэжилтэн

Хараат бус гишүүд:

- 7.Д.Самдан-/Хараат бус гишүүн/
- 8.Д.Золжаргал-/Хараат бус гишүүн/
- 9.А.Түмэнбаяр-/Хараат бус гишүүн/

- Гүйцэтгэх захирал: Ш.Баянмөнх

- Тэргүүн дэд захирал бөгөөд Ерөнхий инженер Ч.Цогтсайхан
- Санхүү, хангамжийн асуудал эрхэлсэн дэд захирал Б.Цэндээ
- Санхүү, эдийн засгийн хэлтсийн дарга бөгөөд Ерөнхий нягтлан бодогч Ч.Бямбаа

Эрхэм зорилго

Орчин үеийн дэвшилтэт технологиор эрчим хүчний системийн найдвартай ажиллагааг хангахад оршино.

Товч танилцуулга

Амгалан дулааны станц ТӨХК нь 348 Мвт-ийн суурилагдсан хүчин чадалтай, эргэлтэт буцлах давхаргат шаталт бүхий QXF116-1.6/130/70 маркийн 3 зуухтай, цагт дунджаар 4800 тн усыг 120° хүртэл халаадаг, жилд дунджаар 626.5 мян.Гкал дулааны эрчим хүч үйлдвэрлэдэг, зуухнаас гарсан утааны хийнээс үнс, тоосонцорыг 99% шүүдэг үнсний уутат шүүлтүүртэй, нүүрсийг нар, салхи бороноос хамгаалсан 20000 м куб эзэлхүүнтэй нүүрсний агуулахтай. Тус станц нь 181 ажилтантай 3 цех, 4 хэлтэстэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна.

Компанийн хөрөнгө


Төрийн эзэмшлийн хувь: 100
Эзэмшигчийн өмч: 105,323,439 мян.төг
Нийт хувьцаа: 1,099,343,672 ширхэг
Хувьцааны нэрлэсэн үнэ: 100 төгрөг

Тулгамдаж буй асуудал


1. Дулаан цахилгаан хослон үйлдвэрлэдэг дулааны цахилгаан станц болгон өөрчилж, бүтээгдхүүний өртөгийг хямдруулж, алдагдлыг бууруулах
2. Тус станцын төсөлд үнсэн сан тусгагдаагүй учир зуухны галлагаанаас гарсан үнсийг автомашинаар тээвэрлэн ДЦС-4 ТӨХК үнсэн санд хаяж, ихээхэн хэмжээний үргүй зардал гаргахаас гадна байгаль орчинд сөрөг нөлөөтэй байгаа нь тус тус тулгамдсан асуудал болж байна.

Сүүлийн 4 жилийн эдийн засгийн үзүүлэлт

Үзүүлэлт	2017	2018	2019	2020
Бүтээгдэхүүн үйлдвэрлэл /мян.Гкал/	534.7	640.7	729.4	761.6
Дотоод хэрэгцээний ДЭХ /мян.Гкал/	13.04	12.45	13.55	13.2
Түгээсэн дулаан /мян.Гкал/	522.3	627.9	729.4	748.4
Нийт орлого /сая.төг/	13.264.8	17.956.4	19.969.2	21,012.0
Нийт зардал /сая.төг/	19.251.9	24.016.1	26.324.7	28,407.5
Цэвэр ашиг /сая.төг/	-6.042.1	-6.323.4	-6.611.3	-7,696.2
Авлага /сая.төг/	11.9	2.873.6	1.772.4	925.2
Өглөг /сая.төг/	298.7	2.515.7	1.677.9	4,590.8
Ажиллагсдын тоо	176	181	181	186



Түгээсэн дулаан /мян,Гкал/





“БАЯНЧАНДМАНЬ АЗЗА” ТӨХК

Түүхэн замнал

Нийт зардал /сая.төг/	67,844.4	76,984.2	96,334.8	151,215.2
Цэвэр ашиг /сая.төг/	15,713.2	7,842.8	34,446.2	48,211.7
Авлага /сая.төг/	3,986.1	3,501.9	1,960.4	5,643.7
Өглөг /сая.төг/	68,705.7	68,575.5	61,570.0	46,137.2
Ажиллагсдын тоо	1,317	1,233	1,309	1,503



Хэрэгжиж буй төсөл, хөтөлбөр

- ❖ Хэнтий аймгийн Дархан сумын нутагт орших төмрийн хүдрийн “Баргилт” ордыг ашиглах төсөл.
- ❖ Өргөн”-ийн ордын кальцитын өндөр агуулгатай хайлуур жоншны хүдрийг “Бор-Өндөр” УБҮ-ийн Баяжуулах Фабрикт боловсруулах технологийн шинэ шийдлүүдийг нэвтрүүлэх.
- ❖ Төв аймгийн Заамар сумын нутагт орших “Цэцэг Мандал” ордыг ашиглах төсөл.
- ❖ Төв аймгийн Заамар сумын нутагт орших Хашаат овоот даваат, Урт сайр болон Галтын талбайнууд геологи хайгуулын ажил хийх төсөл.

Тулгамдаж буй асуудал

1. Засгийн газрын 260 тогтоолын алдаа зөрчлийг арилгах зорилгоор Засгийн газрын 289-р тогтоолоор баталсан усны сан бүхий газрын хилийн заагаас MV-00175 тоот тусгай зөвшөөрлийн талбайн солбицол бүхий талбайг хасч тооцох тухай Засгийн газрын тогтоолыг гаргаж уг талбай дээрх үйл ажиллагааг сэргээх.



“МОНГОЛ КУВЕЙТЫН БАЙГАЛЬ ХАМГААЛАХ ТӨВ” ТӨҮГ

Түүхэн замнал

- ✓ 2007-11-28 “Хүрээлэн буй орчныг хамгаалах салбарт хамтран ажиллах тухай” Монгол Улсын Засгийн газар, Кувейт Улсын Засгийн газар хоорондын санамж бичигт гарын үсэг зурсанаар Монгол-Кувейтын судалгааны төв байгуулагдсан.
- ✓ 2008 онд барилгын шавыг тавьж, барилга угсралтын ажлыг хийж гүйцэтгэсэн.
- ✓ 2016 онд Төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрлэлийн газар болсон.

Үйл ажиллагааны чиглэл

- Байгаль орчин, аялал жуулчлалын чиглэлээс судалгаа, шинжилгээ хийх, эко аялал жуулчлалыг хөгжүүлэх, мэдээлэл, сургалт, сурталчилгааны ажил зохион байгуулах

Үйлдвэрийн газрын удирдлага

- Захирал: Ц. Баяр-Эрдэнэ
- Ерөнхий нягтлан бодогч: Д.Наран

Эрхэм зорилго


Монгол Кувейт хоёр орны хооронд байгуулагдсан байгаль орчны салбарт байгуулсан аливаа санамж бичиг, гэрээ хэлэлцээр, хамтын ажиллагааны протокол, тогтоожмоор хүлээсэн үндсэн үүрэг, зорилтыг хангах гол хүчин зүйл болохуйц чадавхи бүхий олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөгдөхүйц эрдэм шинжилгээ, судалгааны төв байгууллага болох юм.

Товч танилцуулга

“Монгол-Кувейтын байгаль хамгаалах төв” ТӨҮГ нь Богдхан уулын Дархан цаазат газрын эко-системийн тэнцвэрт байдлыг хамгаалах сургалт, эрдэм шинжилгээний хурал цуглаан зохион байгуулах, мэдээлэл, аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулах ба эрдэм шинжилгээний хүрээлэн, их, дээд сургууль, төрийн болон төрийн бус байгууллагуудын үйл ажиллагаатай нягт уялдаа холбоотой ажиллаж олон улсын түвшинд хүргэх зорилго бүхий байгууллага юм.

Сүүлийн 4 жилийн эдийн засгийн үзүүлэлт

Үзүүлэлт	2017	2018	2019	2020
Нийт орлого /мян.төг/	341,494.9	486,964.7	708,320.7	496,381.8
Нийт зардал /мян.төг/	525,713.0	778,559.3	565,974.7	724,086.6
Цэвэр ашиг /мян.төг/	-184,218.1	-291,594.6	128,111.4	-227,704.8
Авлага /мян.төг/	36,319.2	6,375.1	12,205.6	5,335.2
Өглөг /мян.төг/	22,349.1	25,200.0	174,740.9	154,375.3
Ажиллагсдын тоо	14	13	8	12



Үйлдвэрийн газрын хөрөнгө

Төрийн эзэмшлийн хувь: 100%
Эзэмшигчийн өмч: 7,705,488,984.51 төг

Тулгамдаж буй асуудал

1. Ашиглалтын зардал өндөр.
2. Байшин барьсан газар цэвдэгтэй учраас элэгдэл маш хурдацтай явагдаг.
3. Байшинд ан цав их үүссэн. Их засвар хийх шаардлагатай.
4. Төрийн байгууллагуудтай хамтын ажиллагаа сайжруулан орлогын эх үүсвэр бий болгох

“АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ХӨГЖЛИЙН ТӨВ” ТӨҮГ

Түүхэн замнал

2017.01.04 Монгол Улсын Засгийн газрын 2 дугаар тогтоолоор “Аялал жуулчлалын хөгжлийн төв” Аж Ахуйн Тооцоотой Төрийн Өмчит Үйлдвэрийн Газрыг байгуулах шийдвэр гарсан.

Үйл ажиллагааны чиглэл

- Аялал жуулчлалын менежмент, боловсон хүчнийг чадавхижуулах, сургалт зохион байгуулах, ижил түвшний байгууллагуудтай хамтран ажиллах, олон улсын хэмжээний өдөрлөг, арга хэмжээ зохион байгуулах, Зочид буудал, жуулчны баазад зэрэглэл тогтоох, Аялал жуулчлалын байгууллагын гэрчилгээ олгох үндсэн чиглэлтэй.

Үйлдвэрийн газрын удирдлага

- Захирал: С.Бат-Эрдэнэ
- Ерөнхий нягтлан бодогч: Т.Энхцэцэг

Үйлдвэрийн газрын хөрөнгө

Төрийн эзэмшлийн хувь: 100%
Эзэмшигчийн өмч: 3778.00 мян.төг

Эрхэм зорилго


Олон Улсын түвшинд өрсөлдөх чадвар бүхий Маркетинг, Менежменттэй мэргэжлийн байгууллага болно.

Товч танилцуулга

- 2017.01.04 Монгол Улсын Засгийн газрын 2 дугаар тогтоолоор “Аялал жуулчлалын хөгжлийн төв” Аж Ахуйн Тооцоотой Төрийн Өмчит Үйлдвэрийн Газрыг байгуулах шийдвэр гарсан.
- 2017.05.23 Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 253 тоот тогтоолоор АЖХТ-ийн дүрмийг батлаж, орон тооны дээд хязгаарыг 17 байхаар тогтоосон.
- 2017.05.24 Оюуны өмч, улсын бүртгэлийн газарт албан ёсоор бүртгүүлэн, гэрчилгээ, тамга авсан.

Сүүлийн 4 жилийн эдийн засгийн үзүүлэлт

Үзүүлэлт	2017	2018	2019	2020
Нийт орлого /сая.төг/	93.3	118.2	357.8	91.6
Нийт зардал /сая.төг/	92.0	146.0	346.2	239.6
Цэвэр ашиг /сая.төг/	1.2	(27.7)	9.7	-148.0
Авлага /сая.төг/	-	-	0.3	4.9
Өглөг /сая.төг/	23.2	65.8	462.5	520.9
Ажиллагсдын тоо	5	3	8	12



Хэрэгжиж буй төсөл, хөтөлбөр

- ❖ БОАЖЯам, ADB хамтарсан “Тогтвортой Аялал Жуулчлалыг Хөгжүүлэх” төсөл-1. Уг төсөл нь Хөвсгөл аймаг, Хэнтий аймагт хэрэгжиж байна.
- ❖ “Хариуцлагатай аялцаа аян”-ыг ЦЕГ-ын Экологийн Цагдаагийн албатай хамтран хэрэгжүүлж байна.

Тулгамдаж буй асуудал

- 2020 онд Ковид вирустэй холбоотойгоор үүссэн нөхцөл байдлаас шалтгаалан 2020 оны БОАЖЯ-тай байгуулсан “Эрх шилжүүлж, ажил гүйцэтгэх гэрээ”-ний дагуух төсөв орж ирээгүй. Мөн ихэнхи гүйцэтгэх ажлууд цуцлагдсан байдалтай байна.

“ГЕОЛОГИЙН ТӨВ ЛАБОРАТОРИ” ТӨҮГ

Түүхэн замнал

Геологийн зураглал, хайгуул, шинжилгээний ажлыг эрчимжүүлэх, эрдсийн задлан шинжилгээгээр эцсийн үр дүнг гаргах зорилгоор БНМАУ-ын сайд нарын зөвлөлийн 1957 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн 461 дүгээр тогтоолоор “Эрдэм шинжилгээний төв лаборатори”-ийг анх байгуулсан түүхтэй.

Үйл ажиллагааны чиглэл

- Эрдсийн түүхий эдийн шинжилгээ, судалгаа
- Ашигт малтмалын баяжигдах шинж чанарын технологийн туршилт
- Байгаль орчны судалгаа, шинжилгээ (цианид, мөнгөн ус, хүнд металл)
- Аттестатчилсан стандартчилсан загварын үйлдвэрлэл, борлуулалт
- Ур чадварын сорилт зохион байгуулах
- Чулуун бүтээгдэхүүн үйлдвэрлэл, борлуулалт

Үйлдвэрийн газрын удирдлага

- Захирал: **Э.Тэгшжаргал**
- Ерөнхий нягтлан бодогч: **М.Хоролсүрэн**

Үйлдвэрийн газрын хөрөнгө

Төрийн эзэмшлийн хувь: 100 %
Эзэмшигчийн өмч: 13,193.5 мян.төг

Эрхэм зорилго

Орчин үеийн шинжлэх ухаан, технологийн хөгжилтэй мөр зэрэгцэн, Монгол улсын эрдсийн түүхий эдийн шинжилгээ судалгааны ажлыг олон улсын стандартын түвшинд нийцүүлэн гүйцэтгэх.

Товч танилцуулга

Геологийн төв лаборатори нь Монгол орны нутаг дэвсгэрт хийдэж байгаахяналтын шинжилгээг цогцоор гүйцэтгэхийн зэрэгцээ аттестатилчсан стандартчилсан загвар үйлдвэрлэл, ур чадварын сорилт зохион геологийн судалгааны лабораторийн шинжилгээний ажил, уул уурхайн бүтээгдэхүүний экспортын болон гаалийн байгуулах үндсэн үйл ажиллагааг хэрэгжүүлдэг. Үндэсний болон олон улсын MNS ISO/IEC 17025, ISO 17034 болон ISO/IEC 17043 стандартуудыг үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн, олон улсын түвшинд өрсөлдөх чадвартай мэргэжлийн байгууллага юм. Дээж боловсруулалтаас шинжилгээ гүйцэтгэх хүртэлх үйл ажиллагаанд орчин үеийн, өндөр нарийвчлалтай, дэвшилтэт тоног төхөөрөмжүүдийг ашиглан, элементийн агуулгыг 10^{-6} аас 10^{-9} буюу ppm-ppb-ийн түвшинд тодорхойлдог.

Сүүлийн 4 жилийн эдийн засгийн үзүүлэлт

Үзүүлэлт	2017	2018	2019	2020
Нийт орлого /сая.төг/	3,426.9	4,276.3	4,230.4	3,517.8
Нийт зардал /сая.төг/	3,107.8	3,873.0	4,596.2	3,386.3
Цэвэр ашиг /сая.төг/	319.1	403.3	-366.8	118.6
Авлага /сая.төг/	1,383.3	1,324.2	1,010.0	1,209.3
Өглөг /сая.төг/	1,229.8	954.7	1,276.2	754.8
Ажиллагсдын тоо	158	158	158	158


Хэрэгжиж буй төсөл, хөтөлбөр

- ❖ Финляндын геологийн албатай хамтын ажиллагааг үргэлжлүүлж, ашигт малтмалын баяжигдах шинж чанарын судалгааны чиглэлээр хэрэгжүүлэх шинэ төслийн анхны хэлэлцүүлэг амжилтай явагдаж, харилцан тохиролцоонд хүрсэн.
- ❖ Аттестатчилсан стандартчилсан загварын үйлдвэрлэлээр зэсийн баяжмал болон хөрсний АСЗ үйлдвэрлэх 3 төсөл хэрэгжүүлж байна
- ❖ Нүүр болон хүдрийн ур чадварын сорилтын хөтөлбөрийн 8-р тойргийг зохион байгуулж байна.

Тулгамдаж буй асуудал

1. Улсын төсвийн хөрөнгөөр хийгдэж байгаа геологи хайгуулын ажлын лабораторийн шинжилгээ, уул уурхайн экспортын бүтээгдэхүүний шинжилгээг бүрэн гүйцэтгүүлэх тал дээр дээд шатны байгууллагын дэмжлэг авах,
2. 1974 онд ашиглалтад орсноор хойш ГТЛ-ийн барилгад капитал засвар хийгдээгүй бөгөөд тус барилгын сантехникийн болон цахилгааны шугам сүлжээг цогцоор шинэчлэх,

2017-2020 оны үр дүнгийн харьцуулалт





“ГЕОЛОГИЙН СУДАЛГААНЫ ТӨВ” ТӨҮГ

Түүхэн замнал

Геологи, Эрдэс Баялагийн сайдын (хуучнаар) 1993 оны 01 сарын 18-ны өдрийн 09 тоот тушаалаар анх **“Цахиур” УУГ**-ыг шинээр зохион байгуулсан бөгөөд хожим нь төрийн өмчийн оролцоотой Цахиур компани, Геохими, Геофизикийн судалгааны товчоо зэрэг газруудыг нэгтгэн Хөдөө аж ахуй, үйлдвэрийн яамны (хуучнаар) сайдын 1997 оны А/304 тоот тушаалаар **“Геологийн судалгааны товчоо” (ТӨҮГ)** нэртэйгээр байгуулагдсан. Товчоог Худалдаа үйлдвэрийн сайдын 2000 оны 11 сарын 03 өдрийн А/29 тоот тушаалаар уг товчоог **“ГЕОЛОГИЙН СУДАЛГААНЫ ТӨВ (Төрийн Өмчит Үйлдвэрийн Газар)”** гэж нэрлэх болсон байна.

Үйл ажиллагааны чиглэл

- Төрөл бүрийн масштабтай геологийн зураглал, ерөнхий эрлийн ажил, агаарын болон тандан судалгаа, геологийн мэдээлэл боловсруулах, эрдсийн шинжилгээ, өрөмдлөг, ашигт малтмалын геохимийн судалгаа, геофизик, ордын эрэл, эрэл-үнэлгээ, хайгуул

Үйлдвэрийн газрын удирдлага

- Захирал: Н.Ганболд
- Ерөнхий инженер: Г.Мөнхзул
- Ерөнхий нягтлан бодогч: Т.Батбилэг

Үйлдвэрийн газрын хөрөнгө

Төрийн эзэмшлийн хувь: 100%
Эзэмшигчийн өмч: 232 740 мян.төг

Эрхэм зорилго


Бид Монгол орны геологи, ашигт малтмалын эрэл, эрэл-үнэлгээ, геохими, сансрын зураг, тандан судалгааны зэрэг геологийн бүхий л төрлийн мэдээлэл судалгааны ажлыг орчин үеийн ойлголт, шинжлэх ухааны үндэслэлтэй гүйцэтгэж байгаа бөгөөд цаашид өрөмдлөгийн тоног төхөөрөмжийн шинэчлэл, орчин үеийн геофизикийн судалгааны багаж, тоног төхөөрөмжүүдэд суурилсан мэргэжлийн хүний нөөцийг чадавхжуулан, геологи-хайгуулын ажлыг цогц хэлбэрээр гүйцэтгэдэг мэргэшсэн байгууллага болох

Товч танилцуулга

Тус төв нь Монгол орны нийт нутаг дэвсгэрийн 60 гаруй хувьд төрөл бүрийн масштабтай геологийн зураглал, геохимийн судалгаа, геофизик, ерөнхий эрэл, эрэл, эрэл-үнэлгээний ажлуудыг хийж гүйцэтгэсний дотор өнөөдрийн байдлаар 9 үндсэн нэгжтэй, региональ геологийн зураглал болон эрэл, геохими гидрогеологийн чиглэлээр мэргэшсэн шинжлэх ухааны доктор 2, салбарын доктор 3, докторант 4, магистр болон бакалавр зэрэгтэй 70 гаруй үндсэн геологич инженерүүд, 50 гаруй гэрээт болон улирлын ажилтан, ажилчидтай, магадлан итгэмжлэгдсэн чулуулаг-эрдэс судлалын лаборатори, геологийн болон сансрын иж бүрдэл зураг боловсруулах орчин үеийн программ хангамж, өндөр мэдрэмжтэй тоног төхөөрөмжөөр тоноглогдсон мэдээлэл боловсруулах хэсэг, өрөмдлөгийн нэгдсэн бригад, машин техниктэй ажиллаж байна. Гадаад хамтын ажиллагааны хүрээнд 1994 оноос Япон, Герман, Хятад, Солонгос, Орос, Казакстан, Чех улсуудтай хамтран Региональ судалгаа, геохими, эрэл хайгуулын 20 гаруй төслүүдийг амжилттай хэрэгжүүлсэн.

Сүүлийн 4 жилийн эдийн засгийн үзүүлэлт

Үзүүлэлт	2017	2018	2019	2020
Нийт орлого /сая.төг/	2,626.9	5,988.6	12,349.8	5,033.9
Нийт зардал /сая.төг/	2,217.2	5,473.6	9,559.0	4,780.6
Цэвэр ашиг /сая.төг/	387.0	455.6	2,502.9	222.6
Авллага /сая.төг/	36.6	22.4	201.8	350.6
Өглөг /сая.төг/	184.4	198.3	431.7	283.3
Ажиллагсдын тоо	62	105	120	130



Хэрэгжиж буй төсөл, хөтөлбөр

- Улсын төсвийн хөрөнгөөр
- ❖ “Бүс нутгийг хөгжүүлэх хөтөлбөрийн хүрээнд Голлох ашигт малтмалын хэтийн төлвийн судалгаа” төсөл
 - ❖ “Хойд, төв, зүүн азийн гүний геологийн процесс ба металлогени” Олон улсын төсөл (Монгол-БНХАУ-БНСУ-БНКаЗУ-ОХУ)
 - ❖ “Геомэдээллийн сан-2019” төсөл
 - ❖ Овоот толгой-50 төсөл

Тулгамдаж буй асуудал

1. Автомашины 90 хувь нь хуучирсан, хүрэлцээ муу байгаагаас түрээсээр гадны машин ашиглахад хүрч байна. Мөн лабораторийн зарим багаж тоног төхөөрөмж, техник хэрэглэлүүд цаашид ашиглах боломжгүй, ашиглалтын хугацаа дууссан.
2. Тус төвийн аж ахуйн аргаар орлого олох гол техник болох өрөмдлөгийн машин нь ашиглалтын хугацаа дуусч, засвар ихээр шаардагдах болсон.
3. Геологийн зураглал, хайгуулын орчин үеийн техник хэрэгсэл дутмаг.



ЦЕГ-ЫН “ЦАГААН ШОНХОР” ТӨҮГ

Түүхэн замнал

ЦЕГ-ын даргын 1992 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн 168 дугаар тушаалаар Цагдаагийн байгууллагын хэрэгцээт зарим хувцас, хүнс үйлдвэрлэх, техник тоног төхөөрөмж бэлтгэн нийлүүлж байх үүрэг бүхий үйлдвэр, үйлчилгээ, худалдааны “Цагаан шонхор” компанийг байгуулсан.

Үйлдвэрийн газрыг бүрэн бус хариуцлагатай аж ахуйн нэгжээр бүртгүүлэн, дүрмийг баталж, захирлаар нь дэд хурандаа Эрэгдэндагвын Батмөнхийг томилсон.

1993 онд 1 мастер /эсгүүрчин/, 4 оёдолчин, оёдлын 3 машинтайгаар оёдлын цехийн үйл ажиллагааг эхэлсэн түүхтэй.

Үйл ажиллагааны чиглэл

- Цагдаагийн албан хаагчдын дүрэмт хувцас хэрэглэл
- Цагдаагийн албан хаагчдын хэрэгцээт бараа, материал тоног төхөөрөмжийн бэлтгэн нийлүүлэлт, гадаад худалдаа

Үйлдвэрийн газрын удирдлага

- Захирал: Б.Ариунзаяа
- Ерөнхий нягтлан бодогч: Ц.Цэнгэлмаа

Эрхэм зорилго

Чанартай бүтээгдэхүүн, соёлч шуурхай үйлчилгээгээр хэрэглэгчдийг баярлуулан үднэ.


Товч танилцуулга

ЦЕГ-ын “Цагаан шонхор” ТӨҮГ нь 1992 онд ЦЕГ-ын даргын тушаалаар байгуулагдаж, Төрийн Өмчийн Бодлого Зохицуулалтын Газрын 2017 оны 05 дугаар сарын 31 өдрийн 255 дугаар тогтоолоор дүрэм, зохион байгуулалтын бүтэц, албан тушаалын жагсаалт орон тооны хязгаарыг шинэчлэн батлуулж 28 дахь жилдээ үйл ажиллагаагаа явуулж байна.

Тус газар нь Цагдаа, Дотоодын цэрэг, Хууль сахиулах их сургууль, Гадаадын иргэн харьяатын газрын алба хаагчдын хувцас хэрэглэл бэлтгэн нийлүүлэх, цагдаагийн алба хаагчдын дүрэмт хувцсанд хийх шинэчлэлийн арга хэмжээнд оролцох чиг үүрэгтэй байгуулагдсан төрийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар юм.

Сүүлийн 4 жилийн эдийн засгийн үзүүлэлт

Үзүүлэлт	2017	2018	2019	2020
Нийт орлого /сая.төг/	625.9	716.6	812.1	804.1
Нийт зардал /сая.төг/	582.8	705.9	747.9	778.1
Цэвэр ашиг /сая.төг/	37.1	7.6	56.7	23.2
Авлага /сая.төг/		0.1	206.9	40.7
Өглөг /сая.төг/		40.4	325.9	40.1
Ажиллагсдын тоо	60	54	50	50




Үйлдвэрийн газрын хөрөнгө

Төрийн эзэмшлийн хувь: 100%
Эзэмшигчийн өмч: 59,469.0 мян.төг

Тулгамдаж буй асуудал

1. Харьяалалын асуудлыг шийдүүлэх:
2. Шууд гэрээгээр ажил авдаг болох:
3. Үйлдвэрийн байрыг шинэчлэх:



“СЭРГЭЭГДЭХ ЭРЧИМ ХҮЧНИЙ ҮНДЭСНИЙ ТӨВ” ТӨҮГ

“СЭРГЭЭГДЭХ ЭРЧИМ ХҮЧНИЙ ҮНДЭСНИЙ ТӨВ” ТӨҮГ

“Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв” Төрийн Өмчит Үйлдвэрийн Газар /СЭХҮТ ТӨҮГ/ нь Монгол оронд сэргээгдэх эрчим хүчийг ашиглах чиглэлээр сургалт, судалгаа, туршилт, угсралт суурилуулалт, засвар үйлчилгээ, үйлдвэрлэл, сэргээгдэх эрчим хүчний барилга байгууламжид техникийн хяналт тавих, хүлэмжийн хийн ялгаралын бууралтыг магадлах, нотлох чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн өмчийн үйлдвэрийн газар юм.

Тус төв нь Сэргээгдэх эрчим хүчний шинжлэх ухаан, үйлдвэрлэлийн нэгдэл (СЭХШУҮН) гэв нэртэйгээр байгуулагдсан.

Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв, Нарны зайн үйлдвэр, “100000 нарыг гэр” төслийг нэгтгэж Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв нэртэйгээр байгуулагдав.

“Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв” Төрийн өмчит үйлдвэрийн газар нэртэйгээр ажиллаж байна.

1989 ОН 2005 ОН 2009 оноос

ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Монгол орны нөхцөлд сэргээгдэх эрчим хүчийг ашиглах, шинэ болон дэвшилтэт техник, технологийг судалж нутагшуулах чиглэлээр туршилт, судалгааны ажлуудыг хийх, зураг төсөл зохиох, ТЭЗҮ боловсруулах, тусгай зөвшөөрлийн хүрээнд эрчим хүчний зарим барилга байгууламж барих, угсралт суурилуулалтын болон засвар үйлчилгээний ажил, хүлэмжийн хийн ялгарлын бууралтын магадлагаа нотолгооны ажил, техникийн хяналт тавих ажлыг хэрэгжүүлж байна.



КОМПАНИЙН ХӨРӨНГӨ

- Төрийн эзэмшлийн хувь: 100 хувь
- Эзэмшигчийн өмч: 2.1 тэрбум төгрөг


Д/д	ҮЗҮҮЛЭЛТ /сая.т/	ОН		
		2017	2018	2019
1	Нийт орлого	885	1,605.0	852.4
2	Нийт зардал	514	1,086.6	1,005.6
3	Татварын өмнөх ашиг	414	518.4	-153.2
4	Татварын зардал	42.6	54.2	0.09
5	Цалингийн сан	253	364.9	380.1
6	ТӨБЗГ-т шилжүүлсэн ногдол ашиг	-	37.2	10
7	Ажиллагсдын тоо	-	37	36
8	Цэвэр ашиг	372	464.2	-153.2



Инноваци, смарт хөтөлбөрийн хүрээнд:

- Нарны үүсгүүрүүдийг суурилуулж дуусаад байна.
- Цахилгаан автомашин цэнэглэх зогсоолыг ашиглалтад оруулав.





“Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв” ТӨААТҮГ

Түүхэн замнал

- БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1988 оны 212 дугаар тогтоолоор 1989 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс “Сэргээгдэх эрчим хүчний шинжлэх ухаан-үйлдвэрлэлийн нэгдэл”;
- Монгол Улсын Засгийн газрын 2005 оны 160 дугаар тогтоолоор Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв;
- Төрийн өмчийн хорооны 2009 оны 58, 146 дугаар тогтоолоор “Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв” төрийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар

Эрхэм зорилго

Үндэсний хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөж, Олон улсад үйл ажиллагаа явуулдаг байгууллага болох

Товч танилцуулга

Монгол орны нөхцөлд сэргээгдэх эрчим хүчийг ашиглах, шинэ болон дэвшилтэт техник, технологийг судалж нутагшуулах чиглэлээр туршилт, судалгааны ажлуудыг хийх, зураг төсөл зохиох, ТЭЗҮ боловсруулах, тусгай зөвшөөрлийн хүрээнд эрчим хүчний зарим барилга байгууламж барих, угсралт суурилуулалтын болон засвар үйлчилгээний ажил, хүлэмжийн хийн ялгарлын бууралтын магадлагаа нотолгооны ажил, техникийн хяналт тавих ажлыг хэрэгжүүлж байна.

Компанийн хөрөнгө

Төрийн эзэмшлийн хувь: 100 хувь
Эзэмшигчийн өмч: 2,158,372.1 мянган төгрөг
Эргэлтийн хөрөнгө: 417,312.3 мянган төгрөг
Үндсэн хөрөнгө: 1,741,059.8 мянган төгрөг
Эзэмшигчийн өмч: 1,808,258.4 мянган төгрөг

Үйл ажиллагааны чиглэл

- СЭХ-ийн чиглэлийн сургалт зохион байгуулах
- СЭХ-ийн нөөцийн судалгаа, дата төв байгуулах
- СЭХ-ийн төсөл хөтөлбөр
- СЭХ-ийн зураг төсөлд магадлал хийх
- Хүлэмжийн хийн ялгарлын бууралтад магадлагаа нотолгоо хийх
- СЭХ-ийн техник хяналт
- Нарны дэлгэц хэмжих олон улсын итгэмжлэгдсэн лаборатори байгуулах
- Гадаад харилцаа, хамтын ажиллагаа

Сүүлийн 4 жилийн эдийн засгийн үзүүлэлт

Үзүүлэлт	2017	2018	2019	2020
Нийт орлого /сая.төг/	885	1,605.00	852.4	653.1
Нийт зардал /сая.төг/	514	1,086.60	1,005.60	732.5
Цэвэр ашиг /сая.төг/	414	518.4	-153.2	-79.6
Авлага /сая.төг/	98.2	84	268.7	243.7
Өглөг /сая.төг/	127.5	130.1	292.1	350.1
Ажиллагсдын тоо	30	39	39	39
Цалингийн сан /сая.төг/	253.2	364.9	380.1	255.8
Төсвийн төлбөрт /сая.төг/	194.2	183.1	33.4	44.6
Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал	0.6	0.7	1.2	1.1
Хөрөнгө оруулалт /сая.төг/	-	397.6	57.3	-

Хэрэгжиж буй төсөл, хөтөлбөр

- Налайх дүүрэгт 400 кВт-н нар салхи хосолсон станцын техник хяналтын ажил;
- Төв аймгийн Зуунмод суманд баригдах 9МВт нарны цахилгаан станцын ТЭЗҮ боловсруулах ажил;
- “Ю ПИ СИ ЧОЙР” ХХК-ийн 50МВт Салхин станцын ТЭЗҮ боловсруулах ажил;
- Дэлхийн банкны санхүүжилтээр хийгдэж буй Ховд аймгийн Мянгад суманд баригдах 10МВт нарны цахилгаан станцын Зөвлөх үйлчилгээ;
- Сэргээгдэх эрчим хүчийг нэмэгдүүлэх төслийн хүрээнд баруун бүсэд угсралт суурилуулалтын ажил;

Компанийн удирдлага

- Захирал: Баярсайханы Алтанцэцэг /Бизнесийн удирдлагын магистр/, /2021 оны 02 дугаар сараас одоог хүртэл/
- Ерөнхий инженер: Энхтайваны Баяржаргал /Техникийн ухааны магистр, докторант/ 2018 оны 02 дугаар сараас одоог хүртэл/

Тулгамдаж буй асуудал

- Орлогын тогтвортой үүсвэргүй тул төсөл хөтөлбөрүүдийн хэрэгжих хугацаатай өндөр хамааралтай
- Цар тахлын улмаас Олон улсын хамтын ажиллагаа удааширсан
- Байгууллагын эрхүйн орчныг сайжруулах шаардлагатай Жишээ нь: (аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар учир Дэлхийн банк, Азийн хөгжлийн банкны төсөл хөтөлбөрүүдэд техник хяналт хийх боломжгүй)



“ШИНГЭН ТҮЛШ ШИЛЖҮҮЛЭН АЧИХ БАЙГУУЛАМЖ” ТӨҮГ

Түүхэн замнал

Шингэн Түлш Шилжүүлэн Ачих Байгууламжийг газрын тосны бүтээгдэхүүний импортын хоёр дахь эх үүсвэр бий болгох зорилгоор Монгол улсын Засгийн газраас Европын холбоотой хамтран ТАСИС хөтөлбөрийн хүрээнд буцалтгүй тусламжийн хөрөнгөөр барьж 2004 оны 4 дүгээр сард ашиглалтанд оруулсан юм.

Байгууламжийн үндсэн зураг төслийг Европын холбооноос боловсруулсан төслийн дагуу ХБНГУ-ын “Прова Инженеринг” компаниас олон улсын API, NFPA, DIN стандартын дагуу төлөвлөн тоног төхөөрөмжийг нийлүүлж, угсралтын ажлыг чанарын өндөр түвшинд хийж гүйцэтгэсэн юм.

Үйл ажиллагааны чиглэл

- Шингэн түлш шилжүүлэн ачих, хадгалах
- Газрын тосны бүтээгдэхүүний бөөний худалдаа, импорт

Үйлдвэрийн газрын удирдлага

- Захирал: Г.Гансүх
- Ерөнхий нягтлан бодогч: Б.Дэлгэрдалай

Эрхэм зорилго


Манай улс нь ОХУ-аас газрын тосны бүтээгдэхүүний шууд хамааралтай бөгөөд манай газрын эрхэм зорилго нь газрын тосны бүтээгдэхүүний хоёр дахь эх үүсвэрийг бий болгоход оршино.

Товч танилцуулга

Манай байгууламж нь орчин үеийн технологи, тоног төхөөрөмжөөр иж бүрэн хангагдсан, үйл ажиллагааны нэгдсэн систем бүхий Европын болон олон улсын сүүлийн үеийн стандартын шаардлагад нийцсэн Монгол улсын анхны иж бүрэн газрын тосны байгууламж юм. Газрын тосны бүтээгдэхүүнийг хүлээн авах, хадгалах, ачих зориулалттай бөгөөд Байгууламжийн үндсэн үйл ажиллагаа нь БНХАУ-аас нарийн царигийн вагонцистернээр нийлүүлэгдэж байгаа газрын тосны бүтээгдэхүүн (автобензин, дизель түлш, Жет А-1, керосин)-ийг өргөн царигийн вагонцистернд шилжүүлэн ачих юм. 2 цагийн хугацаанд нэгэн зэрэг 8н вагонцистернээс буулгах болон 8 вагонцистернд шилжүүлэн ачих хүчин чадалтай.

Сүүлийн 4 жилийн эдийн засгийн үзүүлэлт

Үзүүлэлт	2017	2018	2019	2020
Нийт орлого /сая.төг/	472.4	2,133.3	3,240.1	4,633.4
Нийт зардал /сая.төг/	774.	1,189.0	1,299.1	1,538.4
Цэвэр ашиг /сая.төг/	-302.8	831.9	1,743.9	2,785.1
Авлага /сая.төг/	2.8	6.5	115.8	159.8
Өглөг /сая.төг/	5.6	0.0	13.7	118.4
Ажиллагсдын тоо	28	28	28	32



Үйлдвэрийн газрын хөрөнгө

Төрийн эзэмшлийн хувь: 100 %
Эзэмшигчийн өмч: 15,362,339.0 мян.төг

Тулгамдаж буй асуудал

1. Тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ
2. Вакум насосны хүчин чадлыг нэмэгдүүлэх, шинэчлэх
3. Онгоцны түлшийг шилжүүлэн ачих, хадгалах үйлчилгээ



“МОНГОЛ УС” ТӨҮГ

Үйл ажиллагааны чиглэл

Монгол Улсын Байгаль орчны тухай багц хууль, “Ус” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд Усны тухай хуулиар байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад олгогдсон зарим чиг үүргийг гэрээний үндсэн дээр “Монгол-Ус” ТӨҮГ-аар гүйцэтгүүлэхээр Засгийн газрын 2013 оны 390 дүгээр тогтоолоор шийдвэрлэсний дагуу 2014 оноос эхлэн Байгаль орчин, аялал жуулчлалын яамтай “Чиг үүргийг гүйцэтгүүлэх гэрээ” байгуулан ажиллаж ирлээ.

Үйлдвэрийн газар нь стратегийн үнэт баялаг бөгөөд хүн ам, хот суурины хөгжил, улс орны нийгэм, эдийн засгийн бүх салбарын үндсэн хэрэглэгдэхүүн болох усны нөөцийг хамгаалах, чанарыг сайжруулах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх үйл ажиллагааг гүйцэтгэж төрийн үйлчилгээг иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад хүргэж байна. Үүнд:

- үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангах,
- үндэсний аюулгүй байдал, улс орны нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангах,
- иргэдийн тав тухтай амьдрах нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэгдсэн усны нэгдсэн менежментийг хэрэгжүүлэх,
- эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх,
- усны нөөцийн менежментийг боловсронгуй болгох,
- усны нөөцийг нарийвчлан судалж зохистой ашиглуулах,
- хяналт мониторингийн иж бүрэн тогтолцоог нэвтрүүлэхэд гол ажлаа чиглүүлэн ажиллаж байна.

Үйлдвэрийн газрын удирдлага

- Захирал Г.Билэгсайхан
- Ерөнхий нягтлан бодогч М.Энхтүвшин

Үйлдвэрийн газрын хөрөнгө

Төрийн эзэмшлийн хувь: 100%
Эзэмшигчийн өмч: мян.төг

Эрхэм зорилго


Стратегийн үнэт баялаг бөгөөд хүн ам, хот суурины хөгжил, улс орны нийгэм эдийн засгийн бүх салбарын үндсэн хэрэглэгдэхүүн болох усны нөөцийг хамгаалах, чанарыг сайжруулах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх ажлыг гүйцэтгэж, үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангах, улмаар үндэсний аюулгүй байдал, улс орны нийгэм эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангах, иргэдийн тав тухтай амьдрах нөхцлийг бүрдүүлэхэд чиглэгдсэн усны нэгдсэн менежментийг хэрэгжүүлэхэд оршино. Усны нөөцийн нэгдсэн менежментийг хэрэгжүүлэх, усны хайгуул судалгаа, нөөцийн хуваарилалт, зохицуулалт хийх, үндэсний болон олон улсын хэмжээнд итгэл хүлээсэн, мэргэшсэн баг хамт олонтой, чадавхтай мэргэжлийн байгууллага болон хөгжихөд оршино.

Товч танилцуулга

“Монгол-Ус” ТӨҮГ нь Монгол улсын Байгаль орчны тухай багц хуулиуд тэдгээрээс голчлон Усны тухай хуульд нийцүүлэн “Ус” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх усны нөөцийн менежмент хийх төрийн эзэмшлийн болон төсвийн хөрөнгөөр баригдсан усны барилга байгууламж түүний дотор толгойн барилга байгууламжийн ашиглалт, засвар үйлчилгээг хариуцан ажиллах чиг үүрэг бүхий Төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар юм.

Сүүлийн 3 жилийн эдийн засгийн үзүүлэлт

Үзүүлэлт	2017	2018	2019	2020
Нийт орлого /сая.төг/	598,6	700,6	1,429,6	1,490.4
Нийт зардал /сая.төг/	572,0	808,1	1,272,6	1,255.5
Цэвэр ашиг /сая.төг/	26,65	-107,4	141,3	211.3
Авллага /сая.төг/	186,1	17,1	23,1	7.4
Өглөг /сая.төг/	10,0	617,9	361,0	0.1
Ажиллагсдын тоо	32	33	33	33



Хэрэгжиж буй төсөл, хөтөлбөр

- ❖ БОАЖЯ-наас хэрэгжүүлсэн МИНИС төслийн хүрээнд Говийн бүсийн аймгуудын усны чанарын 487 дээж, Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль батлагдаж хэрэгжсэнтэй холбогдуулан Нийслэлийн 175 цэцэрлэг, сургуулиас ирүүлсэн 348 бохир усны дээжид усны хими, хүнд металлын шинжилгээг хийж гүйцэтгэсэн байна.
- ❖ - БОАЖЯ-наас өгсөн үүрэг чиглэлийн дагуу хамтын ажиллагааг өргөжүүлэх хүрээнд Унгар улсын “Мечекерц” Төрийн өмчит хувьцаат компанитай хамтран ажиллах санамж бичиг байгуулж, Унгар-Монголын Засгийн газрын хуралдаанд төслийн техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулан танилцуулж, Унгар улсын хөнгөлөлттэй зээлээр санхүүжүүлэх, төслийн эхний шатны ажлыг эхлүүлэх талаар тохиролцоонд хүрээд байна.

Тулгамдаж буй асуудал

1. УИХ-аар “Усны тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль” батлагдаж, Засгийн газрын 2020 оны 121 дүгээр тогтоолоор усны агентлаг байгуулж, Засгийн газрын 2013 оны 390 дүгээр тогтоолыг хүчингүй болгосон.
2. Үйлдвэрийн газрын үйл ажиллагааны гол чиг үүрэг болох дүгнэлт гаргах ажлууд усны агентлагт шилжсэнтэй холбогдуулан үйлдвэрийн газрын орлогын төлөвлөгөө тасалдаж, хэвийн үйл ажиллагаа бүрэн зогсож, ажилтнууд олноор ажлын байраа алдсан. Үйлдвэрийн газрыг одоогийн статусаар ажиллуулж Засгийн газрын 2011 оны 335, 2013 оны 391 дүгээр тогтоолоор өгөгдсөн чиг үүргийг хэрэгжүүлж ажиллахад дэмжлэг үзүүлэх шаардлага үүсээд байна.



“МОНГОЛ КИНО НЭГТГЭЛ” ТӨҮГ

Түүхэн замнал

1935 он 10 сарын 11 өдөр Ардын сайд нарын зөвлөлийн 32 дугаар тогтоолоор улсын кино зургийн хороог байгуулж улмаар уг хорооны харьяа кино үйлдвэрийн газрыг байгуулжээ.

Үйл ажиллагааны чиглэл

- Кино хальс боловсруулах
- Телевизийн болон уран сайхны кино нэвтрүүлэг бэлтгэх
- Студи, тайз заслын үйлчилгээ
- Кино гэрэлтүүлэг, зураг авалт
- Хувцас жижиг хэрэглэлийн түрээсийн үйлчилгээ
- Дуу оруулалт, хөгжим бичлэг, найруулга

Үйлдвэрийн газрын удирдлага

- Захирал: **Ж.Солонго**
- Ерөнхий нягтлан бодогч: **Г.Төрбат**

Үйлдвэрийн газрын хөрөнгө

Төрийн эзэмшлийн хувь: 100 %
Эзэмшигчийн өмч: 4,686,538.2 мян.төг

Эрхэм зорилго


Уран сайхны болон баримтат кино бүтээж түүгээр дамжуулан Монгол орны түүх, өв уламжлал, ёс заншил, үндэсний бахархалыг хойч үедээ амьд дуу, дүрсээр өвлүүлэх.

Товч танилцуулга

Монгол Улсын Засгийн газрын 1997 оны 74 дүгээр тогтоолоор Баримтат кино студи, Хүүхэд залуучуудын театр, Хүүхдийн кино студи, Монголфильм үзвэрийн газрыг нэгтгэн одоогийн “Монгол кино нэгтгэл” Төрийн өмчит үйлдвэрийн газрыг шинэчлэн зохион байгуулсан. Монгол кино нэгтгэл Монгол улсын түүхэнд холбогдох нийгэм, улс төр, эдийн засгийн амьдрал гарч буй чухал үйл явдлуудыг архивлан авч хадгалах зорилгоор “Түүхийн хүрд” баримтат киног жил бүрт бүтээж Үндэсний төв архивт хүлээлгэн өгөх үндсэн чиг үүрэгтэйгээр үйл ажиллагаа явуулж байна.

Сүүлийн 3 жилийн эдийн засгийн үзүүлэлт

Үзүүлэлт	2017	2018	2019	2020
Нийт орлого /сая.төг/	292.4	348.2	713.4	341.6
Нийт зардал /сая.төг/	291.7	347.3	590.1	579.7
Цэвэр ашиг /сая.төг/	0.2	0.6	111.0	238.0
Авлага /сая.төг/	52.8	51.2	32.5	33.0
Өглөг /сая.төг/	5.0	4.0	12.7	12.2
Ажиллагсдын тоо	22	23	22	19



Хэрэгжиж буй төсөл, хөтөлбөр

- ❖ Монголын кино урлагийн ахмад зүтгэлтнүүд, дэлгэцийн ард ажилладаг далд фронтын уран бүтээлчдийн амжилт бүтээлийг харуулсан “Кино миний амьдрал” цуврал нэвтрүүлэг
- ❖ Ардын уран зохиолч, төрийн соёрхолт Б.Догмидын “Морины хүүхэд” зохиолоор уран сайхны кино бүтээхээр дүр шалгаруулалт, бэлтгэл ажил хийгдэж байна.

Тулгамдаж буй асуудал

1. Төрийн өмчийн хөрөнгөөр бүтээгдсэн кино бүтээлийн зохиогчийн эрхийг хэрхэн эзэмших, ашиглах тэдгээрийг эдийн засгийн эргэлтэд оруулах хууль эрх зүйн орчин дутмаг
2. Кино урлагийг төрөөс бодлогоор дэмжих, техник технологийн эрс шинэчлэл хийх хөрөнгө оруулалтын эх үүсвэр дутмаг



“БАРИЛГЫН ХӨГЖЛИЙН ТӨВ” ТӨҮГ

Түүхэн замнал

Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 47 дугаар тогтоолоор Газрын харилцаа, барилга, геодези, зураг зүйн газрыг татан буулгаж, тухайн байгууллагын хэрэгжүүлж байсан барилга, нийтийн аж ахуй, сургалт, судалгаа, хөрөнгө оруулалт, барилга захиалагчийн чиг үүргийг хэрэгжүүлэх үүрэг бүхий “Барилгын хөгжлийн төв” ТӨҮГ-ыг байгуулсан.

Үйл ажиллагааны чиглэл

- Салбарын хууль, тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтийг хангуулах, зохион байгуулах

Үйлдвэрийн газрын удирдлага

- Захирал: Ц.Амарсанаа
- Ерөнхий нягтлан бодогч: Г.Гантуул

Үйлдвэрийн газрын хөрөнгө

Төрийн эзэмшлийн хувь: 100%
Эзэмшигчийн өмч: 8,159.3 мян.төг

Эрхэм зорилго


Барилгын салбарын хөгжлийг түргэтгэгч, дэмжин туслагч, түншлэгч байгууллага байна.

Товч танилцуулга

Монгол улсын Засгийн газар 2012 оны 47 дугаар тогтоолоор Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Газрын харилцаа, барилга, геодези, зураг зүйн газрыг татан буугдсантай холбогдуулан барилгын чиг үүргийг хэрэгжүүлэх үүрэг бүхий “Барилгын хөгжлийн төв” төрийн өмчит үйлдвэрийн газрыг байгуулсан. Барилгын тухай хуулийн 34 дүгээр зүйлд заасан “Барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын чиг үүрэг”-ийг Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 51 дүгээр тогтоолын үндсэн дээр хэрэгжүүлэн ажиллаж байна.

Сүүлийн 3 жилийн эдийн засгийн үзүүлэлт

Үзүүлэлт	2017	2018	2019	2020
Нийт орлого /сая.төг/	4,538.9	6,027.1	8,660.6	7,966.9
Нийт зардал /сая.төг/	4,007.8	5,584.9	6,093.8	6,785.1
Цэвэр ашиг /сая.төг/	478.0	381.4	2,258.1	1,181.8
Авлага /сая.төг/	34.2	32.6	33.2	51.3
Өглөг /сая.төг/	2,288.9	3,594.8	7,451.2	9,193.6
Ажиллагсдын тоо	130	145	155	162



Хэрэгжиж буй төсөл, хөтөлбөр

- ❖ 2020 онд нийт 496 төсөл арга хэмжээнд захиалагчийн техникийн хяналтыг хэрэгжүүлэхээр байна. Үүнд: БХБЯ 132, БСШУСЯ 253, ЭМЯ 88, ХХААХҮЯ 3, ХНХЯ 18, ЗТХЯ 1, Улсын бүртгэлийн ерөнхий газар 1

Тулгамдаж буй асуудал

1. Улсын төсвийн хөрөнгөөр баригдаж буй барилга байгууламжийн зураг төслийг магадлалаас баталгаажсаны дараа улсын төсөвт тусгах ажлын алдаа, дутагдлыг арилгахаар ажиллаж байна.



“АВТОТЭЭВРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ” ТӨҮГ

Түүхэн замнал

1925 он	1929 он	1936 он	1940 он
1925 оны 7 дугаар сарын 15-нд "Монгол Улсын тээх, нэвтрүүлэх газар"-ыг байгуулж байсан нь Монголын анхны механикжсан нийтийн тээврийн эхлэл байлаа	БНМАУ, ЗСБНХУ-ын засгийн газар хоорондын хэлэлцээрийн үндсэн дээр хоёр орны хувь нийлүүлсэн тээврийн байгууллага "Монгол транс"	"Монгол транс"-ын үндсэн хөрөнгийг манай улсад үнэ төлбөргүй эзэр шилжүүлж, үндэсний бие даасан байгууллага "Монгол тээхийн ерөнхий газар"-ыг байгуулсан.	Зам, тээврийн яам байгуулагдаж "Монгол тээхийн ерөнхий хороо"-г "Автотээврийн хэрэг эрхлэх газар", 1942 онд "Ачаа тээврийн шалган бүртгэх товчоо"
1966 он	1975 он	1990 он	1991 он
"Улсын автотээврийн хэргийг бүртгэх газар", "Авто тээврийн төв диспетчерийн удирдах газар"	"Авто тээврийн төв диспетчерийн удирдах газар", "Ачаа тээврийн удирдах газар", "Зорчигч тээврийн үйлчилгээний төв" гэсэн 2 байгууллага	1990 оны 12 дугаар сард "Автотээврийн нэгтгэл", "Хот хоорондын тээвэрчид, зорчигчдод үйлчлэх төв" гэсэн 2 байгууллага	"Тээврийн бирж", "Буудлын үйлчилгээний компани"
1993 он	1996 он	2004 он	2008 он
"Автотээврийн газар"	Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг "Автотээврийн газар"	"Тээврийн үйлчилгээний төв"	Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг "Автотээврийн газар"
2009 он	2013 он	2015 он	
"Тээврийн хэрэгслийн оношлогоо, хяналт зохицуулалтын алба" УТУГ	"Авто тээврийн үндэсний төв" ТӨААТҮГ	"Авто тээврийн үндэсний төв" ТӨҮГ	

Үйл ажиллагааны чиглэл

- Монгол Улсын нутаг дэвсгэрт ашиглагдаж байгаа автотээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх
- Автотээврийн хэрэгсэлд техникийн хяналтын үзлэг хийх
- Автотээврийн хэрэгслийн болон тээвэрлэлтийн талаарх мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, мэдээллээр хангах
- Улс, хот хооронд, орон нутгийн зорчигч болон ачаа тээвэр, шуудан, нийтийн тээвэр, жуулчин тээвэрлэлтийн үйлчилгээ болон дамжин өнгөрөх тээвэрлэлтийн үйлчилгээг улсын хэмжээнд зохицуулах, зохион байгуулах, аж ахуй нэгж байгууллагуудтай гэрээ байгуулж, үйлчилгээг гүйцэтгүүлэх
- Улс, хот хооронд, орон нутгийн нийтийн зорчигч, ачаа болон дамжин өнгөрөх тээвэрлэлт гүйцэтгэж байгаа тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хянах, мэдээллээр хангах
- Автотээврийн хэрэгслийн мэргэшсэн жолоочийн шалгалт авах, үнэмлэх олгох
- Улс, олон улс хоорондын зорчигч тээвэрлэлтийн үйлчилгээ эрхлэх
- Авто үйлчилгээний байгууллагад ангилал тогтоох үйл ажиллагааг зохион байгуулах
- Төрийн захиалгат ажил үйлчилгээг гэрээний үндсэн дээр гүйцэтгэх
- Чанарын удирдлагын тогтолцоог нэвтрүүлж, техникийн хяналт, засвар үйлчилгээний хэмжлийн тоног төхөөрөмжүүдийн шалгалт, тохируулга, баталгаажуулалт хийх

Эрхэм зорилго

Автотээврийн хэрэгслээр ачаа, зорчигч тээвэрлэх үйл ажиллагааг боловсронгуй болгох, тээвэрлэлтийг мэргэшсэн жолоочоор гүйцэтгүүлэх Авто үйлчилгээний байгууллагуудад ангилал тогтоох, Автотээврийн хэрэгсэлд тавигдах техникийн хяналт, Тээврийн хэрэгслийн бүртгэлийг хэрэгжүүлэх, хөгжүүлэх, нийгмийн хэрэгцээг хангасан аюулгүй, ая тухтай үйлчилгээний нөхцөлийг бий болгох явдал мөн.

Товч танилцуулга

"Автотээврийн үндэсний төв" ТӨҮГ нь автотээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын гаргасан бодлого, шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах, төрийн зарим чиг үүргийг хэрэгжүүлэх болон нийгмийн хэрэгцээг хангах үндсэн чиг үүрэгтэй автотээврийн салбарын мэргэжлийн байгууллага юм. Автотээврийн тухай хууль, Засгийн газрын тогтоол болон дүрэм журамд заасны дагуу тус үйлдвэрийн газар нь дараах чиглэлээр улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байна.

Сүүлийн 4 жилийн эдийн засгийн үзүүлэлт

Үзүүлэлт	2017	2018	2019	2020
Нийт орлого /сая.төг/	22,759,0	25,592,1	27,647,3	23,460.6
Нийт зардал /сая.төг/	16,259,2	18,009,1	20,360,5	20,889.7
Цэвэр ашиг /сая.төг/	5,235,4	7,470,7	5,745,2	2,196.8
Авлага /сая.төг/	99,9	112,2	109,8	162.7
Өглөг /сая.төг/	6,854,9	7,085,9	7,389,3	6,779.1
Ажиллагсдын тоо	799	799	819	819

Үйлдвэрийн газрын хөрөнгө

Төрийн эзэмшлийн хувь: 100%
Эзэмшигчийн өмч: 35,485,912,364.24 төг

Үйлдвэрийн газрын удирдлага

- Захирал: Б. Гүрсоронзон
- Тэргүүн дэд захирал: Б.Мөнхгарьд
- Дэд захирал: Х.Баярхүү
- Дэд захирал: Ц.Эрдэнэчулуун
- Ерөнхий нягтлан бодогч: Я.Оюунсүрэн

Хэрэгжиж буй төсөл, хөтөлбөр

- ❖ Аймаг бүрт автобуудал, техникийн хяналтын үзлэгийн төвийн барилга, бүтээн байгуулалт
- ❖ Тээврийн ухаалаг системийг хөгжүүлэх
- ❖ Ажилчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөр

Тулгамдаж буй асуудал

1. Дэлхий даяар короновирусын өвчин тархаж, Улсын онцгой комиссын шийдвэрээр тус үйлдвэрийн газрын зарим ажил, үйлчилгээг түр зогсоосонтой холбоотойгоор тээврийн хэрэгсэл шинээр бүртгэх, улс, хот хоорондын зорчигч тээвэрлэлт, улс хоорондын ачаа тээвэрлэлт гол үзүүлэлтүүд өмнөх онтой харьцуулахад буурсан үзүүлэлттэй байна.
2. Ажилчдын ажиллах орчин нөхцлийг сайжруулах, ажлын байрны нөхцлийг сайжруулах, оффисын байр, талбайн асуудлыг шийдвэрлүүлэх



“ЭРЧИМ ХҮЧНИЙ ЭДИЙН ЗАСГИЙН ХҮРЭЭЛЭН” ТӨҮГ

Түүхэн замнал

Улс орныг үйлдвэржүүлэх, уул уурхайн олборлох үйлдвэрүүдийг шинээр барьж ашиглалтад оруулах зорилгоор Аж үйлдвэрийн яамны сайдын **1959 оны** 532 тоот тушаалаар уг яамны хөрөнгө оруулалт их барилгын хэлтсийн дэргэд “Их хайрханы уурхайг» цахилгаанаар хангах зураг төсөл, төсөв зохиох 7 хүний бүрэлдэхүүнтэй групп байгуулагдсан ба энэ нь тус байгууллагын үүсэл хөгжлийн үндэс суурь болон тавигдсан. Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 157 дугаар тогтоолоор Эрчим хүчний яамны харьяанд, 2017 онд Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын харьяанд шилжин ажиллаж байна.

Үйл ажиллагааны чиглэл

- Шинжлэх ухаан технологийн сангийн захиалгат төслүүдийг хийж гүйцэтгэх, Техник эдийн засгийн тооцоо боловсруулах /ТЭЗҮ/
- Эрчим хүчний хэмнэлтийн АУДИТ хийх, Эрчим хүчний баланс, төлөвлөлтийн судалгаа хийх
- Эрчим хүчний Стандарт, Норм, нормативын бичиг баримт боловсруулах
- Эрчим хүчний тусгай зөвшөөрлийн гэрээ байгуулж, гэрчилгээ олгох
- Эрчим хүчний ЦДАШ болон Өндөр хүчдэлийн дэд станцын зураг төсөл боловсруулах, барилга угсралтын ажилд зохиогчийн хяналт тавих

Үйлдвэрийн газрын удирдлага

- Захирал: М.Түмэнжаргал
- Ахлах нягтлан бодогч: Л.Балган

Үйлдвэрийн газрын хөрөнгө

Төрийн эзэмшлийн хувь: 100%
Эзэмшигчийн өмч: 913,718.77 мян.төг

Эрхэм зорилго

Хүрээлэнгийн үйл ажиллагааны үндсэн зорилго нь эрчим хүчний салбарын ойрын болон дунд хугацааны, хэтийн хөгжлийн бодлого, стратеги боловсруулахад шаардагдах Хүрээлэнгийн үйл ажиллагааны үндсэн зорилго нь эрчим хүчний салбарын ойрын болон дунд хугацааны, хэтийн хөгжлийн бодлого, стратеги боловсруулахад шаардагдах өгөгдлийг судлан шинжлэх, эрчим хүчний хэрэглээний таац, эдийн засгийн тооцоо, судалгаа, шинжилгээг шинжлэх ухааны үндэслэлтэй боловсруулах, захиалгат эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийх, зураг төсөл, төсөв боловсруулах, шинэ техник, технологи, инновацийг судлан нэвтрүүлэх, норм норматив, стандартын бичиг баримтыг боловсронгуй болгох, эрчим хүчний чиглэлийн гадаад, дотоод хамтын ажиллагааг өргөжүүлэх замаар Эрчим хүчний асуудал эрхэлсэн Төрийн захиргааны төв байгууллагын захиалга, үүрэг даалгаврыг мэргэжлийн түвшинд гүйцэтгэн судалгаа, мэдээллээр ханган эрчим хүчний салбарын хөгжлийг төгөлдөржүүлэхэд оршино.

Товч танилцуулга

Тус хүрээлэн нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 240 дугаар тогтоолоор

- Захиргаа, удирдлагын хэлтэс
- Эрдэм шинжилгээ бодлого судалгааны хэлтэс
- Зураг төслийн хэлтэс
- Стандарт, норм нормативын хэлтэс гэсэн 4 хэлтэс 41 хүний бүрэлдэхүүнтэй үйл ажиллагаагаа явуулж байна.

Сүүлийн 4 жилийн эдийн засгийн үзүүлэлт

Үзүүлэлт	2017	2018	2019	2020
Нийт орлого /сая.төг/	1,586.71	1,831.27	1,824.74	1,793.55
Нийт зардал /сая.төг/	1,175.73	1,527.75	1,728.05	1,597.45
Цэвэр ашиг /сая.төг/	369.87	268.36	83.35	168.68
Авлага /сая.төг/	1,348.32	1,281.51	677.85	670.34
Өглөг /сая.төг/	1,204.13	976.53	292.30	245.95
Ажиллагсдын тоо	37	37	41	41
Цалингийн сан /сая.төг/	506.10	666.63	809.89	824.89
Төсвийн төлбөрт /сая.төг/	215.30	295.08	359.96	373.22
Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал	0.74	0.83	0.95	0.89
Хөрөнгө оруулалт /сая.төг/	217.03	213.56	33.96	84.83

Хэрэгжиж буй төсөл, хөтөлбөр

- ❖ “Дулааны шугам сүлжээний алдагдлыг тодорхойлох арга зүйг боловсруулах, алдагдлыг бууруулах техникийн шийдэл, хэрэгжилт”
- ❖ Монгол улсын эрчим хүчний хэмнэлтийн үр ашгийн үзүүлэлтүүдийг тодорхойлох
- ❖ Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын цахилгаан хангамжийн ажлын зураг төслийг боловсруулж дуусган барилга угсралтын ажлыг эхлүүлсэн.
- ❖ “Тавантолгой Түлш” ХХК-ийн Төв аймгийн Сэргэлэн сумын нутаг дахь сайжруулсан шахмал түлшний үйлдвэрийн хангамжийн 110 кВ-ын ЦДАШ, 110/10 кВ-ын дэд станцын 110 кВ талын ажлын зураг төслийг боловсруулж дуусган барилга угсралтын ажлыг эхлүүлсэн.
- ❖ Эрчим хүчний салбарын 51 стандарт, шинээр цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц, дулааны шугам сүлжээний засвар, угсралтын ажлын 18 технологийн карт, хөдөлмөр зарцуулалтын норм, төсвийн суурь нормыг боловсруулан батлуулж мөрдөгдөж байна.

Тулгамдаж буй асуудал

1. Эрдэм шинжилгээ, судалгааны төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхэд төрөөс дэмжлэг, туслалцаа байхгүй.
2. Боловсон хүчний чадавхыг дээшлүүлэх, материаллаг баазыг сайжруулах
3. Эрдэм шинжилгээ, судалгааны төсөл, хөтөлбөрийн санхүү, хөрөнгө оруулалтын төсвийг нэмэгдүүлэх.
4. Эрчим хүчний салбарын хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрт төрийн өмчит байгууллагын хувьд давуу эрхтэй оролцох боломжгүйгээс хувийн хэвшлийн байгууллага хэт бага үнээр шалгарч, төсөл, хөтөлбөрүүдийн хэрэгжилт дутуу дулимаг, чанарын шаардлага хангахгүй байна.



Түүхэн замнал



Үйл ажиллагааны чиглэл

- Захиалагчийн хяналтыг тавих;
- Үйлдвэр, компаниудын техник ашиглалтын үйл ажиллагаанд хяналт тавих;
- Эрчим хүчний барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийх, дүгнэлт гаргах;
- Эрчим хүчний салбарын ИТА нарыг сургах, бэлтгэх;
- Эрчим хүчний салбарт нэгдсэн лабораториор хими, метал гагнуурын болон цахилгаан техникийн чиглэлээр туршилт, шинжилгээг гүйцэтгэж, баталгаажуулах.

Үйлдвэрийн газрын удирдлага

Захирал: Я.Нямжаргал
 Ерөнхий инженер: Л.Батхүү
 Ерөнхий менежер: Б.Энхбат

ЭХХТ ТӨҮГ-ын хөрөнгө

Төрийн эзэмшлийн хувь: 100%

Нийт хөрөнгийн дүн 23,890,633.8 мян.төг
Эргэлтийн хөрөнгө 1,755,344.9 мян.төг
Үндсэн хөрөнгө 10,468,306.8 мян.төг
Эзэмшигчийн өмч: 18,482,325.3 мян.төг


/2019.12.31-ны байдлаар/

Товч танилцуулга

Эрчим хүчний салбарт улсын төсвийн болон гадаад, дотоодын хөрөнгө оруулалт, зээл тусламжаар хэрэгжих төсөл хөтөлбөр, арга хэмжээнд гэрээгээр ажил үйлчилгээ гүйцэтгэх, захиалагчийн хяналтыг тавих, үйлдвэр, компаниудын техник ашиглалтын үйл ажиллагаанд хяналт тавих, эрчим хүчний барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийх, дүгнэлт гаргах, салбарын ажилтнуудыг давтан сургах, хими, метал гагнуурын болон цахилгаан техникийн чиглэлээр туршилт, шинжилгээг гүйцэтгэж, баталгаажуулах, хүрээлэн буй орчинд үзүүлэх хортой нөлөөллүүдийг бууруулах, эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх, салбарын хэмжээнд мөрдөгдөж буй хууль, дүрэм, журам, стандартын хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Сүүлийн 4 жилийн эдийн засгийн үзүүлэлт

Үзүүлэлт	2017	2018	2019	2020
Нийт орлого /сая.төг/	7,272.4	7,313.4	6,288.4	4,283.3
Нийт зардал /сая.төг/	6,892.1	7,302.3	6,283.8	4,775.6
Цэвэр ашиг /сая.төг/	342.3	9.9	4.1	-492.2
Авлага /сая.төг/	917.4	993.6	813.4	906.3
Өглөг /сая.төг/	6,886.2	5,951.8	5,179.6	4,950.5
Ажиллагсдын тоо	115	123	123	119



Хэрэгжиж буй төсөл, хөтөлбөр

1. 2020 оны Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 11 төсөл арга хэмжээний 14 багц ажил хэрэгжиж байна.
2. Эрчим хүчний салбар хэрэгжиж буй томоохон төсөл хөтөлбөрүүдийг дурьдвал:
 - ❖ Бүгд Найрамдах Хятад Ард Улсын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжих Улаанбаатар-Мандалговь чиглэлийн цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц барих төсөл
 - ❖ “Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын суурь бүтцийн трассын дагуух 35кВ-ын хүчдэлтэй 2 хэлхээ бүхий нийт 414.6 км урттай ЦДАШ, дэд станц барих ажил
 - ❖ Төв аймгийн Сэргэлэн сумын нутаг 1 дүгээр баг, Баян-уулын баруун талд шинээр баригдах сайжруулсан шахмал түлшний үйлдвэрийн цахилгаан хангамжийн ажил
 - ❖ Эрдэнэтийн дулааны цахилгаан станц” ТӨХК-ийн суурилагдсан хүчин чадлыг өргөтгөх, шинэчлэх
 - ❖ Чойбалсан дулааны цахилгаан станцын 50МВт-аар өргөтгөх

Тулгамдаж буй асуудал

1. Эрчим хүчний салбарт хэрэгжиж буй болон хэрэгжихээр төлөвлөсөн төсөл хөтөлбөрүүд удааширсантай холбогдуулан байгууллагын санхүүгийн байдалд хүндрэл үүсээд байна.

“СПОРТЫН БЭЛТГЭЛИЙН ТӨВ” ТӨҮГ

Түүхэн замнал

- ✓ Тус ТӨҮГ нь 1978 онд ашиглалтанд орж, 1983 онд “Строй инвест” компанийн мэдэлд, 2004 онд Орхон аймгийн орон нутгийн өмчид шилжүүлэн Орхон аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2004 оны 20 дугаар тогтоолоор анх “Эрдэнэт Олимп” ОНӨҮГ болгон өөрчилсөн ба мөн 2010 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн 58 дугаар тогтоолоор Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Биеийн тамир спортын газарт, Монгол улсын Засгийн газрын 2011 оны 10 дугаар сарын 19-ны өдрийн 298 дугаар тогтоолоор Улсын төсөвт үйлдвэрийн газар, ЗГ-н 2015 оны 2 дугаар сарын 09-ны 55 дугаар тогтоолоор “Спортын бэлтгэлийн төв” ТӨААТҮГ болгон өөрчилсөн.

Үйл ажиллагааны чиглэл

- Үндэсний шигшээ баг болон спортын өндөр зэрэглэлтэй тамирчдын бэлтгэл сургуулилтыг ханган үйл ажиллагаа явуулахад оршино.

Үйлдвэрийн газрын удирдлага

- Захирал: О. Баярбат
- Ерөнхий нягтлан бодогч: О.Батдэлгэр

Эрхэм зорилго

Монгол улсын биеийн тамир спортыг хөгжүүлэх талаар төрөөс баримтлах бодлогод тусгасан зорилт, хөтөлбөрийг хэрэгжүүлэх, тамирчдын бэлтгэл сургуулилтыг хийхэд ая тухтай нөхцөл бололцоогоор хангах, хөнгөн шуурхай үйлчилгээ үзүүлэхэд оршино.

Товч танилцуулга

“Спортын бэлтгэлийн төв” ТӨҮГ нь Булган аймгийн Хангал сумын нутаг “Цагаан хөтөлийн дэнж” гэдэг газар Улаанбаатар хотоос 460 км, Эрдэнэт хотоос 60 км зайд байрладаг. Тус ТӨҮГ-н барилга, байгууламжийг анх Эрдэнэт үйлвэрийн 1, 2-р ус өргөх станцуудын ажилчдын амьдрах сууцны зориулалтаар 1978 онд барьж ашиглалтанд оруулсан.

Сүүлийн 4 жилийн эдийн засгийн үзүүлэлт

Үзүүлэлт	2017	2018	2019	2020
Нийт орлого /сая.төг/	121.1	88,1	128,3	156.3
Нийт зардал /сая.төг/	178,8	188,8	183,6	207.5
Цэвэр ашиг /сая.төг/	-57.7	-100,6	-55,0	-51,1
Авлага /сая.төг/	0,2	15,0	3,5	1,337.4
Өглөг /сая.төг/	119,2	174,7	176,7	147,704.6
Ажиллагсдын тоо	14	14	14	14

Үйлдвэрийн газрын хөрөнгө

Төрийн эзэмшлийн хувь: 100%
Эзэмшигчийн өмч: 1,237,758.9 мян.төг

Тулгамдаж буй асуудал

1. Барилга байгууламжуудын чанар муудсан.
2. Халаалтын системийг цогцоор нь шийдвэрлэх.
3. Аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар болсноор өөрийн орлогоор өөрийн зардлаа нөхөж чадахгүйд хүрч улмаар цахилгаан эрчим хүч, татвар, нийгмийн даатгал болон бусад өр төлбөр жилээс жилд нэмэгдсээр байна.



“ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ТӨВ” ТӨҮГ

Түүхэн замнал

Монгол Улсын Засгийн газрын 2004 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн 202 дугаар тогтоолоор Зам, тээвэр аялал жуулчлалын сайдын эрхлэх асуудлын хүрээнд “Авто замын хяналт, судалгааны төв”, Монгол улсын Засгийн газрын 2015 оны 2 дугаар сарын 09-ний өдрийн 55 дугаар тогтоолоор “Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ нэртэйгээр тус тус шинэчлэн зохион байгуулагдсан

Үйл ажиллагааны чиглэл

- Авто замын сүлжээний ашиглалтын бэлэн байдал, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах бодлогыг хэрэгжүүлэх,
- Авто замын салбарын эрдэм шинжилгээ, судалгаа шинжлэх ухаан технологийн бодлогыг хэрэгжүүлэх
- Авто замын салбарын хүний нөөцийн бодлогыг хэрэгжүүлэх, ур чадвар, ажлын бүтээмжийг сайжруулах
- Авто зам барилгын үйлдвэрлэлийн технологийн хяналтыг хэрэгжүүлэх
- Norm, нормативын санг бүрдүүлэх, норматив техникийн баримт бичгийг боловсронгуй болгох, зураг төслийн магадлалын үйл ажиллагааг зохион байгуулах
- Авто замын материалын сорилт туршилт судалгааны чиглэлийг хэрэгжүүлэх, дүгнэлт гаргах
- Олон улс, улсын чанартай авто зам ашигласны төлбөр үйл ажиллагааг зохион байгуулах, орчин үеийн шаардлагад нийцүүлэн боловсронгуй болгох

Үйлдвэрийн газрын удирдлага

- Захирал: Монгол улсын гавьяат барилгачин Р.Буд.
- Ерөнхий нягтлан бодогч: Б.Дуламханд

Үйлдвэрийн газрын хөрөнгө

Төрийн эзэмшлийн хувь: 100%
Эзэмшигчийн өмч: 6'215'341,20 мян.төг

Эрхэм зорилго

Зам, тээврийн талаар төрөөс гаргасан бодлого шийдвэр, Авто замын тухай хууль /Шинэчлсэн найруулга/-ийн 11 дүгээр зүйлд заасан чиг үүргийн хүрээнд Монгол улсын авто замын сүлжээний ашиглалтын бэлэн байдалд хяналт тавих, арчлалт, засварын ажлыг удирдан зохион байгуулах, стандарт, норм нормативын баримт бичиг боловсруулах, авто зам, замын байгууламжийн зураг төслийн магадлалын үйл ажиллагааг зохион байгуулах, авто замын салбарын мэргэжилтэй ажилтныг давтан сургах, мэргэжил дээшлүүлэх, мэргэжлийн зэрэг олгох ажлыг зохион байгуулах, авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажлын техник технологийн хяналтыг хэрэгжүүлэхэд оршино


Товч танилцуулга

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2020 оны 129 дүгээр тогтоолоор шинэчлэн батлагдсан дүрэм, бүтэц орон тооны хүрээнд 7 хэлтэс, 3 алба, 122 үндсэн, 260 гэрээт ажилтантайгаар Авто замын тухай хуулийн 11 дүгээр зүйлд заасан чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 90 дүгээр тушаалаар Авто замын салбарын норм нормативын сангийн үйл ажиллагааг зохион байгуулах, мөн авто зам, барилгын ажилд тавих технологийн хяналтын ажлын цар хүрээ нэмэгдсэн, авто замын ашиглалтын бэлэн байдлыг ханган ажиллах менежментийн шинэчлэлтийн үр дүнд үйл ажиллагааны чиглэл 2016 оны мөн үеэс 50%-аар, ажиллах хүчний тоо 2 дахин нэмэгдэж, эдийн засгийн үзүүлэлт 2,5 дахин өссөн байна. 2019 онд хэрэгжүүлсэн онцлог ажлаас дурдвал:

- Авто замын норм нормативын сангийн хөрөнгөөр 7 стандарт, норм норматив, техникийн баримт бичиг шинэчлэн боловсруулж, 2 судалгааны ажлыг амжилттай хэрэгжүүлэн үйлдвэрлэлд нэвтрүүлээд байна.
- Улсын төсвийн хөрөнгөөр баригдсан нийт 300 км авто зам, 940 урт/м гүүрийн барилгын ажилд технологийн хяналт гүйцэтгэн, 11 объект түүний дотор Дорноговь аймгийн Алтанширээ суманд баригдах “Газрын тоос боловсруулах үйлдвэрийг Сайншанд хоттой холбох хүнд даацын автомашины 17,7 км авто замын технологийн хяналтыг амжилттай хэрэгжүүлэн байнгын ашиглалтад орууллаа.
- Олон улс, улсын чанартай авто замаар зорчиж буй тээврийн хэрэгслээс авто зам ашигласны хураамж авах үйл ажиллагааг иргэдэд чирэгдэлгүй түргэн шуурхай зохион байгуулах зорилгоор төлбөрийн цахим систем CANDY PAY, тээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн дугаар ашиглан төлбөр /RFID/ төлөх зэрэг туршилтын төслүүдийг амжилттай хэрэгжүүлж байна.
- Олон улс, улсын чанартай авто замын сүлжээний ашиглалтын бэлэн байдал, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах зорилгоор Авто замын тухай хуулийн 11.1.13-т заасан “Хөдөлгөөнт эргүүл-ийг шинээр зохион байгуулан 6 чиглэлийн 5387 км авто замд хөдөлгөөний аюулгүй байдлыг хангуулахад жолооч нарт санамж, мэдээлэл өгөх, тээврийн хэрэгслийн даацад хяналт тавин 630 гаруй тээврийн хэрэгслийн зөрчлийг арилгуулан ажиллалаа.
- Салбарын ахмадууд болон ажилтнуудын нийгмийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор Ажилтнуудын цалинг нэмэгдүүлэх, дэмжлэг тусламж үзүүлэх, ажлын байрны нөхцөлийг сайжруулах зэрэг томоохон ажлуудыг хэрэгжүүлэн ажиллалаа.

Сүүлийн 4 жилийн эдийн засгийн үзүүлэлт

үзүүлэлт	2017	2018	2019	2020
Нийт орлого /сая.төг/	1,760,4	2,728,0	5,264,1	5,852.7
Нийт зардал /сая.төг/	1,668,0	2,106,6	4,342,5	4,886.5
Цэвэр ашиг /сая.төг/	81,6	557,4	803,2	966.2
Авлага /сая.төг/	54,0	414,6	399,1	599.5
Өглөг /сая.төг/	10,7	254,1	1,291,8	1,093.7
Үндсэн ажилтаны тоо	55	75	116	148



Хэрэгжиж буй төсөл, хөтөлбөр

- ❖ Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага JICA-ийн шугамаар хэрэгжиж буй “Монгол орны зам, цаг уурын нөхцөлд тохирсон авто замын хучилтын технологийн чадавхыг сайжруулах төсөл” Төслийн хүрээнд Монгол орны цаг уурын нөхцөлд тохирсон хучилтын хийцийн стандарт боловсруулах, үйлдвэрлэлд нэвтрүүлэх, шаардлагатай лабораторийн тоног төхөөрөмж нийлүүлэх ажлууд хийгдэнэ. Төсөл хэрэгжих хугацаа-2019-2021 он
- ❖ “Олон улс, улсын чанартай авто замаар зорчиж байгаа тээврийн хэрэгслээс авто зам ашигласны төлбөр хураамжийг автоматжуулах төсөл” Төслийн хүрээнд нийт 3 ТАЦ-ын үйл ажиллагааг цахимжуулан, RFID төхөөрөмж, LPR камер суурилуулан төлбөр хураамжийг төвлөрүүлнэ. Төсөл хэрэгжих хугацаа 2020 он
- ❖ Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Беларусь Улсын Засгийн газар хооронд байгуулсан Экспортын зээлийн ерөнхий хэлэлцээрийн хүрээнд “Авто замын засвар, арчлалтын байгууллагуудын чадавхийг сайжруулах төсөл” Уг төслийн хүрээнд “МАЗ” Хамтарсан хувьцаат компанийн үйлдвэрлэн гаргаж байгаа авто замын засвар арчлалтын нүхэн засварын 42 машин, тоног төхөөрөмжийг Зам, засвар арчлалтын байгууллагуудад нийлүүлэх юм. Төсөл хэрэгжих хугацаа-2019-2020 он

Тулгамдаж буй асуудал

1. ШИНЭЧЛЭЛТ-Тус төв нь хөдөө орон нутагт авто зам, замын байгууламжийн ашиглалтын бэлэн байдал, зам барилгын ажлын техник технологийн хяналт хийх чиг үүргийг хэрэгжүүлэхэд өнөөдрийн байдлаар 6 автомашин ашиглаж байгаа боловч эдгээр нь 2005-2012 онуудад ашиглалтад орсон, 150000-250000 км зам туулж, өртгийн болон гүйлтийн норм дууссан хөдөлгөөний аюулгүй байдлыг ханган үйлчилгээ үзүүлэхэд хүндрэлтэй болсон. Жилд эдгээр тээврийн хэрэгсэлд 30 гаруй сая.төгрөгийн засвар үйлчилгээг тогтмол хийж байна.
2. АЖЛЫН БАЙРНЫ НӨХЦӨЛ-Засгийн газрын 2018 оны 112 дугаар тогтоолоор татан буугдсан “Тоног төхөөрөмжийн түрээс” ТӨХК-ийн компанийн эзэмшилд байсан 512 мкв тоосгон 2 давхар оффисын барилгыг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын шийдвэрээр тус төв шилжүүлэн авч ашиглаж байгаа боловч, үйл ажиллагааны чиглэл өргөжин тэлж, ажиллах хүч нэмэгдсэний хэрээр ажлын байрны хүрэлцээ хангалтгүй байна. Иймд өөрийн эзэмшлийн газарт ажлын байрыг шинээр барьж, өргөтгөх шаардлага үүсээд байна.



“БУЯНТ УХАА СПОРТЫН ОРДОН” ТӨҮГ

Түүхэн замнал

“Буянт-Ухаа спортын ордон” 2010 онд 66 ажилчинтайгаар байгуулагдан өнөөг хүртэл үйл ажиллагаагаа явуулж байна. 2018 оны 10-р сарын 30-ний өдрийн №477 Төрийн Өмчийн Бодлого, Зохицуулалтын газрын №114 тоот тогтоолоор бүтэц орон шинэчлэн баталсан бөгөөд Захирал-1, Дэд захирал-1, Захиргаа, санхүүгийн алба-6, Техникийн алба-13, Нийтлэг үйлчилгээний алба-12 нийт 33 хүний орон тоотойгоор шинэчлэн зохион байгуулагдан үйл ажиллагаагаа явуулж байна.

Үйл ажиллагааны чиглэл

Нийтийг хамарсан бие тамир, спорт, тив дэлхий, олон улсын тэмцээн уралдаан баяр ёслол, соёл урлагийн арга хэмжээ, хурал зөвлөгөөн, үзэсгэлэн зохион байгуулах, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх.

Үйлдвэрийн газрын удирдлага

- Захирал: Л.Энхбаяр
- Дэд захирал: Ч.Содном
- Ерөнхий нягтлан бодогч: Н.Баатаргэрэл

Үйлдвэрийн газрын хөрөнгө

Төрийн эзэмшлийн хувь: 100%
Эзэмшигчийн смч: 55,805,680.817.31 төг

Эрхэм зорилго


2020 онд олон улс тив дэлхийн тэмцээн уралдааныг эх орондоо өндөр түвшинд зохион байгуулах, спортын ордныг үр ашигтай ажиллуулж, зөв удирдлага менежментээр удирдан дэлхийн жишигт хүргэж хөгжүүлэх.

Товч танилцуулга

Монгол улс БНХАУ-ын хамтын ажиллагааны гэрээний хүрээнд 134 сая юаны хөрөнгө оруулалтаар баригдан 2010 оны 12 сарын 02-нд ашиглалтад орсон. Үндсэн заал 3000 мкв, 2 давхар 1400 мкв, гадна талбай 3500 мкв, суудлын тоо 5045, нэмэлт 2000 суудал засах боломжтой бөгөөд нийт 7045 хүнд үйлчлэх боломжтой.

Сүүлийн 4 жилийн эдийн засгийн үзүүлэлт

Үзүүлэлт	2017	2018	2019	2020
Нийт орлого сая.төг	832.4	1,483.0	2,212.2	251.5
Нийт зардал сая.төг	1,247.7	1,881.9	2,591.3	1,946.8
Цэвэр ашиг сая.төг	-409.3	-398.8	-379.0	-1,695.3
Авлага сая.төг	65.5	143.9	210.2	119.1
Өглөг сая.төг	111.8	234.9	519.4	539.9
Ажилчдын тоо	28	28	33	33



Хэрэгжиж буй төсөл, хөтөлбөр

- ❖ Ордонд БНХАУ-ын Засгийн газрын буцалтгүй тусламжийн хөрөнгөөр 2020-2021 онуудад их засвар, хөрөнгө оруулалт хийхээр болж 2019-08-29-нд “Буянт-Ухаа спортын ордон”-ны засвар, үйлчилгээний төслийн хэрэгжүүлэлтийн хамтын ажиллагааны гэрээ байгуулсан. Төсөл хэрэгжих хугацааг 2020-06-30-ны өдөр гэж заасан боловч шинэ төрлийн “Корона вирус” дэлхийн олон улсад дэгдэж цар тахлын хэмжээнд хүрсэнтэй холбогдуулан тус төсөл тодорхойгүй хугацаагаар хойшлоод байна.

Тулгамдаж буй асуудал

1. Ашиглалтад орсноос хойш өдөр алгасалгүй тогтмол үйл ажиллагаа явагдсаар өдий хүрсэн бөгөөд ордонд суурилагдсан тоног төхөөрөмжүүд хуучирсан тул өнөөгийн шаардлагыг хангахгүй, зарим нь ажиллагаагүй болох зэрэг асуудлууд өдөр бүр тулгарч байна.
2. Дэлхий болон олон улсын чанартай соёл спортын арга хэмжээ, хурал зөвлөгөөний стандартууд өндөр болохын хэрээр ордны материаллаг бааз болон заал танхимуудад тавигдах шаардлага нэмэгдэж, байшин барилгын хувьд зарим зориулалтын барилгаар өргөтгөх асуудал тулгарч байна.
3. Ордон нь 2016 онд аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар болсноор татварын ачаалал нэмэгдэж цаашид хэвийн үйл ажиллагаа явуулахад нэн хүндрэлтэй болж байна.



“ДИПЛОМАТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛЧИЛГЭЭГ ЭРХЛЭХ ГАЗАР” ТӨҮГ

Эрхэм зорилго

Дипломат байгууллагуудад үзүүлдэг цогц үйлчилгээг олон улсын жишигт хүргэж, өрсөлдөх чадвар бүхий мэргэшсэн баг хамт олны хүчээр, Монгол улсын гадаад харилцааны салбарт оруулах хувь нэмрээ дээшлүүлнэ.

Түүхэн замнал

1951-1953 Гадаад явдлын яамны протоколын хэлтсийн харъяанд /орон тоо 1/
1953-1956 Элчингүүдэд үйлчлэх тасаг /орон тоо 3/
1956-1958 Гадаад явдлын яамны аж ахуйн хэлтэст нэгтгэсэн /орон тоо 6/
1958-1970 Дипломат корпуст үйлчлэх товчоо
1970-1977 Гадаад явдлын яамны хэрэг эрхлэх хэлтэстэй нэгтгэсэн
1977-2000 Дипломат байгууллагын үйлчилгээ, аж ахуйн газар/
2000-2012 “Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар” Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг
2012-2015 “Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар” УТҮГ
2015 -2020 “Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар” ТӨҮГ

Үйлдвэрийн газрын удирдлага

- Захирал: Б.Ичинхорлоо
- Үйл ажиллагаа хариуцсан дэд захирал: Д.Хулганажав
- Үйлчилгээ чанар хариуцсан дэд захирал Д.Чулуунбаатар
- Ерөнхий нягтлан бодогч: Б.Болдбаатар

Үйлдвэрийн газрын хөрөнгө


Төрийн эзэмшлийн хувь: 100%
Эзэмшигчийн өмч: 29,017,597.3 мян.төг

Товч танилцуулга

Гадаад хэргийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, гадаад улсаас Монгол улсад суугаа дипломат болон консулын төлөөлөгчийн газар, олон улсын байгууллагын төлөөлөгчийн газруудын үйл ажиллагааг тасралтгүй хэвийн явуулахад шаардлагатай нийтлэг үйлчилгээг үзүүлэх, гадаад улсад суугаа Монгол улсын дипломат төлөөлөгчийн газрын барилга байгууламжийн ашиглалт, хамгаалалтыг хариуцах үндсэн чиг үүргийн дагуу өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар үйл ажиллагаа явуулж байна.

Сүүлийн 4 жилийн эдийн засгийн үзүүлэлт

Үзүүлэлт	2017	2018	2019	2020
Нийт орлого /сая.төг/	5,389.0	5,429.6	5,472.4	5,866.6
Нийт зардал /сая.төг/	5,349.5	5,298.1	5,387.9	5,655.9
Цэвэр ашиг /сая.төг/	35.5	118.3	91.8	170.4
Авлага /сая.төг/	937.6	797.4	731.5	566.3
Өглөг /сая.төг/	23.8	57.3	788.9	861.2
Ажиллагсдын тоо	141	143	157	167



Үйл ажиллагааны чиглэл

- Монгол Улсын Гадаад харилцааны яам, Монгол Улсад суугаа гадаад улсын Дипломат төлөөлөгчийн газар, олон улсын байгууллагын төлөөлөгчийн газрын барилга байгууламж болон цахилгаан, ус, дулаан хангамжийн асуудлыг бүрэн хариуцах, мөн тэдгээрийн засвар үйлчилгээ, тохижилтын ажлыг хариуцан үйлчилгээ үзүүлэх.
- Гадаад улсад суугаа ЭСЯ, дипломат төлөөлөгчийн газрын барилга байгууламжийн ашиглалт, хамгаалалтыг хариуцах тэдгээрт үзлэг хийх шаардлагатай засвар үйлчилгээний талаар санал боловсруулж дээд шатны байгууллагад хүргүүлэх.
- Монгол Улсад зохион байгуулагдаж буй Төрийн бүх түвшний айлчлал, хүндэт зочид төлөөлөгчид, Гадаад харилцааны яам, Монгол улсад суугаа Элчин сайдын яамд, Консулын газрууд, Олон Улсын байгууллагын төлөөлөгчийн газрын захиалгын дагуу автомашины үйлчилгээ үзүүлэх.
- Төрийн хэмжээний айлчлал болон Гадаад харилцааны яам, Дипломат төлөөлөгчийн газруудын хүсэлтээр ёслол хүндэтгэлийн хүлээн авалт, арга хэмжээг зохион байгуулж, чанар, стандартын өндөр түвшинд хүрсэн зоогийн үйлчилгээгээр үйлчлэх.
- Төрийн бусад байгууллага, аж ахуйн нэгж байгууллагуудад зоогийн үйлчилгээгээр үзүүлэх.
- Байр автомашин түрээсийн үйлчилгээ.
- Гадаад дотоодын зочдод зочид буудлын үйлчилгээ үзүүлэх.



“МЭДЭЭЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ҮНДЭСНИЙ ПАРК” ТӨҮГ

Түүхэн замнал

1972 онд Шинжлэх ухаан техникийн мэдээлэл нэртэйгээр анх үүсгэн байгуулагдаж 1997 онд Шинжлэх ухаан технологийн төв корпораци нэртэйгээр үйл ажиллагаа явуулж байгаад 2002 оноос хойш Мэдээлэл технологийн үндэсний парк болон өргөжин ажиллаж байна.

Үйл ажиллагааны чиглэл

- Мэдээллийн технологийн гарааны компанийг бизнес инкуборт бойжуулах, Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн мэдээллийн технологийн шалгалт, сургалт зохион байгуулж холбогдох төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх

Үйлдвэрийн газрын удирдлага

- Гүйцэтгэх захирал: Э.Цогтгэрэл
- Ерөнхий нягтлан бодогч: Д.Цэрэндолгор

Үйлдвэрийн газрын хөрөнгө

Төрийн эзэмшлийн хувь: 100 %
Эзэмшигчийн өмч: 3,674,205.6 мян.төг

Эрхэм зорилго


Гарааны бизнес болон өндөр технологийг нутагшуулах, дамжуулах, чадварлаг хүний нөөцийг мэргэшүүлэх, салбарын эко системийг төгөлдөржүүлж олон улсад тэргүүлэгч цөм байгууллага болох.

Товч танилцуулга

Монгол улсад мэдээллийн технологийн хөгжлийн түүхээ болж, инновацийг бүтээх гарааны компаниудыг хурдасгах хөтөлбөр хэрэгжүүлэх, мэдээллийн технологийн инкубаторыг ажиллуулах, бүх нийтийн мэдээллийн технологийн боловсролыг сайжруулах зорилгоор стандартад нийцсэн сургалт, олон улсын шалгалтын системийг нэвтрүүлэн, дэлхийн хэмжээний мэдлэг, ур чадвартай хүний нөөцийг бэлтгэх ажлыг зохион байгуулдаг Төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар юм.

Сүүлийн 4 жилийн эдийн засгийн үзүүлэлт

Үзүүлэлт	2017	2018	2019	2020
Нийт орлого /сая.төг/	1,469.40	819.00	1,102.70	910.00
Нийт зардал /сая.төг/	1,546.70	829.80	1,117.90	1,028.09
Цэвэр ашиг /сая.төг/	-77.3	-10.8	-15.2	-118.09
Авлага /сая.төг/	110.10	80.40	189.90	228.88
Өглөг /сая.төг/	359.20	298.60	304.80	285.18
Ажиллагсдын тоо	56	39	37	38



Хэрэгжиж буй төсөл, хөтөлбөр

- ❖ 2020 оны байдлаар нийт 8 төсөл хэрэгжүүлж байгаа бөгөөд 100 хувийн гүйцэтгэлтэй 3 төсөл, 50 хувийн гүйцэтгэлтэй 2 төсөл, 40 хувийн гүйцэтгэлтэй 1, 30 хувийн гүйцэтгэлтэй 1 төсөл хөтөлбөрийг бие даан болон бусад аж ахуйн нэгжүүдтэй хамтран хэрэгжүүлж байна.

Тулгамдаж буй асуудал

1. Шилдэг энтрепренёруудыг бэлтгэх, гарааны компаниудад таатай эко системийг бүрдүүлэх зорилготой төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд санхүүгийн эх үүсвэр болсон түрээсийн төлбөр бага, томоохон түрээслэгч нар нь их хэмжээний талбай ашигладаг хэдий ч зөвхөн өөрт ашигтай талбайн түрээсийн төлбөрийн гэрээтэй.
2. Гарааны компаниудыг бойжуулах, шилдэг энтрепренёрийг бэлтгэхэд дэд бүтцийн хувьд хүртээмжтэй хэдий ч салбарын бус төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудад түрээсээр ашиглуулдаг.

“ТЕХНИК СПОРТЫН ТӨВ” ТӨҮГ

Түүхэн замнал

- ✓ “Техник спортын төв” нь анх 1980 онд буудлага спортын төв клуб нэртэйгээр байгуулагдаж улмаар Монгол улсад буудлагын спортыг хөгжүүлэх, олимп, тив дэлхийд өрсөлдөх мэргэжлийн багш дасгалжуулагч, тамирчдыг тэрүүлэх, олон нийтэд буудлагын спортыг сурталчлах, хүүхэд залуучуудын техникийн мэдлэгийг нэмэгдүүлэх зорилготой улсын төсвийн хөрөнгө оруулалтаар байгуулагдсан байдаг.
- ✓ 1997 оноос хойш “Батлан Хамгаалахад Туслах Нийгэмлэг” ТББ-ын “Техник спортын төв” нэртэйгээр үйл ажиллагаа явуулж байгаад МУ-ын Засгийн газрын 2015 оны 55-р тогтоолоор “Техник спортын төв” Төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар болгон өөрчлөн зохион байгуулагдсан боловч шүүхийн маргааны улмаас үйл ажиллагаа явуулж чадалгүй байсаар 2017 оны 10-р сарын 13 ны өдөр МУ-ын Дээд шүүхийн тогтоолоор төрийн өмч болохыг тогтоосон шийдвэр гарч 2018 оны 02 дугаар сарын 18-ны өдрөөс эхлэн үйл ажиллагаа явуулж байна.

Үйл ажиллагааны чиглэл

- Биеийн тамир, спортын салбарын талаар төрөөс баримтлах бодлого чиглэлийн хэрэгжилтийг хангах

Үйлдвэрийн газрын удирдлага

- Захирал: Б.Наран-Идэр
- Орлогч захирал бөгөөд Ерөнхий менежер: Ч.Энхтөр
- Нягтлан бодогч: Д.Алтанчимэг

Эрхэм зорилго

Монгол улсад буудлага, биатлон зэрэг техникийн спортыг хөгжүүлэх, олимп, тив дэлхийд өрсөлдөх мэргэжлийн багш дасгалжуулагч, тамирчдыг тэрүүлэх, олон нийтэд буудлагын спортыг сурталчлах, хүүхэд залуучуудын техникийн мэдлэгийг нэмэгдүүлэх зорилготой.

Товч танилцуулга

“Техник спортын төв” ТӨҮГ нь биеийн тамир, спортын талаар төрөөс явуулж буй бодлогын хэрэгжилтийг хангах, төрөөс баримтлах бодлогод тусгасан зорилтыг хэрэгжүүлэх, иргэдийн дунд нийтийг хамарсан биеийн тамир, спорт, чийрэгжилтийн арга хэмжээ зохион байгуулах, техникийн спорт /буудлага, биатлон/-ын төрлүүдийн сургалтын үйл ажиллагаа явуулах, Үндэсний шигшээ баг, тамирчид, дасгалжуулагчдын бэлтгэл сургуулилт хийх орчин нөхцөлөөр хангах, олон нийтэд техникийн спортыг сурталчлан таниулах, улс, тив дэлхийн тэмцээнийг зохион байгуулахад үйлчилгээ үзүүлэх зорилго бүхий өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр өөрөө өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар ажиллаж, бие даан иргэний гүйлгээнд ордог Төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар юм.

Сүүлийн 3 жилийн эдийн засгийн үзүүлэлт



Үзүүлэлт	2018	2019	2020
Нийт орлого /сая.төг/	479,5	200,7	313,7
Нийт зардал /сая.төг/	708,1	353,8	468,9
Цэвэр ашиг /сая.төг/	-228,5	-153,1	-155,3
Авлага /сая.төг/	31,7	25,4	25,4
Өглөг /сая.төг/	35,4	109,8	348,3
Ажиллагсдын тоо	24	25	19

Үйлдвэрийн газрын хөрөнгө

Төрийн эзэмшлийн хувь: 100 %
Эзэмшигчийн өмч: 537,713,49 /мян.төг/

Тулгамдаж буй асуудал

1. А, Б хоёр заалтай спорт цогцолбор шинээр барих хөрөнгө оруулалт гадна их засварын ажил



Түүхэн замнал

1970 онд СНЗ-ийн 120-р тогтоол, ЮНИДО-ийн МОН-ДП 70/506 төслөөр Арьс ширний эрдэм, шинжилгээ, туршилтын төв нэртэйгээр ХХҮЯ-ны харьяанд байгуулагдсан. 1997 онд ЗГ-ын 31-р тогтоолоор Арьс ширний эрдэм, шинжилгээ туршилтын төв, Ой модны эрдэм судлалын төв, Ноос, ноолуур судлалын төв, хөнгөн үйлдвэрийн зураг төслийн институт зэрэг байгууллагуудыг нэгтгэн АРМОНО корпораци"-ийг байгуулсан. 1999-2006 онуудад Арьс ширний эрдэм шинжилгээний төвөөс бусад төвүүд ШУТИС-д нэгтгэгдсэн. 2015 онд ЗГ-ын 78 дугаар тогтоолоор БСШУСЯ-ны харьяанд, 2019 оны 10.02 2өдрийн ЗГ-ын 370 дугаар тогтоолоор ХХААХҮЯ-ны харьяанд “Хөнгөн үйлдвэрийн судалгаа, туршилт үйлдвэрлэл бизнесийн корпораци ТӨҮГ” нэртэйгээр өөрчлөн зохион байгуулагдсан.

Үйл ажиллагааны чиглэл

- Арьс ширний салбарт шинжлэх ухаан, технологи, судалгаа, инновацийн үйл ажиллагаа
- Мэргэжлийн үйлчилгээ: итгэмжлэгдсэн лабораотри, мэргэшүүлэх сургалт, зөвлөх үйлчилгээ, стандартчилал, мэдээлэл,
- Инкубаци, бизнес үйл ажиллагаа: технологи дамжуулах, нэвтрүүлэх, гарааны компанудыг бойжуулах, ЖДҮ-ийн инкубацийг дэмжин хөгжүүлэх, сураглт явуулах, технологийг үйлчилгээний төв ажиллуулах, захиалгат ажил үйлчилгээ эрхлэх

Үйлдвэрийн газрын удирдлага

- Захирал: П.Насанжаргал Ph.D
- Ерөнхий нягтлан бодогч: Ц.Ичинхорлоо

Эрхэм зорилго

Арьс ширний салбарыг хөнгөн үйлвэрийн тэргүүлэх салбар болгоход чиглэгдсэн шинжлэх ухаанд суурилсан технологийн хөгжлийг хангах зорилготой.

Товч танилцуулга

АРМОНО корпораци ТӨҮГ нь малын гаралтай түүхий эдийг дэвшилтэт технологийн аргаар боловсруулах үндэсний технологийг бий болгох, шинжлэх ухаан, технологи, судалгаа, инноваци, туршилт, сургалт, аутсорцинг, зөвлөх үйлчилгээ, технологи нэвтрүүлэлт, эко-үйлдвэрлэл, итгэмжлэгдсэн лабораторийн үйлчилгээ, салбарын мэргэжилтэн бэлтгэх, дадлагжуулах, оюуны чадавхийг хөгжүүлэх, жижиг дунд үйлдвэрлэлийн инкубаци, үндэсний үйлдвэрлэл, экспортыг дэмжих чиг үүрэг бүхий мэргэжлийн байгууллага юм.

Үзүүлэлт	2017	2018	2019
Нийт орлого /сая.төг/	271,7	280,7	609,5
Нийт зардал /сая.төг/	382,1	349,7	593,5
Цэвэр ашиг /сая.төг/	-110,4	-71,0	15,9
Авлага /сая.төг/	12,8	50,7	131,4
Өглөг /сая.төг/	93,3	81,5	92,5
Ажиллагсдын тоо	20	20	21

Компанийн хөрөнгө

Төрийн эзэмшлийн хувь: 100 %
Эзэмшигчийн өмч: 7,137,697 мян.төг

Хэрэгжиж буй төсөл, хөтөлбөр

- ❖ Арьс ширний үйлдвэрлэлд цэвэр ус хэмнэх технологийн оновчтой шийдэл, ШУТ-ийн төсөл-2019
- ❖ Дэлхий банкны “Экспортыг дэмжих төсөл” Японы ЖАЙКА ОУ-ын байгууллага, Солонгос улсын КОЙКА байгууллагын төсөл хөтөлбөрт санад оруулж, НҮБ-ийн ЮНИДО байгууллагатай хамтран ажиллаж байна.

Тулгамдаж буй асуудал

- 1.Техник, тоног төхөөрөмжийн шинэчлэл хийх.
2. Их засвар, урсгал засвар хийх.
3. Санхүүгийн чадвараа нэмэгдүүлэх.

A decorative graphic on the left side of the slide. It features a pencil with a grey eraser and a yellow body, pointing downwards. The pencil is surrounded by several colorful loops in red, green, blue, and orange, which appear to be part of a stylized design or logo. The background is a light grey gradient.

VI. Сангийн яамны төлөөлөл хэрэгжүүлдэг хуулийн этгээд

Түүхэн замнал

1991.01.18-Монголын хөрөнгийн бирж байгуулагдав.
1992.02.07-ҮЦ-ны анхдагч зах зээлийн арилжаа явагдсан.
1994.09.26-ҮЦ-ны зах зээлийн тухай хууль батлагдав.
1995.08.28-ҮЦ-ны хоёрдогч зах зээлийн арилжаа эхлэв.
1996.10.25-ЗГ-ын бондын анхны арилжаа явагдлаа.
2001.06.08-Компанийн бондын арилжаа явагдсан.
2005.05.25-Анхны IPO гарав.
2011.04.27-МУ-ын ЗГ Лондонгийн хөрөнгийн бирж групптэй “Ажлын мастер гэрээ” байгуулав.
2012.07.02-“Миллениум ай ти” Арилжаа, Төлбөр, Тооцоо, Хяналт, Хадгаламжийн цогц системийг зах зээлд нэвтрүүлээ.
2015.12.02-МХБ өөрийгөө зохицуулах байгууллага боллоо.
2016.01.05-Төрийн өмчийн хувьчлалыг хөрөнгийн биржээр нээлттэй явуулж эхлэв.
2017.12.31-Түүхэн дээд арилжаа хийгдэв.
2018.01.02-MSE А болон MSE В индексүүдийг тооцож эхлэв.
2018.02.12-Монголын хөрөнгийн зах зээлд анхны давхар бүртгэл хийгдэв.
2018.5-Монголын даатгалын салбарын анхны компани үнэт цаасаа бүртгүүлэв.
2019.06.28 "Хамтын хаалттай хөрөнгө оруулалттай сангийн нэгж эрхийн бүртгэлийн журам"-ыг батлав.
2020.03.31 Төлбөр тооцооны Т+2 горимд шилжив.
2020.08.24 Анхны хаалттай хамтын хөрөнгө оруулалтын санг бүртгэв.
2020.12.28 Анхны хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас бүртгэв.

Үйл ажиллагааны чиглэл

Хөрөнгийн биржийн үйл ажиллагаа

Компанийн хөрөнгө

Төрийн эзэмшлийн хувь: 100 %
Дүрмийн сан: 23,130,593,600 төгрөг
Нийт хувьцаа: 231,305,936 ширхэг
Хувьцааны нэрлэсэн үнэ: 100 төгрөг

Эрхэм зорилго


Үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллага Санхүүгийн зах зээл дэх хөрөнгийн хуримтлалыг хямд өртөгтэйгөөр урт хугацаанд зуучлан хүргэх үүрэг бүхий үнэт цаасны сонгодог зах зээлийг бий болгон төлөвшүүлэх замаар улс орны эдийн засгийн хөгжилд бодит хувь нэмэр оруулахад оршино.

Товч танилцуулга

“Монголын хөрөнгийн бирж” ТӨХК нь үнэт цаасны арилжаа эрхлэх үндсэн үйл ажиллагаа бүхий байгууллага юм. Монгол улсад хөрөнгийн зах зээл үүсч, Монголын хөрөнгийн бирж байгуулагдсанаас хойш эдүгээ хөгжлийнхөө 30 жилийг туулан өнгөрүүлжээ. Өнгөрсөн хугацаанд Монголын хөрөнгийн зах зээл олон улсын жишигт хүрсэн дэд бүтэцтэй болж, хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгосноор хөрөнгө оруулалтын таатай орчин бүрдэж, Үнэт цаас гаргагчид нэмэгдэж, Монголын хөрөнгийн зах зээлийн үнэлгээ нийт 3.02 их наяд төгрөгт хүрээд байна.

Сүүлийн 4 жилийн эдийн засгийн үзүүлэлт

Үзүүлэлт	2017	2018	2019	2020
Нийт орлого /сая.төг/	1,902,5	1,793.3	1,550.3	1,124.7
Нийт зардал /сая.төг/	2,562,9	2,626.0	2,665.3	2,101.2
Цэвэр ашиг /сая.төг/	(660,3)	(832.7)	(1,155.1)	(1,037.8)
Авлага /сая.төг/	82,8	70.5	49.6	84.1
Өглөг /сая.төг/	373,5	1,214.6	1,595.2	2,193.4
Улсын төсөвт төлсөн татвар хураамж /сая.төг/	418,6	362.4	446.8	344.0
Ажиллагсдын тоо	52	51	52	53



Компанийн удирдлага

Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга:

М.Батхуяг (СЯ-ны Төрийн сангийн газрын дарга)

ТУЗ-ийн гишүүд:

М.Санжаадорж (Сангийн Яам) Р.Гандиймаа (Хараат бус)

Л.Сонор (Сангийн Яам) А.Анар (Хараат бус)

Д.Баянзул (Монгол Банк) А.Батпүрэв (Хараат бус)

Б.Сүх-Очир (Сангийн Яам)

Б.Ганбат (Засгийн газрын хэрэг эрхлэх газар)

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга: О. Мөнх-Эрдэнэ

Гүйцэтгэх захирал: Х.Алтай

Тулгамдаж буй асуудал

- Зах зээлийн нэгдмэл, үр ашигтай бүтэц, зохион байгуулалтыг бүрдүүлэх, уялдаа холбоог сайжруулах
- Төрийн өмчит, төрийн өмчийн оролцоотой компаниуд болон стратегийн ач холбогдол бүхий орд газруудын тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниудын хувьцааг МХБ-ээр дамжуулан нээлттэй арилжих
- Засгийн газрын үнэт цаасны арилжааг биржээр явуулж эхлэх
- Хүний нөөцийн хөгжлийн хангаж, чадавхийг бэхжүүлэх



Ag Re

“ҮНДЭСНИЙ ДАВХАР ДААТГАЛ” ТӨХК

Компанийн удирдлага

Төлөөлөн удирдах зөвлөл

Дарга:

С.Наранцогт - Сангийн яамны төрийн нарийн бичгийн дарга

Гишүүд:

1. П.Дорждагва – Сангийн яамны Төрийн захиргаа удирдлагын газрын дарга
2. Ц.Болорчулуун – Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга
3. А.Дэмбэрэл – Үндэсний статистикийн хорооны Статистикийн эрдэм шинжилгээ, арга зүйн газрын дарга
4. П.Эрдэнэбаатар – Монголын даатгалын холбооны удирдах зөвлөлийн дарга
5. Д.Насанжаргал – Монголын хөдөө аж ахуйн хоршоологчдын үндэсний холбооны удирдах зөвлөлийн гишүүн
6. Б.Шаравсамбуу – Хараат бус гишүүн
7. Ц.Түмэнхишиг – Хараат бус гишүүн
8. Я.Бадамханд-Хараат бус гишүүн

Гүйцэтгэх захирал: Г.Энхтайван

Дэд захирал: О.Наранхүү

Гүүрэн замнал

- ✓ Үндэсний давхар даатгал ХК нь Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн дагуу Засгийн газрын 2014 оны 8 дугаар сарын 28-ны өдрийн 280 дугаар тогтоолоор Хөдөө аж ахуйн давхар даатгал ХК нэртэйгээр байгуулагдсан ба байгалийн болзошгүй болон гэнэтийн эрсдэлээс малчид, тариаланчдыг хамгаалан олон улсын жишигт нийцсэн давхар даатгалын үйлчилгээ үзүүлж, дотоодын даатгалын компаниудыг давхар даатган ажиллаж байна.
- ✓ Гадаад валютын гадагшлах урсгалыг бууруулах, давхар даатгалын зардлыг багасгах зорилгоор Засгийн газрын 2018 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 303 дугаар тогтоолоор Хөдөө аж ахуйн давхар даатгал ХК-ийн нэрийг Үндэсний давхар даатгал ХК болгон үйл ажиллагааг нь өргөтгөсөн.

Үйл ажиллагааны чиглэл

Давхар даатгал


Компанийн хөрөнгө

Төрийн эзэмшлийн хувь:100%
Хувьцаа эзэмшигч: Сангийн яам

Хэрэгжүүлж буй үйл ажиллагаа, төсөл

- Малын индексжүүлсэн даатгал
- Нэрлэсэн эрсдэлт улаан буудайн даатгал
- Тариалангийн индексжүүлсэн даатгал
- Газар тариалангийн тоног төхөөрөмжийн даатгал
- Эрчимжүүлсэн мал аж ахуйн даатгал
- Экспортыг дэмжих төсөл - Экспортын зээлийн даатгал
- Хөрөнгийн даатгал

Бүтэц



Товч танилцуулга

Алсын хараа

✓Бид Монгол Улсын даатгалын зах зээлийг олон улсын жишигт нийцсэн давхар даатгалын үйлчилгээгээр хангаж, даатгалын салбарын эдийн засгийн хөгжилд үзүүлэх үр нөлөөг дэмжинэ.

✓Эрхэм зорилго

✓Бид үйлчлүүлэгчдийнхээ хөрөнгө, санхүүгийн эрсдэлгүй найдвартай байдлыг ханган давхар даатгалын үйлчилгээ үзүүлж, даатгалын салбарын өсөлт хөгжлийг дэмжинэ.

Үнэт зүйлс

- ✓ **Мэргэшсэн өндөр чадавх** – Даатгалын мэргэжлийн өндөр ур чадвартай боловсон хүчин.
- ✓ **Манлайлал** – Цаашдын зорилго зорилтыг тодорхойлон бусдад үлгэрлэх, чиглүүлэх нэгтгэх, хамтдаа бодит үйл хэрэг болгоно.
- ✓ **Хамтын зүтгэл** – Бусадтай хүндэтгэлтэй хандаж, итгэлцэл бий болгон хамт олонтойгоо үр дүнтэй хамтран ажиллаж бүтээмжийг нэмэгдүүлнэ.
- ✓ **Үнэнч шударга зарчим** – Монгол Улсын хууль журмыг чандлан мөрдөж, компанийн ёс зүйн дүрмийг өдөр тутамд мөрдлөг болгон ажиллана.
- ✓ **Ил тод харилцаа холбоо** – Мэдээллийн ил тод байдлыг хангах үүргээ биелүүлж, шударга, нээлттэй харилцаа холбоо тогтооно.



“Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК

Түүхэн замнал

1991 онд Монголын хөрөнгийн бирж үүсгэн байгуулагдахад “Төлбөр тооцоо хадгаламжийн алба” нэртэйгээр үйл ажиллагаагаа эхлүүлсэн бөгөөд Монгол улсын засгийн газрын 2003 оны 72 тоот тогтоолоор “Үнэт цаасны төлбөр тооцоо төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК бие даасан байгууллага болон өргөжиж, үнэт цаасны бүртгэл, хадгаламж болон төлбөр тооцооны үйлчилгээг эрхлэн гүйцэтгэж байв. 2016 оны 4 дүгээр сарын 15-нд Засгийн газрын 147 тоот тогтоолын дагуу “Үнэт цаасны төлбөр тооцоо төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-ийг “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК болон “Арилжааны төлбөр тооцоо ҮЦК” ХХК болгон хуваасан.

Үйл ажиллагааны чиглэл

- Үнэт цаасны хадгаламж, өмчлөх эрхийн бүртгэлийн үйл ажиллагаа
- Үнэт цаасны арилжааны төлбөрийн үйл ажиллагаа

Компанийн удирдлага

“Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ТӨХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд нь компанийн хувьцаа эзэмшигчийн эрх үүргийг хэрэгжүүлэгч Сангийн яам буюу Сангийн сайдын тушаалаар томилогддог бөгөөд 6 хараат болон 3 хараат бус гишүүнтэй. 2020 онд “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ТӨХХК-ийн бүтэц, зохион байгуулалтаар 4 алба, дотоод хяналтын нэгж, ТУЗ-өөс томилогдсон Дотоод аудитортойгоор ажилласан.

Эрхэм зорилго

“Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-ийн эрхэм зорилго нь үнэт цаасны хадгаламж, өмчлөх эрхийн бүртгэлийн үйл аюулгүй байдлыг ханган, үйл ажиллагаагаа шударга, шуурхай, ил тод явуулан үнэт цаасны зах зээлийг төлөвшүүлэн хөгжүүлэхэд оршино.

Товч танилцуулга

Монголын “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК нь Монгол улсад үнэт цаасны хадгаламжийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий 100% төрийн өмчит хуулийн этгээд юм. “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК нь “Үнэт цаасны тухай хууль”-д зааснаар Үнэт цаас гаргагч болон бусад оролцогчтой байгуулсан гэрээний үндсэн дээр үнэт цаасыг хадгалах, түүнтэй холбоотой бүртгэл хөтлөх үйл ажиллагааг эрхлэх, биржийн болон биржийн бус арилжааны өмчлөх эрхийг баталгаажуулан бүртгэх, кастодианы үйлчилгээг хавсран эрхлэх эрх бүхий өөрийгөө зохицуулагч хуулийн этгээд юм.

Сүүлийн 4 жилийн эдийн засгийн үзүүлэлт

Үзүүлэлт	2017	2018	2019	2020
Нийт орлого /сая.төг/	1,939.7	3,718.3	3,375,2	3,123,0
Нийт зардал /сая.төг/	1,028.1	1,286.2	1,539,2	1,517,4
Цэвэр ашиг /сая.төг/	897.4	2,244.9	1,666,5	1,448,3
Авлага /сая.төг/	173.7	85.1	194,3	189,2
Өглөг /сая.төг/	10.1	11.2	39,5	13,1
Ажиллагсдын тоо	37	37	39	40
Цалингийн сан /сая.төг/	570.2	626.0	760,4	822,6
Төсвийн төлбөрт /сая.төг/				
Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал	0.52	0.35	0.46	0.49
Хөрөнгө оруулалт /сая.төг/	165.4	66.3	99,2	72,1

Компанийн хөрөнгө

Төрийн эзэмшлийн хувь: **100%**
 Эзэмшигчийн өмч: **5,000,000 мян.төг**
 Нийт хувьцаа: **50 сая ширхэг**
 Хувьцааны нэрлэсэн үнэ: **100 төгрөг**

Хэрэгжиж буй төсөл, хөтөлбөр

Үйл ажиллагаагаа цахимжуулах ажлын хүрээнд Үнэт Цаасны компаниудтай дансны мэдээллийг цахимаар солилцох API хөгжүүлэлтийг хийн, үнэт цаасны данс нээлтийг “MIT” системд өөрчлөлт оруулан хялбаршуулсан. Түүнчлэн үнэт цаасны дансны хуулга харах үйлчилгээг ТҮЦ машинаар авах боломжийг бүрдүүлэн үйл ажиллагаанд нэвтрүүлээд байгаа билээ. Үүний үр дүнд Монгол Улсын хэмжээнд буй нийт 111 ТҮЦ машинаас иргэд үнэт цаас эзэмшлийн талаарх болон ногдол ашиг, ногдол хувь олголтын талаарх мэдээллээ бүрэн авах боломжтой болсон.

Тулгамдаж буй асуудал

Цаашид бид үнэт цаасны хадгаламж, өмчлөх эрх бүртгэлийн үйлчилгээг харилцагчдад түргэн шуурхай үзүүлэх, хөрөнгийн зах зээлд оролцогчдын идэвхийг нэмэгдүүлэхийн тулд үнэт цаасны барьцааны үйлчилгээ, үнэт цаас зээлдэх зээлдүүлэх үйлчилгээ болон Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн цахим бүртгэл хөтлөх зэрэг зах зээлийн эрэлтэд нийцсэн шинэ үйлчилгээнүүдийг нэвтрүүлэхээр зорин ажиллаж байна.



Монголын үнэт цаасны клирингийн төв ХХК

Түүхэн замнал

2016 онд Арилжааны Төлбөр Тооцоо ХХК нэртэй байгуулагдаад 2020 оны 03-р сард Монголын Үнэт Цаасны Клирингийн Төв ХХК гэж өөрчилсөн.

Үйл ажиллагааны чиглэл

Үнэт Цаасны арилжааны клирингийн үйл ажиллагаа

Компанийн удирдлага

➤ Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга:
Б.Сүхочир

- Гишүүд: .Б.Лхагваочир
Д.Балжинням
Э. Дуламсүрэн
Б.Энхтуяа
Ж.Цогтсанаа
Ч.Чимидсүрэн
- В.Рэгцэнханд
- Ц.Батсугар

• Хоролсүрэн. /ТУЗ-ийн нарийн бичиг/

- Гүйцэтгэх захирал: О.Эрдэнэгэрэл
- Дэд захирал: . Байхгүй
- Нягтлан бодогч: Л.Цогтуяа

Эрхэм зорилго

Үнэт цаасны арилжааны тооцоо, төлбөрийн үйл ажиллагааг олон улсын стандартын дагуу зохистой гүйцэтгэж, хөрөнгийн захын хөгжлийн тогтвортой өсөлтийг дэмжинэ

Товч танилцуулга

"Монголыг Үнэт Цаасны Клирингийн Төв ХХК " ХХК нь 100% төрийн өмчтэй, төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэгч нь Сангийн яам бөгөөд Сангийн сайдын тушаалаар томилогдсон Төлөөлөн удирдах зөвлөлтэй. Нийт 3 албатай 16 ажилтантай.

Компанийн хөрөнгө

Төрийн эзэмшлийн хувь: Төрийн 100 хувь
Эзэмшигчийн өмч: 2 тэр бум
Нийт хувьцаа: 20000,0 ширхэг
Хувьцааны үнэ: 100 төгрөг

Хэрэгжиж буй төсөл, хөтөлбөр


- ❖ Хэрэгжиж буй одоогоор төсөл байхгүй

Тулгамдаж буй асуудал

Нөөц бааз төв байгуулах түүний тоног төхөөрөмж, сүлжээний цогц шийдэлийг шийдэх

Сүүлийн 4 жилийн эдийн засгийн үзүүлэлт

Эдийн засгийн Үзүүлэлтүүд	2017	2018	2019	2020
Нийт орлого /сая.төг/	491.40	1337.69	991.66	406.43
Нийт зардал /сая.төг/	361.64	439.03	536.83	477.91
Цэвэр ашиг /сая.төг/	129.76	898.60	454.83	-71.48
Авлага /сая.төг/	8.05	5.64	93.73	27.86
Өглөг /сая.төг/	2182.37	1013.65	467.05	933.87
Ажиллагсдын тоо	15	16	16	16
Цалингийн сан	203.43	213.93	236.52	268.6
Төсвийн төлбөрт		0	0	0
Борлуулалтын нэг төгрөгт ногдох зардал	1.86	0.33	0.54	1.18
Хөрөнгө оруулалт	34.94	33.52	1156.37	2.3



Түүхэн замнал

Төрийн Банк нь Монгол улсын Банкны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, Монголбанкны Ерөнхийлөгчийн 2000 оны 375 тоот тушаалаар батлагдсан “Банк, түүний нэгж байгуулах зөвшөөрлийн журам”-ыг үндэслэн Монголбанкнаас 2009.11.23-ны өдөр олгогдсон “26” дугаар бүхий БАНКНЫ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭТЭЙ болно.

Үйл ажиллагааны чиглэл

Төрийн Банк нь олон улсын стандартад нийцсэн орчин үеийн банк, санхүүгийн цогц үйлчилгээг орон даяар саадгүй хүргэх, бүх талын хамтын ажиллагааг дээдлэх, харилцагчдынхаа бизнесийн үйл ажиллагааг тогтвортой явуулах нөхцөлийг бүрдүүлэх, санхүүгийн олон талт хэрэгцээг хангахад чиглэн, Монгол орон даяар 500 гаруй салбар нэгж, 347 АТМ, 3855 гаруй картаар үйлчлэгч байгууллагаар дамжуулан үндэсний хэмжээнд үйл ажиллагаагаа явуулж байна.

Компанийн удирдлага

Төрийн банк нь Сангийн яам болон Хадгаламжийн даатгалын корпорацийн хөрөнгө оруулалттай төрийн эзэмшлийн компани.

Бүтэц, зохион байгуулалт: Эрх барих дээд байгууллага нь Хувьцаа эзэмшигчдийн хурал болон Төлөөлөн удирдах зөвлөл.

Гүйцэтгэх захирал, үйл ажиллагааны чиглэл хариуцсан 5 дэд захиралтай ба нийт 12 газар, 20 хэлтэс, 7 албатайгаар үйл ажиллагаагаа явуулж байна

Эрхэм зорилго

БИД санхүүгийн цогц, хүртээмжтэй үйлчилгээгээр ард иргэдийн сайн сайхан амьдрал, улс орны тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулж, байгаль экологийг хамгаалах, хариуцлагатай хэрэглээг дэмжих бизнесийн дэвшилтэт шийдэл бүхий үйл ажиллагаа явуулна.

Товч танилцуулга


Өнгөрсөн оны санхүүгийн үзүүлэлтээр Төрийн Банк нь 3.5 их наяд төгрөгийн актив хөрөнгөтэй, өөрийн хөрөнгийн хүрэлцээний зохистой харьцаа, төлбөр түргэн гүйцэтгэх чадвар болон бусад үзүүлэлтээрээ Монголбанкнаас тогтоосон шалгуур үзүүлэлтүүдийг бүрэн хангаж ажиллаж байна. Төрийн Банк нь банкны салбарын зохистой бодлогын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд эрсдэлийг бууруулахад чиглэсэн арга хэмжээг тогтмол авч хэрэгжүүлэн, Монгол Улсын банкны салбарын ТОП 3 банкны нэгээр дахин шалгарч, амжилтаа баталгаажууллаа

Компанийн хөрөнгө

Төрийн эзэмшлийн хувь: 100%
Эзэмшигчийн өмч: 133.9 тэрбум
Нийт хувьцаа: 133900 ширхэг
Хувьцааны үнэ: 1 сая төгрөг

Сүүлийн 4 жилийн эдийн засгийн үзүүлэлт

Үзүүлэлт	2017	2018	2019	2020
Нийт орлого /сая.төг/	312,586.0	352,009.7	408,085.9	406,743.7
Нийт зардал /сая.төг/	300,193.2	350,405.2	387,813.3	376,131.8
Цэвэр ашиг /сая.төг/	12,392.8	1,604.5	20,272.6	30,611.9
Авлага /сая.төг/	14,341.5	10,666.5	10,173.2	14,058.3
Өглөг /сая.төг/	8,019.4	6,791.9	10,540.5	13,160.3
Ажиллагсдын тоо	3738	3853	3894	3954
Цалингийн сан /сая.төг/	39,472.7	40,674.9	45,670.9	54,086.1





МОНГОЛ УЛСЫН
ХӨГЖЛИЙН БАНК

“МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН БАНК” ХХК

Түүхэн замнал

Монгол Улсын Засгийн газар 2010 оны 7 дугаар сарын 20-ны өдөр Монгол Улсын Хөгжлийн банкныг байгуулахаар шийдвэрлэж, 2011.02.10-ны өдөр МУХБ-ны тухай хуулийг баталж, 2011.05.12-ны өдөр албан ёсоор нээлтээ хийж үйл ажиллагаагаа эхлүүлсэн.

Үйл ажиллагааны чиглэл

- МУХБ-нь Монгол улсын эдийн засгийн өсөлтийг дэмжсэн, Монгол Улсын хөгжлийн тэргүүлэх болон стратегийн ач холбогдол бүхий томоохон төсөл хөтөлбөрүүдийг санхүүжүүлэх зорилготой.

Компанийн удирдлага

➤ Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга:
С.Наранцогт

- Гишүүд: Б.Ганбат
Б.Цогбадрах
П.Дорждагва
С.Магнайсүрэн
Н.Батнасан
М.Золжаргал
Р.Мөнхтөр

• Д.Хулан /ТУЗ-ийн нарийн бичиг/

- Гүйцэтгэх захирал: Н.Мөнхсүх
- Дэд захирал: -
- Нягтлан бодогч: Б.Батбаяр

Эрхэм зорилго

Үндэсний үйлдвэрлэл, экспортыг дэмжиж нийгэм эдийн засгийн тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулна.

Товч танилцуулга

Монгол Улсын Хөгжлийн банк 2011.05.12-ны өдөр албан ёсоор нээлтээ хийж үйл ажиллагаагаа эхлүүлсэн бөгөөд Монгол Улсын хөгжлийн томоохон төсөл, хөтөлбөрүүдийг санхүүжүүлэх хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлж, Монгол Улсын хөгжил, дэвшилд чухал үүрэг гүйцэтгэх томоохон төслүүдийг санхүүжүүлэн ажилдаг.

Компанийн хөрөнгө

Төрийн эзэмшлийн хувь: 100
Эзэмшигчийн өмч: 1,000,000,000,000
Нийт хувьцаа: 10,000,000 ширхэг
Хувьцааны үнэ: 100,000 төгрөг

Сүүлийн 4 жилийн эдийн засгийн үзүүлэлт

Үзүүлэлт	2017	2018	2019	2020
Нийт орлого /сая.төг/	287,372	353,601	367,554	308,598
Нийт зардал /сая.төг/	286,361	349,516	365,516	386,525
Цэвэр ашиг /сая.төг/	1,011	4,085	2,038	(77,927)
Авлага /сая.төг/	1,120,078	1,125,592	1,211,402	891,326
Өглөг /сая.төг/	783,757	563,891	248,293	146,741
Ажиллагсдын тоо	199	205	228	130
Цалингийн сан /сая.төг/	5,400	6,961	8,133	8,382
Төсвийн төлбөрт /сая.төг/	-	-	-	-
Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал	-	-	-	-
Хөрөнгө оруулалт /сая.төг/	1,832,338	1,829,566	2,529,158	2,774,920

Хэрэгжиж буй төсөл, хөтөлбөр

МУХБ нь дамжуулан зээлээр 11 хөтөлбөрийн 981 төсөл 295.8 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байна. Шууд санхүүжилтээр 69 төсөл 3,146.3 тэрбум төгрөгийг зээлийн үлдэгдэлтэй байна.

НИЙТ 11 ХӨТӨЛБӨР, 1050 ТӨСӨЛ, 3,442.1 ТЭРБУМ ТӨГРӨГИЙН ҮЛДЭГДЭЛТЭЙ.

Тулгамдаж буй асуудал

- Зээлийн чанарыг сайжруулах.
- Зээлийн эргэн төлөлт тасрах
- Зээлийн барьцаа хөрөнгөөр үүргийн гүйцэтгэл хангуулах боломжгүй
- Зээлийн эргэн төлөлтөөс хамааран Засгийн газраас баталгаа гаргасан эх үүсвэрийн зээлүүд буцаан дуудагдах



VII. “Эрдэнэс Монгол” ХХК төлөөлөл хэрэгжүүлдэг хуулийн этгээд

НЭГДЛИЙН ХҮНИЙ НӨӨЦИЙН МЭДЭЭЛЭЛ

2018 ОНЫ АЖИЛЧДЫН НИЙТ ТОО:



"Эрдэнэс Монгол" ХХК	86
"Багануур" ХК	1123
"Гашуун Сухайтын Авто Зам" ХХК	139
"Мон Атом" ХХК	13
"Эрдэнэс Алт Ресурс" ХХК	10
"Шивээ-Овоо" ХК	562
"Эрдэнэс Ашид" ХХК	1
"Эрдэнэс Метан" ХХК	6
"Эрдэнэс Оюу Толгой" ХХК	17
"Эрдэнэс Стийл" ХХК	5
"Эрдэнэс Ассет Менежмент" ХХК	1
"Эрдэнэс Шивээ Энержи" ХХК	1


ХҮЙСИЙН ХАРЬЦАА:




АЖИЛЛАСАН ЖИЛ:




НАСНЫ АНГИЛАЛ:



“ЭРДЭНЭС МОНГОЛ” ХХК-ИЙН САНХҮҮГИЙН ГОЛ ҮЗҮҮЛЭЛТ



“Эрдэнэс Монгол” ХХК нь 2020 онд **376** тэрбум төгрөгийн нийт орлоготой, **311** тэрбум төгрөгийн нийт зардалтай, **47.1** тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан. Авлага 1,003 тэрбум, нийт өр төлбөр 2,720 тэрбум төгрөгийн үзүүлэлттэй байна.



Энэхүү товхимлыг худалдан борлуулах, хувилан олшруулах, албан бус хэрэгцээнд ашиглахыг хориглоно.

Товхимол эмхэтгэсэн:

Ч.БАТЧИМЭГ (Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн мэргэжилтэн)



It is prohibited to copy and sale this booklet

Compiled by:

Batchimeg.Ch (Specialist, State property Management and Regulation Department, Government Agency for Policy Coordination on State Property, Mongolia)